



МОНГОЛ УЛСАД ГЭМТ ХЭРГЭЭС
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ
АЖЛЫГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛ

МОНГОЛ УЛС ДАХЬ ГЭМТ ХЭРГИЙН ЦАГААН НОМ 2018

WHITE PAPER ON CRIME

ЗАХИАЛАГЧ:



МОНГОЛ УЛСАД ГЭМТ ХЭРГЭЭС
УРЬДЧИЛАН СЭРГИЛЭХ АЖЛЫГ
ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛ

ДЭМЖИГЧ:



НЭЭЛТТЭЙ НИЙГЭМ
ФОРУМ

ГҮЙЦЭТГЭГЧ:



МОНГОЛЫН
КРИМИНОЛОГИЧДЫН
ХОЛБОО

ХАМТРАН АЖИЛЛАСАН БАЙГУУЛЛАГА:



ҮНДЭСНИЙ
СТАТИСТИКИЙН ХОРОО



ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ
ЗӨВЛӨЛ



УЛСЫН ЕРӨНХИЙ
ПРОКУРОРЫН ГАЗАР



ЦАГДААГИЙН
ЕРӨНХИЙ ГАЗАР



ШҮҮХИЙН
ШИНЖИЛГЭЭНИЙ
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН



ШҮҮХИЙН ШИЙДВЭР
ГҮЙЦЭТГЭХ ЕРӨНХИЙ
ГАЗАР



ДОТООД ХЭРГИЙН
ИХ СУРГУУЛЬ

СУДАЛГААНЫ БАГ

Зөвлөх:

Ж.Болдбаатар (Sc.D, проф.)
Б.Бат-Эрдэнэ (Ph.D, проф.)
Д.Зүмбэрэллхам (Ph.D, проф.)
Б.Батзориг (Ph.D, дэд проф.)
Г.Эрдэнэбат
Л.Нямгэрэл
Б.Хишигсайхан

Судалгааны багийн ахлагч:

Б.Мөнхдорж (Ph.D)

Судалгааны багийн гишүүд:

Ч.Нямсүрэн (Ph.D, дэд проф.)
Б.Энхболд (Ph.D, дэд проф.)
Б.Алтансүх (Ph.D)
Г.Оюунболд

М.Цэдэвсүрэн
Ц.Гантулгат
Б.Мөнхсэргэлэн
О.Уулзахжаргал
Ч.Отгонсүрэн
О.Мөнхцэцэг
Б.Ариунтуяа

Практик байгууллагын төлөөлөл:

Ц.Дулмаа (ҮСХ)
Ц.Мандах (Ph.D, ШЕЗ)
Э.Ганцэцэг (ШЕЗ)
Б.Дэлгэрсүрэн (УЕПГ)
П.Батбаатар (ЦЕГ)
С.Энхбаатар (ЦЕГ)
Б.Баяраа (ШШҮХ)
Б.Ганчимэг (ШШГЕГ)
Ш.Баттунгалаг (ШШГЕГ)

ГАРЧИГ

ТОТГО ҮГ	6
ЗӨВЛӨХИЙН ҮГ	7
ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ	8

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ.

МОНГОЛ УЛСЫН 2018 ОНЫ ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

1. Гэмт хэргийн индекс	12
2. Тоон мэдээлэл, статистик	14
3. Дүгнэлт, зөвлөмж	22

ХОЁРДУГААР БҮЛЭГ.

ТОДОРХОЙ ТӨРЛИЙН ГЭМТ ХЭРЭГ

1. Эрүүгийн хуулийн тусгай ангийн аравдугаар бүлэг (Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг)	24
1.1. Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	24
1.2. Хүнийг алах гэмт хэрэг	27
2. Эрүүгийн хуулийн тусгай ангийн арван нэгдүгээр бүлэг (Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг)	30
2.1. Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	30
2.2. Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулах гэмт хэрэг	33
2.3. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг	35
3. Эрүүгийн хуулийн тусгай ангийн арван хоёрдугаар бүлэг (Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг)	37
3.1. Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	37
3.2. Хүчиндэх гэмт хэрэг	40
4. Эрүүгийн хуулийн тусгай ангийн арван гуравдугаар бүлэг (Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг)	42
4.1. Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг	42
5. Эрүүгийн хуулийн тусгай ангийн арван дөрөвдүгээр бүлэг (Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг)	45
5.1. Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг	45
6. Эрүүгийн хуулийн тусгай ангийн арван тавдугаар бүлэг (Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг)	47
6.1. Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	47
7. Эрүүгийн хуулийн тусгай ангийн арван зургадугаар бүлэг (Хүүхдийн эсрэг гэмт хэрэг)	50
7.1. Хүүхдийн эсрэг гэмт хэрэг	50
8. Эрүүгийн хуулийн тусгай ангийн арван долдугаар бүлэг (Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг)	53
8.1. Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	53
8.2. Хулгайлах гэмт хэрэг	57
8.3. Дээрэмдэх гэмт хэрэг	61
8.4. Залилах гэмт хэрэг	64
9. Эрүүгийн хуулийн тусгай ангийн арван наймдугаар бүлэг (Эдийн засгийн гэмт хэрэг)	67
9.1. Эдийн засгийн гэмт хэрэг	67
9.2. Улсын хилээр барааг хууль бусаар нэвтрүүлэх гэмт хэрэг	71
9.3. Мөнгө угаах гэмт хэрэг	73

10.ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН ТУСГАЙ АНГИЙН АРВАН ЕСДҮГЭЭР БҮЛЭГ (Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг)	74
10.1. Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	74
11. Эрүүгийн хуулийн тусгай ангийн хорьдугаар бүлэг (Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг)	78
11.1. Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	78
11.2. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэрэг	82
12. Эрүүгийн хуулийн тусгай ангийн хорин нэгдүгээр бүлэг (Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг)	85
12.1. Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг	85
13. Эрүүгийн хуулийн тусгай ангийн хорин гуравдугаар бүлэг (Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг)	89
13.1. Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	89
13.2. Хуурамч баримт бичиг үйлдэх, ашиглах гэмт хэрэг	92
14. Эрүүгийн хуулийн тусгай ангийн хорин дөрөвдүгээр бүлэг (Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг)	94
14.1. Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг	94
14.2. Хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох гэмт хэрэг	97
15. Эрүүгийн хуулийн тусгай ангийн хорин тавдугаар бүлэг (Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг)	99
15.1. Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг	99
16. Эрүүгийн хуулийн тусгай ангийн хорин зургадугаар бүлэг (Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг)	102
16.1. Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	102
16.2. Цахим мэдээлэлд хууль бусаар халдах гэмт хэрэг	105
17. Эрүүгийн хуулийн тусгай ангийн хорин долдугаар бүлэг (Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг)	107
17.1. Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	107
17.2. Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих гэмт хэрэг	110
18. Эрүүгийн хуулийн тусгай ангийн хорин наймдугаар бүлэг (Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг)	113
18.1. Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг	112
19. Эрүүгийн хуулийн тусгай ангийн хорин есдүгээр бүлэг (Хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг гэмт хэрэг)	115
19.1. Хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг гэмт хэрэг	115

ГУРАВДУГААР БҮЛЭГ.

ГЭМТ ХЭРГИЙН ЗАРИМ ОНЦЛОГ ҮЗҮҮЛЭЛТ

1. Эмэгтэй хүн ба гэмт хэрэг	118
2. Насанд хүрээгүй хүн ба гэмт хэрэг	126
3. Согтуурсан хүн ба гэмт хэрэг	134
4. Мансуурсан хүн ба гэмт хэрэг	137
5. Бүлэглэсэн үйлдэл ба гэмт хэрэг	139
6. Галт зэвсэг ашигласан үйлдэл ба гэмт хэрэг	141
7. Урьд ял шийтгэгдсэн хүн ба гэмт хэрэг	143

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ.

НУТАГ ДЭВСГЭРИЙН ГЭМТ ХЭРЭГ 145

1. Улаанбаатар хот	148
2. Баянгол дүүрэг	154
3. Баянзүрх дүүрэг	159
4. Сонгинохайрхан дүүрэг	164
5. Сүхбаатар дүүрэг	169
6. Хан-Уул дүүрэг	174
7. Чингэлтэй дүүрэг	179
8. Багануур дүүрэг	184
9. Багахангай, Налайх дүүрэг	189
10. Орон нутаг	195
11. Архангай аймаг	201
12. Баян-Өлгий аймаг	206
13. Баянхонгор аймаг	211
14. Булган аймаг	216
15. Говь-Алтай аймаг	221
16. Говьсүмбэр аймаг	226
17. Дархан-Уул аймаг	231
18. Дорноговь аймаг	236
19. Дорнод аймаг	241
20. Дундговь аймаг	246
21. Завхан аймаг	251
22. Орхон аймаг	256
23. Өвөрхангай аймаг	261
24. Өмнөговь аймаг	266
25. Сүхбаатар аймаг	271
26. Сэлэнгэ аймаг	276
27. Төв аймаг	281
28. Увс аймаг	286
29. Ховд аймаг	291
30. Хөвсгөл аймаг	296
31. Хэнтий аймаг	301
32. Бусад нутаг дэвсгэр болон зарим салбар	306
32.1. Иргэний агаарын тээвэр	306
32.2. Төмөр замын тээвэр	307
32.3. Хилийн чанад	308
32.4. Тээврийн прокурорын газар	309
32.5. Нийслэлийн прокурорын газар	310

ТАВДУГААР БҮЛЭГ.

ГЭМТ ХЭРГИЙН СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙГ ОЛОН УЛСАД НИЙЦҮҮЛЭХ ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА БА ТАЙЛАГНАСАН БАЙДАЛ 311

1. Гэмт хэргийн статистикийн үйл ажиллагаанд мөрдөгдөж буй арга зүй, маягт, заавар	312
2. Гэмт хэргийн статистикийн мэдээллийн олон улсын жишигт нийцүүлэх хэрэгцээ, шаардлага	315
3. Гэмт хэргийн статистикийн мэдээллийг олон улсад тайлагнасан байдал (НҮБ-ын Гэмт хэргийн чиг хандлагын судалгаа, 2015-2017 оны байдлаар)	317
4. Дүгнэлт, зөвлөмж	331

ЗУРГААДУГААР БҮЛЭГ.

ХУУЛЬ ЗҮЙН САЛБАРЫН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙГ ҮНЭЛЭХ

ҮЗҮҮЛЭЛТИЙГ ТООЦОХ АРГА ЗҮЙ, ҮР ДҮН

331

- | | |
|---|-----|
| 1. Тогтвортой хөгжлийн талаарх ерөнхий ойлголт | 334 |
| 2. Хууль зүйн салбарын тогтвортой хөгжлийг үнэлэх үзүүлэлтийг тооцох арга зүй, үр дүн | 335 |
| 3. Дүгнэлт, зөвлөмж | 355 |

ДОЛООДУГААР БҮЛЭГ.

ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРЛЫН СТАТИСТИКТ ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

356

- | | |
|---|-----|
| 1. Гэмт хэргийн хохирох явдлын (victimization) өнөөгийн байдал, гэмт хэрэг хохирох шалтгаан нөхцөл, нөлөөлөх хүчин зүйл | 358 |
| 1.1. Гэмт хэрэгт хохирох явдлын тоон үзүүлэлт: бүтэц, хөдөлгөөн | 360 |
| 1.2. Гэмт хэргийн хохирогч: гэмт хэрэгт өртөмтгий эмзэг хохирогчийн онцлог | 360 |
| 1.3. Гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршиг, нөхөн төлөлт | 365 |
| 1.4. Гэмт хэрэгт хохирох эрсдэл: тооцох аргачлал, аюулгүй байдлын зэрэглэл | 369 |
| 1.5. Гэмт хэрэгт хохирохоос урьдчилан сэргийлэх ажил, үр дүн, чиг хандлага | 371 |

НАЙМДУГААР БҮЛЭГ.

МОНГОЛ УЛС ДАХЬ НУУГДМАЛ ГЭМТ ЯВДЛЫН ТҮВШИНГ ТООЦСОН БАЙДАЛ

375

- | | |
|--|-----|
| 1. Нуугдмал гэмт хэргийн түвшинг судлах шаардлага, үндэслэл | 376 |
| 2. Судалгааны арга зүй | 376 |
| 3. Нуугдмал гэмт хэргийн түвшинг тооцсон байдал | 378 |
| 3.1. Гэмт хэргийн чиг хандлагын талаарх төсөөлөл | 378 |
| 3.2. Гэмт хэргээс түгших хандлагын түвшин | 378 |
| 3.3. Гэмт хэрэгт шууд болон шууд бусаар хохирсон байдал | 379 |
| 3.4. Монгол Улс дахь нуугдмал гэмт явдлын түвшинг тооцсон байдал, 2018 | 382 |
| 4. Дүгнэлт | 384 |

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

385

ХАВСРАЛТ

387

Хавсралт 1. Хураангуй хүснэгт **388**

Хавсралт 2. Дэлгэрэнгүй хүснэгт **413**

Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл 2016 оноос Монголын криминологичдын холбоотой хамтран гэмт хэргийн цагаан номыг жил бүр эрхлэн гаргаж, нийтийн хүртээл болгодог уламжлалтай.

Энэ жилийн гэмт хэргийн цагаан ном нь холбогдох байгууллагуудаас ирүүлсэн гэмт хэрэг, зөрчлийн статистик мэдээллийг нэгтгэн, Монгол Улс дахь гэмт хэргийн нөхцөл байдал, түүнтэй тэмцэх ажлын үр дүнг дүгнэх боломж олгохыг зорьсоноороо онцлогтой.

Гэмт хэргийн цагаан номд орсон бүхий л статистик, судалгаан дээр үндэслэн аливаа гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх бодлого үйл ажиллагааг илүү оновчтой зөв төлөвлөх, үр дүнтэй хэрэгжүүлэх, зохион байгуулах нь хууль сахиулах байгууллагын үндсэн үүрэг байх учиртай.

Өнгөрсөн хугацаанд хүн худалдаалах, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтэй холбоотой гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх Үндэсний хөтөлбөрүүд батлагдан хэрэгжиж байгаа билээ. Мөн хууль зүйн салбарын байгууллагуудын хүний нөөц, техник, тоног төхөөрөмж, дэд бүтцийг шинэчлэн, хуульд заасан үүргээ стандартын дагуу хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэх ажилд олон ахиц дэвшил гарч байна.

Гарсан гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох ажлыг эрчимжүүлэхийн сацуу гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг цогц, уялдаа холбоотой, тогтвортой, тасралтгүй зохион байгуулах нь илүү ач холбогдолтой.

Ийм учраас гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хэрэгжүүлэх бүхий л арга хэмжээ нь судалгаа, шинжилгээнд үндэслэсэн, шинжлэх ухаан, техник технологийн орчин үеийн ололт, амжилт, шинэ мэдлэгт суурилсан байх үндсэн зарчимд Гэмт хэргийн цагаан номын агуулга, зорилго бүрнээ нийцнэ гэдэгт илтгэлтэй байна.

Гэмт хэргийн цагаан номыг эрхлэн гаргаснаас хойш түүнийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх ажлын гарын авлага, хэрэглээ болгох арга зүй нэгэнтээ тогтож, хууль зүйн шинжлэх ухааны эрдэмтэн, судлаачдын оролцоо улам нэмэгдэж буйд олзуурхаж буйгаа энэ дашрамд илэрхийлье.

Энэ ажилд оройлон оролцсон Монголын Криминологичдын холбоо, түүний гишүүн эрдэмтэн, судлаачдаас бүрдсэн судалгааны багт гүн талархал илэрхийлж, эрдэм мэдлэг дэлгэрүүлэх, гэмт хэргийн хорт үндсийг таслах ариун үйлсэд нь их амжилтыг хүсье.

Амар амгалан ашид эрхшээж, номын гэрэл гийх болтугай.

МОНГОЛ УЛСАД ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ
АЖЛЫГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА БӨГӨӨД АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА Л.НЯМГЭРЭЛ

ЗӨВЛӨХИЙН ҮГ

Дэлхийн хөгжингүй олон оронд жил бүр эрхлэн гаргадаг гэмт хэргийн цагаан номыг Монгол Улсад нутагшуулах тухай бидний санаачилга биеллээ олж, эдүгээ 3 дахь жилдээ хэвлэгдэн гарч байна.

Өөрийн улсын гэмт хэргийн өнөөгийн нөхцөл байдлыг, тодруулбал, цагдаагийн байгууллагад анх бүртгэгдсэн гомдол, мэдээлэл, гэмт хэргээс прокурор, шүүхийн шатанд эцэслэн шийдвэрлэгдэж, шийдвэр гүйцэтгэх байгууллагад шилжиж буй эрүүгийн болоод зөрчлийн хэргийн урсгал, шийдвэрлэлтийн талаарх мэдээллийг цогц байдлаар агуулсан цагаан номтой болохыг эрмэлзсэн бид бүхний зорилго эрүүгийн эрх зүйн чиглэлээр, тэр дундаа криминологийн чиглэлээр мэргэшсэн олон судлаач, эрдэмтэн багагүй хөдөлмөр, зүтгэлийг шингээж, дэмжигч байгууллагуудын хамтын ажиллагааны үр дүнд уламжлал болж буй нь сайшаалтай.

Өмнө жилүүдэд эрхлэн гаргасан цагаан номуудтай харьцуулахад “Монгол Улс дахь Гэмт хэргийн цагаан ном-2018” нь тодорхой төрлийн гэмт хэргийг эрүүгийн хуулийн тусгай ангийн бүх бүлгийг хамруулсан, цагдаа, прокурор, шүүх, шүүхийн шинжилгээ, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагуудын статистикийн мэдээллийг нэгтгэн харуулсанаараа онцлог. Энэ нь гэмт явдалтай тэмцэх үйл ажиллагааны үр дүнг цогц байдлаар хэмжиж, дүгнэх боломжийг бий болгож байгаа юм.

Тухайн улс, бүс нутгийн гэмт явдлын түвшинг статистикийн хэлээр нийтэд гаргаж тавих нь гэмт хэргийн цагаан номын зорилго, онцлог байдаг. Тухайн тайлант жилийн онцлогоос хамааран нийгэмд анхаарал татаж буй гэмт явдлыг тодруулан судлах, түүнчлэн гэмт явдалтай тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөө, төсөв хөрөнгийг оновчтой зарцуулж буйд криминологийн дүн шинжилгээ хийх байдлаар бичигддэг. Хуулийн байгууллагууд, холбогдох байгууллагаас мэдээлэл, тайлан, эх сурвалжийг ирүүлээгүй, гаргаж өгөөгүй байдлаас шалтгаалан 2018 оны номд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөөнд дүн шинжилгээ хийх хэсгийг оруулж чадаагүй гэдгийг дурдах нь зүйтэй.

Энэхүү номыг эрхлэн гаргах явцад хуулийн байгууллагуудаас гаргаж буй тайлан, мэдээний үнэн зөв байдлыг хангах зорилгоор тэдгээрийн хамтын ажиллагаа, ажлын харилцан уялдааг нэмэгдүүлэх чиглэлээр багагүй санал, санаачилга гаргаж ажилласан бөгөөд бидний санал, хүсэлтийг тухай бүрд нь шийдвэрлэж, шаардлагатай мэдээлэл, арга зүйгээр тусалж, хамтран ажилласан бүх байгууллагад талархал илэрхийлье.

Цаашдаа энэхүү номын агуулга, бүтцийг илүү боловсронгуй болгох, хуулийн байгууллагуудын тайлан, мэдээгээ нэгтгэн дүгнэж буй байдлыг сайжруулах тал дээр Монголын Криминологичдын холбоо, түүний гишүүн эрдэмтэн, судлаачид хамтран ажиллах болно.

МОНГОЛЫН КРИМИНОЛОГИЧДЫН ХОЛБООНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ
Г.ЭРДЭНЭБАТ

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ

- ААН** Аж ахуйн нэгж
- АТГ** Авлигатай тэмцэх газар
- АТХХАБАЖЗГХ** Авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих гэмт хэрэг
- БГХ** Бүртгэгдсэн гэмт хэрэг
- ГХ** Гэмт хэрэг
- ГХМБТГ** Гэмт хэрэг, мансууруулах бодистой тэмцэх газар
- ЕЭЗК** Европын эдийн засгийн комисс
- ЗХАБТХ** Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль
- МХХ** Монголын хуульчдын холбоо
- МША** Мөрдөн шалгах ажиллагаа
- НААСЭГХ** Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг
- НПГ** Нийслэлийн прокурорын газар
- НТАХЯ** Нийтэд тустай ажил хийлгэх ял
- НҮБ** Нэгдсэн Үндэстний Байгууллага
- ОНАБАСЭГХ** Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг
- ӨНЭЗС** Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа
- ПБ** Прокурорын байгууллага
- СК** Статистикийн комисс
- ТПГ** Тээврийн прокурорын газар
- ТТАХ** Төрийн тусгай албан хаагч
- ТҮАХ** Төрийн үйлчилгээний албан хаагч
- ТХЗ** Тогтвортой хөгжлийн зорилт
- ТХҮБ** Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал
- УЕПГ** Улсын ерөнхий прокурорын газар
- ҮАБЭГХ** Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг
- ҮСХ** Үндэсний статистикийн хороо
- ҮЭ** Үйлдвэрчний эвлэл
- ХАБТХАЖЭГХ** Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг
- ХБМБ** Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт
- ХБМБА** Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаа
- ХБОЭГХ** Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг

- ХБЭЧХБЭГХ** Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг
- ХЗДХЯ** Хууль зүй, дотоод хэргийн яам
- ХС** Хүүхдийн сан
- ХТАБЭТЭГХ** Хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг гэмт хэрэг
- ХХУТЭЭЧЭГХ** Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг
- ХХЧБЭЭГХ** Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг
- ХЧААХ** Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ
- ХЭМХБЭГХ** Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг
- ЦБ** Цагдаагийн байгууллага
- ЦЕГ** Цагдаагийн ерөнхий газар
- ЦМАБЭГХ** Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг
- ЦМХБХГХ** Цахим мэдээлэлд хууль бусаар халдах гэмт хэрэг
- ШБ** Шүүх байгууллага
- ШЕЗ** Шүүхийн ерөнхий зөвлөл
- ШҮХ** Шинээр үүссэн хэрэг
- ШШГБ** Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага
- ШШГЕГ** Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар
- ЭБАТ** Эрх бүхий албан тушаалтан
- ЭХ** Эрүүгийн хууль
- ЭХ-р** Эрүүгийн хуулиар
- ЭХТА** Эрүүгийн хуулийн тусгай анги
- ЭХҮ-ж** Эрүүгийн хэрэг үүсгэж
- ЭХХША** Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа
- SDG** Sustainable Development Goals
- UNODC** United Nations Office on Drug and Crime

НЭГДҮГЭЭР
БҮЛЭГ

МОНГОЛ УЛСЫН
2018 ОНЫ ГЭМТ
ХЭРГИЙН НӨХЦӨЛ
БАЙДАЛД ХИЙСЭН ДҮН
ШИНЖИЛГЭЭ



МОНГОЛ УЛСЫН 2018 ОНЫ ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Энэхүү бүлгийг боловсруулахдаа өмнөх онуудад гаргасан “Гэмт хэргийн цагаан ном”-ны эхний буюу тойм бүлэгт хэрэглэж байсан дүн шинжилгээ хийх аргачлалын дагуу хийхийг зорьсон болно. Гэмт хэргийн мэдээллийн санд дүн шинжилгээ хийхдээ тоон болон чанарын судалгааны арга зүйг хослуулан асуудлын мөн чанарыг бодитоор тодорхойлохыг эрмэлзэв. Бидний судлах зүйл нь зөрчил, гэмт хэргийн статистик өссөн, буурсан, эсхүл тогтмол хэмжээнд байгаа шалтгааныг нээн илрүүлэх зорилготой тул зөрчлийн болон эрүүгийн процессын дэс дарааллаар, хууль, эрх зүйн орчин, тоон мэдээ гаргах дүрэм, журам болон практикт гарч буй хүндрэл бэрхшээлээр хамаарал, харьцааг тодорхойлов.

Эрүүгийн хууль тогтоомжийн шинэтгэлээс хамаараад гомдол, мэдээлэл, гэмт хэрэг, зөрчлийг бүртгэх, статистик гаргах журмыг тодорхой хугацаанд өөрчлөх, түүний нөлөөллийг судлан үзэх боломж хомс байгаа бөгөөд 2019 онд Монгол Улсын Их Хурлаас Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар төлөвлөжээ. Тухайлбал, уг нэмэлт, өөрчлөлтөд гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийг шалгах хугацааг сунгах, хөөн хэлэлцэх хугацааг өөрчлөх зэрэг асуудал хөндөгдөж байгаа бөгөөд энэ нь гэмт хэргийн статистик үзүүлэлтэд шууд нөлөөлөх хүчин зүйлс болно. Хэрэв Эрүүгийн хууль тогтоомжийн дээрх нэмэлт, өөрчлөлтийн төслүүд батлагдан хэрэгжиж эхэлвэл 2019-2020 оны гэмт хэргийн статистик үзүүлэлтэд шууд нөлөөлөх бөгөөд энэ нь гэмт хэргийн шалтгаан, нөхцөлөөс хамаараагүй гэсэн урьдчилсан таамаглалыг дэвшүүлж байна.

1. ГЭМТ ХЭРГИЙН ИНДЕКС

Дэлхий дахинд хүлээн зөвшөөрөгдсөн арга хэрэгслээр гэмт хэргийн индексийг тодорхой шалгуур үзүүлэлтээр байгаа баримт мэдээлэлд тулгуурлан гаргадаг.¹ Энэхүү гаргасан жагсаалтаар тухайн улсын гэмт хэргийн нөхцөл байдал, аюулгүйн түвшинг үнэлдэг ба улс орон бүрд гэмт хэргийн индексийг өөр өөрөөр тооцож хэрэглэдэг. Дээрх веб сайт нь сайт хэрэглэгчдийн дунд явуулсан судалгаагаар үндэслэн гаргадаг болно. Эдгээр судалгааны асуулгууд нь криминологийн шинжлэх ухааны болон улс орнуудын албан ёсны олон судалгаатай арга зүйн хувьд ижил байна.

Судалгаанд оруулсан бүх зүйл нь [-2, +2] мужийн тоонд хадгалагдаж, -2 нь сөрөг утгатай, +2 нь эерэг утгатай байх ба дундаас их хэмжээний өгөгдөл оруулж буй оролцогчдоос оруулж мэдээллийн үнэн зөв эсэхийг шүүдэг байна.

Судалгааны үр дүнг хэрэглэгчдэд ойлгоход хялбар байлгахын тулд хэмжилтийн утгыг [0-100] оноогоор ашигладаг. Одоо хэрэглэж буй индексийг (байнга шинэчлэгддэг) үүсгэхийн тулд нийт 36 сар хүртэлх өгөгдлийг ашигладаг ажээ. Гэмт хэргийн индекс гэдэг нь тухайн хотод эсвэл тухайн улсад гарсан нийт гэмт хэргийн түвшинг илэрхийлдэг. Бид гэмт хэргийн түвшинг 20-иос доогуур, 20-40 хүртэлх гэмт хэргийн түвшин бага, 40-ээс 60 хүртэлх гэмт хэргийн түвшин дунд, 60-80-ын хооронд үйлдэгдсэн гэмт хэргийн түвшин их, эцэст нь гэмт хэргийн түвшин 80-аас дээш өндөр гэж тооцдог.

¹ https://www.numbeo.com/crime/indices_explained.jsp

Rank	Country	Crime Index
1	Venezuela	84.86
2	Papua New Guinea	80.26
3	South Africa	77.02
4	Honduras	75.84
5	Afghanistan	73.26
6	Trinidad and Tobago	73.15
7	Brazil	69.48
8	El Salvador	68.63
9	Namibia	68.14
10	Syria	66.91
11	Jamaica	65.26
12	Bangladesh	64.98
13	Puerto Rico	64.75
14	Nigeria	64.64
15	Peru	64.58
16	Kazakhstan	64.23
17	Argentina	62.96
18	Kenya	62.38
19	Libya	61.26
20	Malaysia	60.66
21	Dominican Republic	60.62
22	Fiji	60.52
23	Tanzania	59.83
24	Somalia	58.74
25	Mongolia	57.76
26	Uganda	56.47
27	Guatemala	56.05
28	Costa Rica	55.77
29	Algeria	54.41

Аюулгүй байдлын индекс нь нөгөө талаар гэмт хэргийн индексээс эсрэг утгатай ойлголт бөгөөд хэрэв хот аюулгүй байдлын индекс өндөр бол аюулгүй гэж тооцогддог. Гадаадын зарим орон нь нэг хүнд ногдох гэмт хэргийн тоо баримтыг үндэслэн нарийвчилсан статистик гаргадаг. Одоогийн байдлаар гэмт хэргийн индексийг тооцоолох бодит томъёонд өөрчлөлт байнга орж байгаа нарийн төвөгтэй эмпирик томъёог ашиглаж байна. Java програмчлалын хэл дээр бичигдсэн томъёогоор гаргадаг.

Гэмт хэргийн индексийн дагуу зарим улс орон гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх стратеги, төлөвлөлтөө боловсруулдаг бөгөөд НҮБ-аас гаргасан зөвлөмж², аргачлалыг ашигладаг байна.

² https://www.unodc.org/pdf/criminal_justice/Handbook_on_Crime_Prevention_Guidelines_-_Making_them_work.pdf

2. ТООН МЭДЭЭЛЭЛ, СТАТИСТИК

2.1. Бүртгэгдсэн гомдол, мэдээлэл

Монгол Улсын хэмжээнд 2018 онд иргэн, хуулийн этгээдээс 198130 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 70167 буюу 35.4% нь гэмт хэргийн шинжтэй, 127963 буюу 64.6% нь зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл байна.

Утга	Нийт гомдол, мэдээлэл	Үүнээс гэмт хэргийн шинжтэй		Үүнээс зөрчлийн шинжтэй	
2017 он	192618	78050	40.5%	113128	58.8%
2018 он	198130	70167	35.4%	127963	64.6%

Өмнөх оныхоос нийт цагдаагийн байгууллагад хандсан гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийн тоо 5500 орчмоор өссөн бөгөөд Эрүүгийн хууль тогтоомжийн шинэтгэлийн явцад буюу 2017 оны 7 дугаар сарын 1-нээс хойш бүртгэлийн системийн өөрчлөлтөөс хамаарч өсөж, буурсан байж болох талтай. Харин 2018 оны эхнээс гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй гомдол мэдээллийг мэдээллийн системд ялгаж бүртгэж эхэлснээр бодитой гарч эхэлж байна гэж дүгнэж болохоор байна.

Тухайлбал, Гэр бүлийн хүчирхийлэл нь нуугдмал түвшинд буюу “хаалттай хаалганы цаана үйлдэгддэг” бөгөөд цагдаагийн байгууллагад бүртгэгдсэнээр нь авч үзвэл 2018 онд 18507 гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой дуудлага мэдээлэл ирсэн байна. Энэ нь цагдаагийн байгууллагад хандсан зөрчил, гэмт хэргийн шинжтэй нийт гомдол мэдээллийн 10,2% бөгөөд хамгийн их гардаг гомдол, мэдээлэл, дуудлагын эхний 4-рт орж байна. Цаашид ч энэ үзүүлэлт хэвээр хадгалагдах төдийгүй хулгайлах, бусдын биед гэмтэл учруулах, согтуугаар танхайрах дуудлагууд нийт гомдол, мэдээллийн 60 орчим хувийг эзэлсэн хэвээр байх дүр төрх ажиглагдаж байна.

Гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй гомдол мэдээллийн өөрчлөлтийн харьцаа 2017-2018 онд 5-6% хэлбэлзэж байгаа бөгөөд энэ нь хулгайлах, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх, хүний биед халдаж зодох зэрэг зөрчил, гэмт хэргийн шинж адилхан учраас хэрхэн бүртгэснээс хамаарч урвуу хамааралтай байдаг гэж цагдаагийн нэгж, анхан шатны зарим алба хаагч өгүүлж³ байв.

Үзүүлэлт	Нийт хүлээн авсан ГХТГМ			Хэрэг үүсгэхээс татгалзсан			Нийт гомдлоос үүсгэхээс татгалзсаны эзлэх хувь		Хэрэг үүсгэсэн			Нийт гомдлоос хэрэг үүсгэсний эзлэх хувь		
	он	2017	2018	Өөрчлөлт	2017	2018	хувь	2017	2018	2017	2018	хувь	2017	2018
Нийт		70467	70354	0%	38019	22674	-40%	54%	32%	32448	47672	47%	46%	68%
Улаанбаатар хотын хэмжээнд		52936	52796	0%	30027	18045	-40%	57%	34%	22909	34751	52%	43%	66%
Орон нутгийн хэмжээнд		17531	17558	0%	7992	4629	-42%	46%	26%	9539	12921	35%	54%	74%

³ Гэмт хэргийн мэдээллийн санд дүн шинжилгээ хийхдээ Улаанбаатар хотын нийт 6 дүүргийн 6 алба хаагчтай ярилцлагын судалгаа явуулсан болно. Суд.

Прокурорын байгууллагын гаргасан мэдээнээс үзвэл эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах тохиолдол 40% буурч, эрүүгийн хэрэг үүсгэн шалгасан тохиолдол 47% нэмэгдсэн байна. Эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзаж шийдвэрлэх явдал ийн буурсан нь хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, гэмт хэрэг мөн эсэхийг мөрдөн шалгаж нотлох арга барилд шилжсэнтэй холбон тайлбарлаж болно.

2.2. Бүртгэгдсэн гэмт хэрэг

Улсын хэмжээгээр 2018 онд 36.2 мянган гэмт хэрэг бүртгэгдсэн нь 2017 оноос 3961(12.3%)-ээр өссөн байна. Өмнөх оноос нийт гэмт хэрэг өсөхөд залилах гэмт хэрэг 2376 (79.3%), хулгайлах гэмт хэрэг 1202 (9.8%), хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 322 (3.7%), дээрэмдэх гэмт хэрэг 264 (21.4%), хөрөнгө завших гэмт хэрэг 193 (52.3%), хүчиндэх гэмт хэрэг 143 (38.0%)-аар өссөн нь голлон нөлөөлжээ.

Гэмт хэргийн ангиллаар өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2018 онд хөнгөн гэмт хэрэг 36.9%, хүнд гэмт хэрэг 20.4% тус тус өссөн үзүүлэлттэй байна. Гэмт хэргийн ангиллын хувьд хөнгөн гэмт хэрэг буурахад хүнд хэрэг өсдөг, эсхүл адилхан хэмжээгээр өсдөг зүй тогтол хэвээр байна. Мөрдөн шалгах эрх бүхий байгууллагаас гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр зохион байгуулсан үйл ажиллагаа, арга хэмжээ тухайн онд илрүүлсэн гэмт хэрэг нь өсөлт, бууралтад шууд нөлөөлжээ. Тухайлбал “нэг хором” гэх мэт богино хугацааны арга хэмжээ нь зарим сард гэмт хэргийн гаралт буурахад нөлөөлсөн бол мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ нь гэмт хэргийн илрүүлэлтийг нэмэгдүүлж, улмаар энэ төрлийн гэмт хэрэг өссөн тоон мэдээтэй гарсан байна.

Прокурорын байгууллагын 2018 оны тоон мэдээнээс үзвэл 47672 эрүүгийн хэрэг үүсгэн шалгасан гэх ба цагдаагийн байгууллага бүртгэсэн хэргээс 11 мянгаар илүү байна. Энэ нь хэргийн үйлдэл бүрд эрүүгийн хэргийн дугаар авах, эсхүл хэргийг нэгтгэх тусгаарлахтай холбоотойгоор прокурорын гаргасан шийдвэрийн тоо гэдгийг анхаарвал зохино.

Гэмт хэргийн тархалт, өсөлт бууралт

Улсын хэмжээнд гарсан гэмт хэргийн 70.8%-ийг Улаанбаатар хотод үйлдэгдсэн гэмт хэрэг эзэлж байгаа бөгөөд сүүлийн гурван жилийн дундаж харьцангуй тогтвортой байна. Нийт гэмт хэргийн 29,2%-ийг орон нутагт үйлдэгдсэн гэмт хэрэг эзэлж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад хотын статустай болон хүн амын илүү аймгуудын гэмт хэргийн гаралтын түвшинд төдийлөн өөрчлөлт ороогүй байна.

Үзүүлэлт	Улсын хэмжээнд		Улаанбаатарт		Орон нутагт	
	2017 он	2018 он	2017 он	2018 он	2017 он	2018 он
Тоо	32259	36620	21947	25652	10273	10504
Өсөлт, бууралт	12,3%		16,9%		2,2%	

Улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргээс үзвэл 16-аас дээш насны 10000 хүн тутамд 169 гэмт хэрэг оногдож байгаа бөгөөд урьд оныхоос өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 4000-аар нэмэгджээ. Хулгайлах гэмт хэргийн хувьд гомдол, мэдээллийг шалгах хугацаанд эд хөрөнгийн үнэлгээ хийлгэж амждаггүй, зайлшгүй хэрэг бүртгэлтийн хэрэг нээж шалгадаг тул гэмт хэргийн өсөлтөд тодорхой хэмжээгээр нөлөөлдөг байна.

Эрүүгийн хуульд шинээр тусгасан зарим бүлэг тухайлбал, Хүний халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 2017 онд 71 гарч байсан бол 2018 онд 115 тохиолдол бүртгэгдсэн байна. Иргэдийн эрх зүйн мэдлэг, ухамсар дээшлэхийн хэрээр ялгаварлан гадуурхах, заналхийлэх тохиолдолд гомдол гаргаж, эрхээ хамгаалуулах тохиолдол нэмэгдэж байгаа нь эерэг талтай юм.

Тухайн онд хэдийгээр гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг буурсан мэт харагдаж байгаа ч гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж хөнгөн, хүндэвтэр, хүнд гэмтэл учруулах өссөн байна. Тухайлбал, Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой гэмт хэргийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн бүлгээр нь авч үзвэл 2018 онд бүртгэгдсэн тухайн гэмт хэргийн 12 буюу 1.1% нь Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг, 998 буюу 93.3% нь Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, 47 буюу 4.4% нь Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, 5 буюу 0.5% нь Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг, 7 буюу 0.6% нь Хүүхдийн эсрэг гэмт хэрэг, 1 буюу 0.1% нь бусад төрлийн гэмт хэрэг тус тус эзэлж байна.

№	Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн хэрэг		Өсөлт, бууралтын хувь	Нийт гэмт хэрэгт эзлэх хувь
		2017 он	2018 он		
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг Үүнээс: Хүнийг алах	721 189	714 192	-1.0 1.6	2.0 0.5
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг Үүнээс: Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	8812 223	9134 210	3.7 -5.8	25.2 0.6
3	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг Үүнээс: Хүчиндэх	573 376	621 519	8.4 38.0	1.7 1.4
4	Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг	71	115	62.0	0.3
5	Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг	29	6	-79.3	0.02
6	Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	31	33	6.5	0.1
7	Хүүхдийн эсрэг гэмт хэрэг	15	21	40.0	0.1
8	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг Үүнээс	18176	22468	23.6	62.0
	Хулгайлах	11321	12328	11.1	34.0
	Залилах	2996	5372	78.1	14.8
	Дээрэмдэх	1233	1497	25.8	4.1
	Мал хулгайлах	901	1096	14.8	3.0
9	Эдийн засгийн гэмт хэрэг	287	242	-15.7	0.7
10	Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	34	99	2.9 дахин	0.3
11	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	1069	314	-70.6	0.9
12	Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг	125	196	56.8	0.5
13	Авлигын эсрэг гэмт хэрэг	150	362	2.4 дахин	1.0
14	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	262	237	-9.5	0.7
15	Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг	330	366	10.9	1.0
16	Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг	-	3	-	0.01
17	Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	44	42	-4.5	0.1
18	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг Үүнээс: Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих	1525 1291	1231 1215	-19.3 -5.9	3.4 3.4
19	Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг	5	15	3.0 дахин	0.04
20	Хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг гэмт хэрэг	-	1	-	0.0

Цаашид ч Монгол Улсад гарч байгаа хулгайлах, залилах, дээрэмдэх, хүний эрүүл мэндэд санаатай халдаж хөнгөн, хүндэвтэр, хүнд хохирол учруулах, зам, тээврийн хөдөлгөөний аюулгүй байдлын журмын эсрэг гэмт хэргүүд нийт гэмт хэргийн үнэмлэхүй массыг эзэлсэн хэвээр байх бөгөөд хэлбэрийн бүрэлдэхүүнтэй тодорхойлогдсон авлига албан тушаалын, хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг өсөн нэмэгдэх төлөвтэй байна. Гэмт хэргийн цагаан номыг энэ бүлгийг боловсруулахдаа 2017 оныг 2018 онтой харьцуулахад хүндрэлтэй байсан төдийгүй 2017 оны мэдээг тухайн үед үйлчилж байсан 2002 оны Эрүүгийн хууль, 2015 оны Эрүүгийн хуульд заасан гэмт хэргээр гэж хоёр янзаар гаргасан байна. Үүнээс цаашид 2018 оныг нөхцөл байдал, статистикийг 2019 онтой харьцуулан судлахад дээр дурдсан бэрхшээл арилж, харьцуулалт нь илүү бодитой гарна гэж үзэж байна.

Эрүүгийн хууль тогтоомжийн шинэтгэлийн явцад хэрэг бүртгэлтийн хэргийг гэмт хэрэг гэж тооцон гэмт хэргийн тоон мэдээ гаргаж байгааг анхаарах, илрүүлэлтийг тооцох аргыг шинэчлэх талаар урьд оны цагаан номд өгсөн зөвлөмж шийдвэрлэгдээгүй хэвээр байв. Жишээ нь: Гэмт хэргийн илрүүлэлт улсын хэмжээнд 36.0%-тай байгаа нь өмнөх оны мөн үеэс 0.3 нэгжээр өсчээ. Хэлбэрийн бүрэлдэхүүнтэй байхаар заасан зарим гэмт хэрэг тухайлбал, Авлига, албан тушаалын гэмт хэрэг урьд оныхоос 2.4 дахин нэмэгдсэн. Цэргийн салбарт гарсан гэмт хэргүүд тухайн онд дуулиан үүсгэж амиа хорлосон, дэглэлт дарамтын улмаас амь насаа алдсан гэх хэргүүдийг анхааран шалгаж энэ тоо /5 байсан нь 15 болсон/ 3 дахин өссөн дүнтэй гарчээ.

Гэмт хэрэг үйлдсэн газар

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад: Олон нийтийн газарт үйлдэгдсэн хэрэг 393 буюу 8.6%, төрийн бус байгууллагад 39 буюу 14.7%, аж ахуйн нэгж, байгууллагад 662 буюу 23.4%, нийтийн тээвэрт 73 буюу 22.5%, гудамж талбайд 1402 буюу 22.0%, төрийн байгууллагад 314 буюу 56.3%, бусад газарт 1383 буюу 33.2%-иар тус тус өсч, гэр орон сууцанд үйлдэгдсэн хэрэг 35 буюу 0.3%, авто замд 270 буюу 18.2%-иар тус тус буурсан байна.

Гэмт хэрэгт холбогдсон хүн, хэрэг бүртгэлт

Нийт 16389 хүн шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 9.6%-иар буурсан. Холбогдогчдын 2218 буюу 13.5%-ийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 12.4%-иар, 14171 буюу 86.5% нь эрэгтэй хүн байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 9.2%-иар, 956 буюу 5.8%-ийг хүүхэд эзэлж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 10.3%-иар тус тус буурсан байна.

№	Үзүүлэлт	2017	2018	Өсөлт, бууралт
1	Нийт шалгагдсан хүн	18131	16389	-9,6%
2	Эрэгтэй	15599	14171	-9,2%
3	Эмэгтэй	2532	2218	-12,4%
4	Хүүхэд	1066	956	-10,3%

Хэрэг бүртгэлтийн 33943 хэрэг нээн шалгасан өмнөх оны мөн үетэй харьцуулбал 9090 хэрэг буюу 36.6%-иар, үүнээс 12207 хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 3351 буюу 37.8%-иар тус тус өсчээ. Өөрөөр хэлбэл эрүүгийн хэргийг гол төлөв хэрэг бүртгэлтээр шалган, шийдвэрлэж гэмт хэрэг мөн эсэхийг нотолсны үндсэн дээр мөрдөн байцаалт явуулж байгаа учраас гэмт хэргийн тоо өссөн боловч гэмт хэрэгт холбогдон шалгагдсан хүний тоо буурах үндсэн шалтгаан болсон байна.

Гэмт хэргийн хохирогч, хохирол

Гэмт хэргийн улмаас 33566 хүн, 57 хуулийн этгээд хохирч, үүнээс 934 хүн нас барж, 9283 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал, нас барсан хүн 195 буюу 17.3%, гэмтсэн хүн 1230 буюу 11.7%-иар тус тус буурсан байна.

Хохирогч бүгд		Иргэн		Үүнээс				Хуулийн этгээд		Учирсан хохирол бүгд (сая.төг)		Нөхөн төлүүлсэн (сая.төг)	
				Нас барсан		Гэмтсэн							
2017	2018	2017	2018	2017	2018	2017	2018	2017	2018	2017	2018	2017	2018
37259		37173	33566	1129	934	10513	9283	86	57	198,07	193.3	74.5	32,4
										тэрбум	тэрбум	тэрбум	тэрбум

Гэмт хэргийн улмаас учирсан хохирол 2018 онд 193.3 тэрбум төгрөг, нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ 32.4 тэрбум төгрөг болж, өмнөх оноос учирсан хохирол 4.8 (2.4%) тэрбум төгрөгөөр, нөхөн төлүүлсэн хохирол 42.1 (56.5%) тэрбум төгрөгөөр буурсан байна. Эрүүгийн хуулийн хэрэгжилтийн явцад хохирол нөхөн төлүүлэлт ийнхүү буурсан нь Эрүүгийн хуульд хөнгөн ангиллын 33 гэмт хэрэгт хорих ялыг хасч, яллагдагчаас эдгээр хэргийн хохирол, хор уршгаа барагдуулсан тохиолдолд тэнсэх боломжгүй болгосон байна.

Өөрөөр хэлбэл, нийтлэг гардаг хөнгөн ангиллын 33 гэмт хэргийг тэнсэх боломжгүй болсон учраас яллагдагч, шүүгдэгчээс хохирлоо барагдуулах үзүүлэлт буурсан байна. Ялын үндсэн шинж болох хохирол хор уршгаа барагдуулсан тохиолдолд тэнсэх зохицуулалтыг цаашид илүү тодорхой болгохгүй бол гэмт хэргийн улмаас учруулсан хохирлоо нөхөн төлөх явдал буурах хандлагатай байна. Түүнчлэн гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг тоолох, зогсоох, тасалдах талаар Эрүүгийн хуульд заасан зохицуулалтыг илүү тодорхой болгохгүй бол хэргийн шийдвэрлэлтийг удаашруулах, олон дахин хүсэлт гаргах замаар хугацаа хожиж гэмт хэргийн улмаас учруулсан хохирол, хор уршгаа төлөхгүйгээр хэргийг хэрэгсэхгүй болгуулах хандлага ажиглагдав.

Эрүүгийн хэргийн шийдвэрлэлт, прокурорын хяналт:

Прокурорын байгууллагын тоон мэдээнээс үзвэл эрүүгийн хэргийг түдгэлзүүлэх тоо тасралтгүй буурч шүүхэд шилжүүлсэн хэргийн 50 гаруй хувиар нэмэгдсэн байна. Эрүүгийн хууль тогтоомж хэрэгжиж эхэлснээс мөрдөн шалгах эрх бүхий байгууллага, мөрдөгч, прокурорын байгууллага, хяналтын прокурорын үйл ажиллагаа харьцангуй тогтворжсон тул хэргийн шийдвэрлэлт сайжирсан үзүүлэлттэй гарчээ.

Нийт ХБМБ явуулсан хэрэг		Тухайн жил шинээр үүссэн хэрэг		Шийдвэрлэлт									
				Хэрэг бүртгэлтийг хаасан		Нэгтгэгдсэн		Хэрэгсэхгүй болгосон		Түдгэлзүүлсэн		Шүүхэд шилжүүлсэн	
2017	2018	2017	2018	2017	2018	2017	2018	2017	2018	2017	2018	2017	2018
51555	78494	35859	51700	6359	22951	1687	3801	9079	612	122	64	8209	13085

Тухайн онд эрүүгийн хэргийг нэгтгэх тохиолдол 2 дахин нэмэгдсэн бол хэрэгсэхгүй болгосон нийт хэрэг 12 дахин багасжээ. Энэ нь Эрүүгийн хууль хэрэгжих явцад зарим гэмт хэргийг гэмт хэрэгт тооцохоо больсон, хөөн хэлэлцэх хугацаа дууссан зэрэгтэй холбоотойгоор өмнөх онуудад хэргийн үлдэгдлийг шахаж шийдвэрлэснээс хамаарсан байна. Цаашид хэргийг хэрэгсэхгүй болгох тохиолдол 2018 оны тоон мэдээнээс өсөн нэмэгдэх дүр зураг ажиглагдаж байна.

Үлдэгдэл хэрэг				Тухайн жил үүссэн хэрэг дэх яллагдагчийн тоо	
Хэрэг бүртгэлтийн үлдэгдэл		Мөрдөн байцаалтын үлдэгдэл		2017	2018
2017	2018	2017	2018	2017	2018
24466	36446	1704	1612	16704	16279
2018	29938	1160	1021	9391	9023

Прокурорын хяналтын явцад мөрдөн байцаах ажиллагаанд үлдэгдэл хэрэг өмнөх оныхоос буурч, харин хэрэг бүртгэлтийн хэрэг 12 мянгаар нэмэгдсэн байна. Энэ нь дээр дурдсаны дагуу гэмт хэрэг илрүүлэх бүхий л ажиллагааг явуулахдаа хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, нотлох баримтыг цуглуулж, сайтар нотолсон гэж үзсэний дараа мөрдөн байцаалтын хэрэг нээж байгаатай холбоотой аж. Мөн прокурорын зүгээс хүнийг буруутгах хангалттай үндэслэл тогтоогдсон гэж үзсэн тохиолдолд мөрдөн байцаалтын хэрэг нээж байгаа нь дээрх үзүүлэлтэд нөлөөлжээ.

Шүүх:

Анхан шатны шүүхүүд 2018 онд нийт 17734 хүн, 4 хуулийн этгээдэд холбогдох 14207 эрүүгийн хэрэг хүлээн авснаас 1191 хүнд холбогдох 686 хэргийг прокурорт буцааж, 53 хүнд холбогдох 35 хэргийг түдгэлзүүлж, 310 хүнд холбогдох 133 хэргийг харьяаллын дагуу шилжүүлж, 319 хүнд холбогдох 150 хэргийг хэрэгсэхгүй болгож, 112 хүнд холбогдох 62 хэргийг цагаатгаж, нийт 12551 эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэж, 14925 хүнийг гэм буруутайд тооцож, үүнээс 2040 хүнийг хорих ял оногдуулахгүйгээр тэнсэж, 52 хүнийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлж, 12366 хүнийг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож, ял шийтгэл оногдуулсан бөгөөд тайлант хугацааны эцэст 802 хэргийн үлдэгдэлтэй байна.

Өнгөрсөн онтой харьцуулбал хянан шийдвэрлэсэн эрүүгийн хэрэг 42%-иар, ял шийтгүүлэгчдийн тоо мөн 37.1%-иар тус тус өссөн дүнтэй байна. Энэ нь Эрүүгийн хууль /2015 он/ шинэчилсэн найруулга, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль /2017 он/ 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжиж гэмт хэрэг тус бүрт ял оногдуулж, шийдвэрлэдэг болсон бөгөөд 2018 онд эдгээр хууль бүтэн жилийн хугацаанд хэрэгжиж эхэлсэн анхны жил болсонтой холбоотойгоор хянан шийдвэрлэсэн хэрэг, ял шийтгүүлсэн хүний тоо өсөлттэй гарахад нөлөөлсөн гэж дүгнэсэн байна.

Бүртгэгдсэн зөрчил:

Улсын хэмжээнд цагдаагийн байгууллагаас нийт 1698178 зөрчил шалгаж, 1687231 зөрчлийг шийдвэрлэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 360214 буюу 27.1%-иар өссөн үзүүлэлттэй байна. Өмнөх онд зөрчлийн төрлөөр тоон мэдээ гаргаагүй учраас 2018 онтой харьцуулах боломжгүй байна. Зөрчлийн тоон мэдээ цаашид ч өсөх төлөвтэй байгаа бөгөөд Зөрчлийн хуулийн талаар нийт иргэд сөрөг ойлголттой, хуулийг хэрэгжүүлэхгүй байх хандлага давамгайлж байна. Хэдий ийм ч 1,500,000-аас илүү хүн амтай Улаанбаатар хотод замын хөдөлгөөний тухай хууль, дүрэм зөрчих, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх, хулгайлах гэсэн зөрчлүүд хамгийн их гарч, архи дан согтуурахтай тэмцэх тухай хууль болон утаат тамхины тухай хууль зөрчих зөрчлүүд нэмэгджээ. Цаашид зөрчлийн тоо мэдээ, нарийвчлан гарч эхэлж байгаа бөгөөд энэ нь тухайн салбарын зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөх, зөрчлийг таслан зогсооход ач холбогдолтой.

Нийт бүртгэгдсэн зөрчлийн 1589381 буюу 93.7%-ийг замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих, 42842 буюу 2.5%-ийг олон нийтийн газарт зүй бусаар биеэ авч явах, 5821 буюу 0.3%-ийг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, 60134 буюу 3.5%-ийг бусад зөрчил эзэлж байна.

Зөрчил гаргасан 1649704 иргэн, 448 хуулийн этгээдийг 60.3 тэрбум төгрөгөөр торгох, 10981 хүнийг баривчлах, 26098 хүнийг торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл тус тус ногдуулжээ.

Улсын хэмжээнд нийт 85840 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 657 буюу 0.8%-иар буурсан байна.

Зөрчлийн тухай хуулийн зүйл, заалт	Бүртгэгдсэн зөрчил	Холбогдогч хүн
НИЙТИЙН ХЭВ ЖУРАМ, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЭСРЭГ ЗӨРЧИЛ	73987	66630
5.1 дүгээр зүйл.Олон нийтийн газарт зүй бусаар биеэ авч явах	49826	49979
5.2 дугаар зүйл.Танхайрах	6379	5710
5.3 дугаар зүйл.Хүний биед халдах	8088	7084
5.4 дүгээр зүйл.Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих	5827	82
5.5 дугаар зүйл.Нийтийн зориулалттай орон сууцны оршин суугчдын амгалан тайван байдлыг алдагдуулах	3153	3133
5.6 дугаар зүйл.Хууль бусаар зэвсэг эзэмших	328	329
5.7 дугаар зүйл.Мөрийтэй тоглоом зохион байгуулах	164	139
5.8 дугаар зүйл.Жагсаал, цуглаан зохион байгуулах журам зөрчих	27	17
5.9 дүгээр зүйл.Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль зөрчих	140	102
5.10 дугаар зүйл.Терроризмтой тэмцэх тухай хууль зөрчих	2	2
5.12 дугаар зүйл.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль зөрчих	1	1
5.16 дугаар зүйл.Энгийн харуул, манааны журам зөрчих	50	50
5.18 дугаар зүйл.Онц байдлын тухай хууль зөрчил	2	2
НИЙТИЙН ЁС СУРТАХУУН, ХҮН АМЫН ЭРҮҮЛ МЭНД, ЭРҮҮЛ АХУЙН ЖУРМЫН ЭСРЭГ ЗӨРЧИЛ	5133	4456
6.3 дугаар зүйл.Тамхины хяналтын тухай хууль зөрчих	2825	2806
6.5 дугаар зүйл.Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль зөрчих	1283	998
6.18 дугаар зүйл.Садар самуун явдалтай тэмцэх тухай хууль зөрчих	342	389
6.20 дугаар зүйл.Хүүхдийн эрхийг зөрчих	191	171
6.21 дүгээр зүйл.Гүтгэх	490	90
6.22 дугаар зүйл.Зөвшөөрөлгүй гэрэл зураг авах, дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг хийх	2	2
БАЙГАЛЬ ОРЧИН, АМЬТАН, УРГАМЛЫГ ХАМГААЛАХ ЖУРМЫН ЭСРЭГ ЗӨРЧИЛ	19	13
7.15 дугаар зүйл.Усны тухай хууль зөрчих	19	13
НИЙТИЙН ӨМЧ, ӨМЧЛӨХ ЭРХИЙН ЭСРЭГ ЗӨРЧИЛ	6167	1128
8.6 дугаар зүйл. Хулгайлах	4340	44
8.7 дугаар зүйл.Хөрөнгө завших	139	23
8.8 дугаар зүйл.Эд хөрөнгө устгах, гэмтээх	1688	1061
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРМЫН ЭСРЭГ ЗӨРЧИЛ		
АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРМЫН ЭСРЭГ ЗӨРЧИЛ	5514	5348
10.4 дүгээр зүйл.Худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааны журам зөрчих	5503	5338
10.8 дугаар зүйл.Аж ахуйн үйл ажиллагааны нууцад халдах	1	2
10.26 дугаар зүйл.Гэрээт харуул, хамгаалалтын тухай хууль зөрчих	10	8
ҮНЭТ ЦААС, БАНК, САНХҮҮ, ГААЛЬ, ТАТВАР, ДААТГАЛЫН ЖУРМЫН ЭСРЭГ ЗӨРЧИЛ	7464	7464
11.5 дугаар зүйл.Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль зөрчих		
11.15 дугаар зүйл.Жолоочийн даатгалын тухай хууль зөрчих	7464	7464

ХӨДӨӨ АЖ АХУЙ, ГАЗАР ТАРИАЛАНГИЙН ТАЛААР ТОГТООСОН ЖУРМЫН ЭСРЭГ ЗӨРЧИЛ	306	302
13.5 дугаар зүйл.Мал, махны үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ эрхлэх журам зөрчих	306	302
МЭДЭЭЛЭЛ, ХАРИЛЦАА ХОЛБОО, ТЭЭВЭР, ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН АШИГЛАЛТ, ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЖУРМЫН ЭСРЭГ ЗӨРЧИЛ	1595439	1560111
14.1 дүгээр зүйл.Харилцаа холбооны тухай хууль зөрчих		
14.4 дүгээр зүйл.Авто замын тухай хууль зөрчих	21	19
14.5 дугаар зүйл.Авто зам, замын байгууламж, тэмдэг, тэмдэглэлийг гэмтээх, өөрчлөх, бохирдуулах	2959	2950
14.6 дугаар зүйл.Автотээврийн тухай хууль зөрчих	3078	3079
14.7 дугаар зүйл.Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих	1589381	1554063
ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ХЭВИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЭСРЭГ ЗӨРЧИЛ	4147	4250
15.1 дүгээр зүйл.Эрүүл мэндийн байгууллага, хууль сахиулах байгууллагад туслалцаа үзүүлэхгүй байх	23	18
15.2 дугаар зүйл.Төрийн албан тушаалтны шийдвэрийг үл биелүүлэх, үйл ажиллагаанд нь саад учруулах	1635	1642
15.6 дугаар зүйл.Прокурорыг бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд саад учруулах	6	4
15.7 дугаар зүйл.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулах	20	15
15.8 дугаар зүйл.Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хууль зөрчих	2	2
15.9 дүгээр зүйл.Хуурамч дуудлага, мэдээлэл өгөх	2461	2569
15.10 дугаар зүйл.Гэмт хэргийг үл мэдээлэх		
МОНГОЛ УЛСЫН ХИЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН БОЛОН ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬАЛАЛГҮЙ ХҮН МОНГОЛ УЛСАД ЗОРЧИХ ЖУРМЫН ЭСРЭГ ЗӨРЧИЛ	2	2

Прокурорын байгууллагын зөрчлийн хэрэг бүртгэлтэд хяналт тавьсан тоон мэдээнээс үзвэл зөрчлийн хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн тохиолдол 10 дахин, хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн гэж прокурорын байгууллагад хянуулсан тохиолдол 2.5 дахин нэмэгдсэн байна. Зөрчлийн тухай хууль тогтоомж хэрэгжих явцад энэ тухай тоон мэдээллийг ашиглах, сан үүсгэх явдал учир дутагдалтай байсан бөгөөд прокурорын байгууллагаас хоёр ч удаа цахим мэдээллийн сангийн өгөгдлийг шинэчилж хийсэн байна.

Үзүүлэлт	Хялбаршуулсан журмаар шалгаж шийдвэрлэсэн		Нийт хүлээн авсан ГХТГМ		Хүлээн авахаас татгалзсан		Зөрчлийн хэрэг нээсэн		ХБМБ-ын хэрэг нээсэн		
	Он	2017 он	2018 он	2017 он	2018 он	2017 он	2018 он	2017 он	2018 он	2017 он	2018 он
	Он	2017 он	2018 он	2017 он	2018 он	2017 он	2018 он	2017 он	2018 он	2017 он	2018 он
		497912	1423799	12584	84594	6634	27739	5930	55206	20	1649

Хулгайлах болон гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх, эд хөрөнгө устгах зэрэг ижил гэмт хэрэг зөрчил хоорондоо шилжих тохиолдол нэмэгдсэн бөгөөд 2017 онд 20 зөрчлийг эрүүгийн хэрэг гэж үзэн шилжүүлж, шийдвэрлэж байсан бол 2018 онд 1649 зөрчлийг гэмт хэргийн шинжтэй гэж үзэн хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад шилжүүлсэн байна.

3. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Гэмт хэргийн өсөлт, бууралтын шалтгаан нөхцөл болон эрүүгийн хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хийсэн судалгаагаар дараах дүгнэлтийг хийж болохоор байна:

- Гэмт хэргийн тоон мэдээ, статистик гаргах байгууллага бүр өөр өөр аргачлал, журам ашигладаг нь цагдаа, прокурор, шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тоон мэдээ хол зөрүүтэй гарах үндсэн нөхцөл болж байна. Тухайлбал, цагдаагийн байгууллага тухайн онд бүртгэгдсэн хэрэг бүртгэлтийн хэргийг Эрүүгийн хуулийн зүйл, хэсэг, заалт бүрээр гаргаж, прокурорт шилжүүлж шийдвэр гаргуулснаар статистик мэдээг гаргадаг бол прокурорын байгууллага тухайн бүртгэгдсэн хэрэгт хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн, хаасан, мөрдөн байцаалтын хэрэг нээсэн, хэрэгсэхгүй болгосон тохиолдлоор тоон мэдээгээ гаргаж байна.
- Прокурорын байгууллага нь цагдаагийн байгууллагаас ирүүлсэн эсхүл хянаж шийдвэрлэсэн хэргийг өөрсдийн ажлын үзүүлэлтээр буюу тэдний хуульд заасан шийдвэр гаргалтын төрлөөр тоон мэдээг цааш нь гаргадгаас гэмт хэргийн үндсэн мэдээлэл зөрж эхэлдэг байна. Өөрөөр хэлбэл тодорхой эрүүгийн хэрэг прокурорын хяналтын явцад хэдэн хэрэг болон задарч эсхүл нэгтгэж, түдгэлзүүлж шийдвэрлэж байгааг гаргах боломжгүй ба нийт дүнгээр тоон мэдээ гаргадаг байна.
- Шүүхийн статистик мэдээний хувьд ч адилхан бөгөөд тухайн онд прокуророос шилжсэн эрүүгийн хэргийн зүйл хэсэг заалтаар бус өмнөх онуудын болон үлдэгдэл нийт хэргээс шийдсэн байдлаас статистик гаргадаг тул тухайн онд гарсан хэрэг гэж ялгах боломжгүй байдаг. Гэмт хэргийг шалгаж, хянан шийдвэрлэдэг тогтолцооны аль хэсэгт хэрэг яаж өөрчлөгдөж байгааг ийнхүү тоон үзүүлэлтээр тулгаж хянах боломжгүй тул цаашид нэгдсэн аргачлалд шилжих шаардлагатай гэсэн дүгнэлтэнд хүрч байна.
- Монгол Улсад 2018 онд 36.2 мянган гэмт хэрэг бүртгэгдсэн нь 2017 оноос 3961(12.3%)-ээр өссөн ба нийтлэг гардаг 8 төрлийн гэмт хэрэг нийт гэмт хэргийн үнэмлэхүй массыг эзэлсэн хэвээр байна.
- Судалгаагаар 2019 онд болон түүнээс цааш гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэл, гэмт хэргийн өсөх хандлагатай гэж таамаглаж байна. Орчин цагийн нийтийн сүлжээний мэдээллийн тархалт нэгмэгдэж, хууль сахиулах байгууллагаас зөрчил, гэмт хэргийн талаар гомдол мэдээлэл авах сувгийн төрлийг нэмэгдүүлэхийн хэрээр дээрх үзүүлэлт байнга тасралтгүй өсөн нэмэгдэх төлөвтэй байна.
- Зөрчлийн тоон мэдээ цаашид ч өсөх прогноз ажиглагдав. Зөрчлийн хуулийн талаар нийт иргэд сөрөг ойлголттой, хуулийг хэрэгжүүлэхгүй байх хандлага давамгайлж байна. Цаашид 2020 оноос хэрэгжиж эхлэх Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангах шаардлагатай.
- Эрүүгийн хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт орох тохиолдол болгон нь гэмт хэргийн статистик үзүүлэлт шууд нөлөөлөх бөгөөд 2019 онд Монгол Улсын Их Хурлаас Эрүүгийн хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулахаар төлөвлөжээ. Тухайлбал, уг нэмэлт, өөрчлөлтөд гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээллийг шалгах хугацааг сунгах, хөөн хэлэлцэх хугацааг өөрчлөх зэрэг асуудал хөндөгдөж байгаа бөгөөд энэ нь гэмт хэргийн статистик үзүүлэлтэд шууд нөлөөлөх хүчин зүйл болно.
- Гэмт хэрэг, зөрчлийн цахим бүртгэлийг сайжруулах, тухайн онд бүртгэгдэж шийдвэрлэгдэж байгаа хэргийн тоон мэдээг мөрдөн шалгах, прокурор, шүүх, шүүхийн шийдвэр гэсэн дарааллаар харах боломжтой тогтолцоог бий болгох.
- Гэмт хэргийн шалтгаан, нөхцлийг судлах судалгааны байгууллагуудыг бэхжүүлэх, гэмт хэргийн цагаан ном боловсруулах чиг үүргийг төр өөртөө авах.
- Криминологич мэргэжилтнийг бэлтгэх сургах чиглэлээр нэгдсэн бодлого баримтлах гадаад улсын ижил төстэй судалгааны байгууллагуудтай хамтран ажиллаж, орчин үеийн судалгааны арга зүйг нэвтрүүлэх шаардлагатай гэсэн дүгнэлтэнд хүрлээ.

ХОЁРДУГААР
БҮЛЭГ

ТОДОРХОЙ ТӨРЛИЙН
ГЭМТ ХЭРЭГ



1. ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН ТУСГАЙ АНГИЙН АРАВДУГААР БҮЛЭГ (Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг)

1.1. Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг



Зүйл, хэсэг	ЦБ	ПБ		Шүүх	
	Шинээр БГХ	Нийт ХБМБ явуулсан	Тайлант онд ШҮХ	Шийдвэрлэвэл зохих	Хянан шийдвэрлэсэн
10.1	192	374	255	216	164
10.2	2	16	10	3	3
10.3	-	12	6	-	-
10.4	459	4014	3597	-	-
10.5	8	17	15	3	3
10.6	53	151	103	60	52
Нийт	714	4573	3977	282	222

ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГА:

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 10-р бүлэгт заасан гэмт хэрэг улсын хэмжээнд 714 шинээр бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 7 хэргээр буюу 0.97%-иар, Нийслэлийн хэмжээнд 433 шинээр бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 45 хэргээр буюу 9.41%-иар тус тус буурсан байна. ЦБ-д нийт 36220 гэмт хэрэг бүртгэгдсэн байх бөгөөд энэ бүлэгт заасан гэмт хэрэг 714 бүртгэгдсэн нь нийт гэмт хэргийн 1.97%-ийг эзэлж байна.

	Хэргийн тоо		Өсөлт, бууралтын хувь	Нийт хэрэгт эзлэх хувь		Өсөлт, бууралтын хувь
	2017 он	2018 он		2017 он	2018 он	
Орон нутагт	243	281	+15.63%	2.36%	2.67%	+0.31%
Нийслэлд	478	433	-9.41%	2.17%	1.68%	-0.49%
Улсын дүн	721	714	-0.97%	2.23%	1.97%	-0.26%

Холбогдогч (ЦБ-ын тоо бүртгэл)

Энэ бүлэгт заасан гэмт хэрэгт нийт 266 хүнийг холбогдуулан МША явуулсан бөгөөд үүнээс 133 тохиолдол нь согтуугаар, 27 тохиолдол нь бүлэглэж үйлджээ.

Мөн энэ бүлэгт заасан гэмт хэрэгт холбогдон шалгагдсан этгээдүүдийн 29 нь урьд шүүхээр шийтгэгдэж байсан, эмэгтэй 42, насанд хүрээгүй 5 хүн байна.

ГХИ 73.8%-тай байна.

Хохирогч, хохирол (ЦБ-ын тоо бүртгэл)

Энэ бүлэгт заасан гэмт хэргийн улмаас 647 иргэн хохирсон бүртгэлд авагдсанаас 3 иргэн нь гадаад улсын харьяат иргэн байна. Нийт 558 хүн нас барж, 34 хүн гэмтжээ.

Гэмт хэргийн улмаас иргэнд учирсан 1164.01 сая төгрөгийн хохирлоос 895.9 сая төгрөг буюу нийт хохирлын 79.9%-ийг нөхөн төлүүлж, 551.2 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилжээ.

ПРОКУРОРЫН ХЯНАЛТ

ПБ-аас Эрүүгийн хуулийн 10 дугаар бүлэгт заасан Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэгт холбогдуулан улсын хэмжээнд нийт 4573 хэргийн ХБМБА-нд хяналт тавьжээ.

Тайлант онд шинээр үүссэн хэрэгт нийт 333 хүнийг эрүүгийн хэрэг үүсгэн, яллагдагчаар татсан бол үүнээс 265 нь эрэгтэй, 68 эмэгтэй байна.

ПБ-ын тоон үзүүлэлтийг харуулбал:

Зүйл, хэсэг	Нийт ХБМБ явуулсан	Тухайн жил шинээр үүссэн	Шийдвэрлэлт					Үлдэгдэл хэрэг	
			ХБ-ийн хэрэг хаасан	Нэгтгэгдсэн	Хэрэгсэхгүй болгосон	Түдгэлзүүлсэн	Шүүхэд шилжүүлсэн	ХБ-ийн үлдэгдэл	МБ-ын үлдэгдэл
10.1	374	255	25	8	5	-	216	41	79
10.2	16	10	6	2	1	-	3	4	-
10.3	12	6	3	-	-	-	7	2	-
10.4	4014	3597	3358	9	1	-	14	628	6
10.5	17	15	8	-	-	-	4	5	-
10.6	151	103	31	-	5	-	47	55	13
Нийт	4573	3977	3426	19	12	-	289	733	96

ПБ-ын бүртгэлээс үзвэл энэ бүлэгт заасан гэмт хэргийн улмаас 2463 хүн хохирсон байх бөгөөд нийт 1561 хүн нас барж, 80 хүн гэмтсэн гэж бүртгэгдсэн нь ЦБ-ын бүртгэлээс эрс зөрүүтэй байгааг анхаарч үзвэл зохино.

ШҮҮХИЙН ШИЙДВЭРЛЭЛТ

Шүүхийн шатанд нийт 282 хэрэг бүртгэгдсэн байх ба үүнээс 222 хэргийг шийдвэрлэж, 3 хэргийг цагаатгажээ. Энэ бүлэгт заасан гэмт хэргийн улмаас нийт 192 хүн ял шийтгүүлсний 191 нь хорих ялаар шийтгүүлсэн. Үүнээс 25 нь эмэгтэй, 4 нь өсвөр насны хүн байна.

Улаанбаатар хотын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргийн тоон үзүүлэлтийг дүүрэг тус бүрээр, буурах дарааллын дагуу хүснэгтээр үзүүлбэл:

¹ "Улаанбаатар хот" гэх нэршилд 9 дүүргийг нийтэд нь хамруулсан бөгөөд Нийслэл, дүүргүүд гэх нэршилтэй агуулгын хувьд ижил.

² ШШГБ-ын хорихоос бусад төрлийн ял эдлүүлэх ажиллагаанд холбогдох статистик мэдээлэл нь нутаг дэвсгэр бүрээр гардаггүй бөгөөд 2017, 2018 оны нутаг дэвсгэрт хамаарах статистик мэдээллийг судалгааны багт ирүүлээгүй болно.

³ 2016-2017 онд 5092 буюу 18.7%-иар өссөн дүнтэй байжээ.



д/д	Дүүргийн нэр	Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо		Өсөлт, бууралт	
		2017	2018	тоо	хувь
1	Баянзүрх	5939	7522	1583	26.7
2	Баянгол	3204	4501	1297	40.5
3	Сүхбаатар	3816	4132	316	8.3
4	Сонгинохайрхан	3691	3692	1	0.03
5	Чингэлтэй	2719	2776	57	2.1
6	Хан-Уул	1900	2332	432	22.7
7	Налайх	393	420	27	6.9
8	Багануур	254	253	-1	-0.4
9	Багахангай	31	24	-7	-22.6

Улаанбаатар хот буюу нийт дүүргүүдийн хэмжээнд Баянзүрх дүүрэгт 7522 гэмт хэрэг бүртгэгдсэн нь хамгийн өндөр дүнтэй байх бөгөөд энэ нь дүүргийн дунджаас 2.3 дахин их байна. Мөн БГХ-ийн дүнгээр 2017 онд Баянгол дүүрэг нийт 9 дүүргээс эхний 4-т бичигдэж байсан бол 2018 онд 2-т бичигдэж, 1297 гэмт хэргээр буюу 40.5%-иар, Хан-Уул дүүрэгт 432 гэмт хэрэг буюу 22.7%-иар өссөн байгаа нь тус тус анхаарал татаж байна. Харин Багануур, Багахангай дүүргүүдэд БГХ буурсан эерэг үзүүлэлт гарчээ.

• *Бүртгэгдсэн гэмт хэрэг тоогоор*

Нийт дүүргүүдийн хэмжээнд Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргээс Хулгайлах, Залилах, Дээрэмдэх гэмт хэргүүд, Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг тус тус хамгийн их дүнтэй байх бөгөөд эдгээр гэмт хэрэг нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн гэмт хэргийн 21501 буюу 83.5%-ийг эзэлж байна.

Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг, Хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг гэмт хэрэг тус бүр 1 бүртгэгдсэн байгаа нь хамгийн бага дүнтэй байна.

• *Бүртгэгдсэн гэмт хэрэг өсөлт, бууралтын хувиар*

Нийт дүүргүүдийн хэмжээнд Хүчиндэх гэмт хэрэг 75 буюу 38.7%-иар, Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг 37 буюу 71.2%-иар, Хүүхдийн эсрэг гэмт хэрэг 8 буюу 72.7%-иар, Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 3849 буюу 28.3%-иар үүнээс Залилах гэмт хэрэг 2076 буюу 78.1%-иар, Дээрэмдэх гэмт хэрэгт 279 буюу 25.8%-иар, Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг 3 буюу 33.3%-иар, Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг 46 буюу 55.4%-иар тус тус өссөн байгаа нь анхаарал татаж байна.

Харин Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг 45 буюу 9.4%-иар, үүнээс Хүнийг алах гэмт хэрэг 8 буюу 6.8%-иар, Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг 47 буюу 30.9%-иар, Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг 14 буюу 70.0%-иар, Эдийн засгийн эсрэг гэмт хэрэг 17 буюу 8.9%-иар, Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг 551 буюу 70.9%-иар, Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг 29 буюу 17.5%-иар, Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг 21 буюу 51.2%-иар, Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг 3 буюу 7%-иар, Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 135 буюу 20.5%-иар тус тус буурсан эерэг үзүүлэлттэй байна.

Тодорхой төрлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа /2018 он/

Тодорхой төрлийн гэмт хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны статистик мэдээлэл нь 2015 онд Эрүүгийн хууль шинэчлэгдсэнтэй холбоотойгоор зарим байгууллагад хуучин болон шинэ хуулийн харгалзах бүлэг, зүйлүүд нэгтгэгдэн нэг үзүүлэлтээр гарч байхад зарим байгууллагын хувьд “2002 оны Эрүүгийн хуулиар”, “2015 оны Эрүүгийн хуулиар” тус тусдаа⁴

⁴ 2002 болон 2015 оны Эрүүгийн хууль дахь гэмт хэргийг бүлэглэн хуульчилсан байдал нь харилцан адилгүй байх тул нэг хүснэгтэд мэдээллийг харуулахдаа 2002 оны хуульд хамаарах хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны мэдээллийг зөвхөн зүйлээр нь харуулж, бүлэгт холбогдох мэдээллийг нөхөлгүй хоосон үлдээж, харин 2015 оны хуульд хамаарах мэдээллийг Эрүүгийн хуулийн бүлэг болон зүйлээр тус тус харуулсан болно. Мөн шүүх байгууллагаас нутаг дэвсгэрийн хэмжээнд 2002 оны хуулиар шийдвэрлэсэн тодорхой төрлийн гэмт хэргийн талаарх 2018 оны мэдээлэл ирээгүй тул зөвхөн 2015 гэсэн баганан дахь тоог харуулж байгаа бөгөөд энэ нь 2018 онд шүүх байгууллагаас тухайн нутаг дэвсгэрт шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн тоо бүтнээрээ биш зөвхөн 2015 онд батлагдсан Эрүүгийн хуулийн холбогдох бүлэг, зүйлээр шийдвэрлэсэн хэргийн мэдээлэл болохыг анхаарна уу. Иймд энэхүү номын “Нутаг дэвсгэрийн гэмт хэрэг” гэх энэхүү бүлэгт ШБ-аас шийдвэрлэсэн хэргийн хувьд 2018 оны нийт дүнг ЭХ-ийн бүлгээр нь тодорхойлон дурдах боломжгүй байна.

гарсан байна. Улаанбаатар хотын хэмжээнд ЭХХША-нд хамаарах БГХ, түүнийг хянасан, шийдвэрлэсэн талаарх нэгдсэн статистикийг ЭХТА-д хуульчлагдсан гэмт хэргийн бүлгээр, түлхүү үйлдэгддэг болон анхаарал татсан зарим гэмт хэргийг төрлөөр нь харуулбал:

Эх сурвалж: ЦЕГ, УЕПГ, ШЕЗ, ШШГЕГ

№	Гэмт хэргийн төрөл	ЦБ	ПБ		ШБ		ШШГБ ⁵
			2002	2015	2002	2015	
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг /10-р бүлэг/	433		2226	-	117	-
	Үүнээс Хүнийг алах 91/10.1	110	0	155	-	98	
	Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх 95/10.4	459	1	2008	-	0	
2	ХЭМХБЭГХ /11-р бүлэг/	5867		7970	-	3953	-
	Үүнээс Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах 96/11.1	295	0	233	-	189	
	Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулах 99/11.6	8128	2	7019	-	3345	
	Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх 120 ¹ /11.7	105	0	202	-	45	
3	ХБЭЧХБЭГХ /12-р бүлэг/	315		591	-	120	-
	Үүнээс Хүчиндэх 126/12.1	269	1	518	-	108	
4	ХХЧБЭЭГХ /13-р бүлэг/	89		187	-	9	-
	Үүнээс Хүн худалдаалах 113/13.1	7	0	26	-	3	
5	ХХУТЭЭЧЭГХ /14-р бүлэг/	6		7	-	0	-
6	Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг /15-р бүлэг/	23		42	-	4	-
7	Хүүхдийн эсрэг гэмт хэрэг /16-р бүлэг/	19		40	-	6	-
8	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг /17-р бүлэг/	17465		24214	-	1681	-
	Үүнээс Хулгайлах 145/17.1	9539	29	12930	-	782	
	Дээрэмдэх 146,147/17.2	4735	10	1769	-	216	
	Залилах 148/17.3	1360	12	6396	-	348	
	Мал хулгайлах 17.12	93		110	-	8	
9	Эдийн засгийн эсрэг гэмт хэрэг /18-р бүлэг/	174		306	-	15	-
10	ҮАБЭГХ /19-р бүлэг/	12		40	-	20	-
11	ОНАБАСЭГХ /20-р бүлэг/	226		371	-	128	-
	Үүнээс Олон нийтийн амгалан тайван байдал алдагдуулах 181/20.16	41	0	54	-	17	
12	Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг /21-р бүлэг/	129		248	-	13	-
13	НААСЭГХ /23-р бүлэг/	137		228	-	34	-
14	ХБОЭГХ /24-р бүлэг/	20		101	-	24	-
15	Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг /25-р бүлэг/	1		1	-	0	-
16	ЦМАБЭГХ /26-р бүлэг/	40		72	-	3	-
17	ХАБТХАЖЭГХ /27-р бүлэг/	517		1165	-	429	-
	Үүнээс АТХХАБАЖЗ гэмт хэрэг 215/27.10	511	0	1147	-	429	-
18	Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг /28-р бүлэг/	8		14	-	5	-
19	ХТАБЭТЭГХ /29-р бүлэг/	1		0	-	0	-
Улаанбаатар хотод нийт		25652	64	37731	-	6579	1328

⁵ ШШГБ-ын хорих ял эдлүүлэх ажиллагаанд холбогдох статистик мэдээлэл нь нутаг дэвсгэрээр гардаггүй тул дээрх хүснэгтээр үзүүлэх тодорхой төрлийн гэмт хэрэгт хорих ялаар шийтгэгдэн хоригдож буй хүний мэдээллийг харуулах боломжгүй байна.

Улаанбаатар хот буюу нийт дүүргүүдийн хэмжээнд 2018 онд Цагдаагийн байгууллагад 25652 гэмт хэрэг бүртгэгдэж, Прокурорын байгууллага нь 2002 оны ЭХ-р 64, 2015 оны ЭХ-р 37731 гэмт хэрэгт тус тус ХБМБ-ын ажиллагаа явуулж, Шүүх байгууллагаас 2015 оны ЭХ-р 6579 эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэж, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад 1328 хүн хоригдож байна.

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад ЦБ-д бүртгэгдсэн гэмт хэрэг 3961 буюу 12.2%-иар, ПБ-д нийт ХБМБ явуулсан хэрэг 12607 буюу 50%-иар тус тус өссөн байна.

Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс, нийгмийн байдал

Улаанбаатар хотын хэмжээнд 2018 онд БГХ 16.9 хувиар өссөн хэдий ч түүнд холбогдон шалгагдсан хүний тоо буурсан эерэг дүнтэй байна.

Гэмт хэрэгт холбогдон шалгагдсан хүний нэгдсэн статистик мэдээллийг зарим онцлогийн хамт харуулбал:

Эх сурвалж: ЦЕГ, УЕПГ, ШЕЗ, ШШГЕГ

д/д	Үзүүлэлт	ЦБ		ПБ ⁶		ШБ ⁷		ШШГБ	
		Шалгагдсан бүгд		Яллагдсан бүгд		Ял шийтгүүлсэн бүгд		Хорих ял эдэлж байгаа бүгд	
		2017	2018	2017	2018	2017	2018	2017	2018
1	Нийт хүн	9618	8844	9391	9023	4092	6729	-	-
	Эрэгтэй	8054	7418	7442	7394	3582	5900	-	-
	Эмэгтэй	1564	1426	1927	1574	510	829	-	-
	Хүүхэд	541	495	463	545	150	133	-	-
	14-15 нас	147	208	117	182	25	19	-	-
	16-17 нас	394	287	329	280	125	114	-	-
	18-24 нас	2328	2070	1973	1960	1975	18-29 насны 3002	-	-
	25-29 нас	2102	1799	1948	1722			-	-
	30-34 нас	1510	1584	1463	1557	741	1722	-	-
	35-39 нас	1035	942	1084	992	1226	35-дээш насны 1872	-	-
	40-44 нас	850	820	813	770			-	-
	45-49 нас	557	596	572	553			-	-
	50-54 нас	364	283	375	343			-	-
	55-59 нас	208	158	188	186			-	-
	60-64 нас	78	63	80	68			-	-
	65-69 нас	24	21	22	23	-	-		
	70-аас дээш	21	13	28	32	-	-		
	Тодорхойгүй ⁸			386	293	-	-	-	-
2	Согтуугаар	4427	4655	-	-	-	1367	-	-
3	Мансуурсан үедээ	89	207	-	-	-	1	-	-
4	Бүлэглэж	2881	2483	-	-	-	-	-	-
5	Галт зэвсгээр	38	23	-	-	-	-	-	-
6	Урьд ял шийтгүүлсэн	492	1267	719	519	-	1200	-	-

⁶ ПБ-аас 2018 онд үүсгэсэн хэрэг дэх яллагдагчийн тоо бөгөөд “эрэгтэй”, “эмэгтэй” гэсэн үзүүлэлтийн нийлбэр нь нийт яллагдсан хүний тоотой таарахгүй байгаа тул үзүүлэлтийн задаргааг дүгнэх боломжгүй байна. Энэ нь хэд хэдэн гэмт хэрэгт яллагдсан тохиолдолд яллагдагчийн тоо нь нэгээс илүүгээр тоологддогтой холбоотой байж болно. Мөн судалгааны багт ирүүлсэн мэдээлэлд гэмт хэргийн зарим онцлогийг харуулах “согтуугаар”, “мансуурсан үедээ” зэрэг үзүүлэлтэд холбогдох мэдээлэл ирүүлээгүй болно.

⁷ Шүүх байгууллагын зүгээс нутаг дэвсгэрийн хэмжээнд гаргасан 2018 оны мэдээлэл нь зөвхөн 2015 онд батлагдсан хуулийн зүйлээр шийдвэрлэсэн хэрэгт ял шийтгүүлсэн талаарх мэдээлэл юм. Иймд 2002 оны хуулиар 2018 онд шийдвэрлэсэн хэрэгт хамаарах ял шийтгүүлэгчийн мэдээлэл энэхүү номд ороогүй болно. Мөн шүүх байгууллага дахь ял шийтгүүлсэн хүний насны ангилал бусад байгууллага дахь насны ангиллаас нэлээд өөр байна. Иймд албан ёсны эх сурвалжаас өгсөн мэдээллийн дагуу хүснэгтэд үзүүлэлтийг нөхсөн болно. Мөн гэмт хэргийн зарим онцлогийг харуулах “галт зэвсгээр”, “бүлэглэж” зэрэг үзүүлэлт нь шүүх байгууллагын хэмжээнд гардаггүй байна.

⁸ Тодорхойгүй гэх үзүүлэлт нь зөвхөн прокурорын байгууллагаас ирүүлсэн статистик мэдээлэлд “тухайн мэдээллийг санд шивэхдээ насыг сонголтгүйгээр шивсэн тохиолдолд ийнхүү бүртгэгдсэн” гэсэн тайлбартайгаар ирсэн үзүүлэлт болно. Бусад байгууллагын хувьд ийм үзүүлэлт гардаггүй болно.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд 2018 онд холбогдон шалгагдсан бүгд тоог өмнөх онтой харьцуулахад ЦБ-ын мэдээллээр БГХ-т холбогдон шалгагдсан бүгд 8844 байгаа нь 774 буюу 8%-иар, ПБ-д 2018 онд үүсгэсэн хэрэг дэх ялагдсан бүгд 9023 байгаа нь 368 буюу 3.9%-иар тус тус буурсан эерэг үзүүлэлттэй байгаа бол ШБ-д ял шийтгүүлсэн бүгд 6729 байна.

ЦБ-ын хэмжээнд БГХ-т нийт холбогдон шалгагдсан бүгд 8844 хүний 7418 буюу 83.9%-ийг эрэгтэй, 1426 буюу 16.1%-ийг эмэгтэй, 495 буюу 5.6%-ийг хүүхэд, ШБ-аас ял шийтгүүлсэн 6729 тохиолдол бүгд хүнд хамаарч байх бөгөөд 5900 буюу 87.6%-ийг эрэгтэй, 829 буюу 12.4%-ийг эмэгтэй, 133 буюу 1.9%-ийг хүүхэд тус тус эзэлж байна.

Гэмт хэрэгт хамаарах зарим онцлогийг өмнөх онтой харьцуулахад ЦБ-ын хэмжээнд шалгагдсан хүний 52.6% нь согтуурсан үедээ, 2.3% нь мансуурсан үедээ, 28% нь бүлэглэж, 0.3% нь галт зэвсэг хэрэглэн, 14.3% нь урьд ял шийтгүүлж байсан холбогдогч тус тус эзэлж байгаа бол ШБ-аас ял шийтгүүлсэн хүний 20.3% нь согтуугаар, 1 хүн буюу 0.01% нь мансуурсан үедээ гэмт хэрэг үйлдсэн гэж ялагдсан байна.

ЦБ-ын мэдээллээр мансуурсан үедээ гэмт хэрэгт холбогдон шалгагдсан хүний тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад 118 буюу 2.3 дахин их байгаа нь анхаарал татаж байгаа бол бүлэглэж үйлдсэн холбогдогчийн тоо 398 буюу 13.8%, галт зэвсэг хэрэглэсэн холбогдогчийн тоо 15 буюу 39.4%-иар тус тус буурсан эерэг үзүүлэлт гарчээ.

Гэмт хэргийн хохирогч, хохирол

Гэмт хэргийн улмаас хохирсон хүн, хуулийн этгээдэд хамаарах мэдээллийн бааз хууль сахиулах болон шүүх эрх мэдлийн зарим байгууллагад харилцан адилгүй байна. Тухайлбал, цагдаагийн болон прокурорын байгууллагад 2018 он болон түүнээс өмнөх хугацаанд хамаарах энэ төрлийн мэдээллийн олдоц харьцангуй сайн байх бол Шүүх байгууллагад бааз багатай байна.

Улаанбаатар хотын хэмжээнд гэмт хэргийн улмаас хохирсон хүн, хуулийн этгээдэд хамаарах нэгдсэн статистик мэдээллийг дүүргээр нь харуулбал:

Эх сурвалж: ЦЕГ, УЕПГ, ШЕЗ

д/д	Дүүргүүд	ЦБ		ПБ		ШБ	
		2017 он	2018 он	2017 он	2018 он	2017 он ⁹	2018 он
1	Баянзүрх	5291	7104	6089	8876	-	1846
2	Баянгол	9420 ¹⁰	3896	1812	2145	-	1017
3	Сүхбаатар	3253	3630	3222	3584	-	980
4	Сонгинохайрхан	3710	3623	2639	3901	-	1050
5	Чингэлтэй	2575	2634	3081	2857	-	1219
6	Хан-Уул	1647	1731	1413	1795	-	862
7	Налайх	391	408	591	449	-	228
8	Багануур	261	262	216	291	-	192
9	Багахангай ¹¹	48	21	-	-	-	2
	Нийт	26596	23309	19063	23898	-	7396

2018 онд Улаанбаатар хотын хэмжээн дэх хохирогчийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад хохирогч бүгд ЦБ-д 23309 байгаа нь 3287 буюу 12.3%-иар, ПБ-д 25233

⁹ Шүүх байгууллагад 2017 онд хохирогчийн мэдээллийн маягт батлагдан гарч 2018 оноос холбогдох үзүүлэлтээр мэдээлэл нэгтгэн гаргах болсон тул 2017 оны мэдээлэл номд ороогүй болно.

¹⁰ Баянгол дүүрэгт 2017 онд 9420 байгаа нь Баянгол дүүрэгт гарсан залилах гэмт хэрэгтэй холбоотой бөгөөд энэхүү хэрэг нь цахимаар үйлдэгдсэн байдаг.

¹¹ Прокурорын байгууллагаас гаргадаг дүүргүүдэд хамаарах энэхүү мэдээлэлд "Багахангай" дүүрэгт хамаарах мэдээлэл тусдаа гардаггүй, "Налайх, Багахангай" гэж хамтдаа гардаг байна. Иймд Багахангай дүүргийн мэдээлэл Налайх дүүрэгт хамт нөхөгдсөн болно.

байгаа нь 5010 буюу 24.7 хувиар тус тус өссөн байна. ШБ-ын мэдээллээр гэмт хэргийн улмаас 2018 онд 7396 хохирогч хохирсон байна.

ПБ-д хянагдаж буй нийт хэрэгт гэмт хэргийн улмаас 2018 онд хохирогч бүгд 25233 байгаа нь нийт дүүргүүд дэх ПБ-аас шалгасан хэрэгт 23898, ТПГ-аас шалгасан хэрэгт 1204, НПГ-аас шалгасан хэрэгт 131 хохирогч тус тус хохирсон байна.

Улаанбаатар хотын хэмжээнд гэмт хэргийн улмаас хохирсон хохирогчийн мэдээллийг нас, хүйсээр нь, гэмт хэргийн улмаас учирсан хохирлын мэдээлэлтэй хамт харуулбал:

Эх сурвалж: ЦЕГ, УЕПГ, ШЕЗ

Үзүүлэлт	ЦБ		ПБ		ШБ	
	2017 он	2018 он	2017 он	2018 он	2017 он	2018 он
Хүн	26579	23290	15328	25226	-	7396
Эрэгтэй	12341	12541	3038	9410	-	4832
Эмэгтэй	14238	10749	12290	15816	-	2564
Хүүхэд	1115	1128	564	1098	-	363
18-24 нас	3191	3279	1826	3426	-	1384
25-29 нас	4655	4135	2449	4271	-	1472
30-34 нас	4461	4007	2555	4228	-	1494
35-39 нас	3476	3016	2024	3328	-	1090
40-44 нас	2909	2476	1701	2691	-	640
45-49 нас	2247	1857	1367	2031	-	403
50-54 нас	1895	1375	1052	1572	-	288
55-59 нас	1337	1010	803	1134	-	145
60-64 нас	643	528	414	673	-	56
65-69 нас	355	248	163	288	-	30
70-аас дээш	295	231	227	301	-	31
Нас барсан	504	415	945	1195	-	177
Гэмтсэн	6093	5381	5631	6807	-	4484
Хуулийн этгээд	17	19	24	12	-	16
Учирсан хохирол	166748.6	161904.9	-	-	-	24725.2
Нөхөн төлүүлсэн хохирол	58669.6	19051.1	-	-	-	15379.7

Нийт дүүргүүд буюу Улаанбаатар хотын хэмжээнд ЦБ-д БГХ-ийн улмаас 23309 хохирогч, үүнээс 23290 хүн, 19 хуулийн этгээд, ПБ-д нийт хянагдсан гэмт хэрэгт хохирогч бүгд 25238 байгаагаас 25226 хүн, 12 хуулийн этгээд, ШБ-аас шийдвэрлэсэн хэрэгт хохирогч бүгд 7422 байгаагаас 7396 хүн, 16 хуулийн этгээд тус тус хохирсон бол өмнөх онтой харьцуулахад 2018 онд БГХ-ийн хохирогч бүгд 24.7%-иар, хохирсон хүн 64.5%-иар тус тус өсч, хохирогч хуулийн этгээд 61.1%-иар буурч, нийт ХБМБ явуулсан хэрэгт хохирогч бүгд 64.3%-иар, хохирсон хүн 64.5%-иар тус тус өсч, хохирсон хуулийн этгээд 2 дахин буурсан байна.

Нийт учирсан хохирол болон нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээг өмнөх онтой нь харьцуулбал ЦБ-ын мэдээлэлд гэмт хэргийн улмаас учирсан хохирол 161904.9 сая төгрөг байгаа нь 4843.7 сая буюу 2.9%-иар, нөхөн төлүүлсэн хохирол 19051.1 сая байгаа нь 39618.4 сая буюу 67.5%-иар тус тус буурсан бол ШБ-ын мэдээлэлд дурдсанаар 2018 онд учирсан хохирлын 62.2%-ийг нөхөн төлүүлсэн байна.

2. БАЯНГОЛ ДҮҮРЭГ

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа

2018 онд Баянгол дүүрэг дэх цагдаагийн хэлтсүүд нь иргэд, хуулийн этгээдээс 17843 гомдол, мэдээлэл хүлээн авснаас 10615 буюу 59.5%-ийг гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл эзэлж байгаа бөгөөд гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээллээс 4501 буюу 42.4% нь бүртгэгдсэн байна.

Прокурорын байгууллага Баянгол дүүрэгт нийт 9441 хэрэгт ХБМБ-ын ажиллагаа, тухайн жилд 6527 хэрэгт ХБМБ тус тус явуулсан нь өмнөх оны мөн үеэс нийт ХБМБ явуулсан хэрэг 74.3%-иар, тухайн жилд ХБМБ явуулсан хэрэг 91.1%-иар өсжээ. Мөн 2018 онд 2654 хэргийн хэрэг бүртгэлтийг хааж, 383 хэргийг нэгтгэж, 37 хэргийг хэрэгсэхгүй болгож, 9 хэргийг түдгэлзүүлж, 927 хэргийг шүүхэд шилжүүлж, хэрэг бүртгэлтийн 5308, мөрдөн байцаалтын 133 хэргийн тус тус үлдэгдэлтэй, тухайн жилд үүсгэсэн хэрэгт 1138 яллагдагч яллагдсан байна.

Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх 2015 оны Эрүүгийн хуулиар 965 хэргийг хянан шийдвэрлэж, 999 хүнд ял оногдуулснаас 165 хүнийг хорих, 110 хүнийг нийтэд тустай ажил хийлгэх ялаар, 724 хүнийг торгох ялаар тус тус шийтгэсэн байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад Баянгол дүүрэгт харьяалалтай 130 хоригдол 2018 онд ял эдэлж байна.

Бүртгэгдсэн гэмт хэрэг

2018 онд Баянгол дүүрэгт 4501 буюу нийт гэмт хэргийн 12.4% нь бүртгэгдсэн бөгөөд өмнөх оны мөн үеэс бүртгэгдсэн гэмт хэрэг 1297 буюу 40.5%-иар өссөн байна. Баянгол дүүрэгт бүртгэгдсэн гэмт хэргийн хураангуй мэдээлэл болон тоон үзүүлэлтийг хороо тус бүрээр буурах дарааллын дагуу хүснэгтээр үзүүлбэл:

Хураангуй:

- Улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэрэгт эзлэх хувь **12.4**
- Улаанбаатар хотод эзлэх хувь **17.5**
- Хамгийн их бүртгэгдсэн **20-р хороо**
- Хамгийн бага бүртгэгдсэн **23-р хороо**
- Хороодын дундаж нь **195.7**
- Гэмт хэрэг хамгийн их үйлдэгддэг газар **Гудамж талбай**
- Гэмт хэрэг хамгийн их үйлдэгддэг гараг **Баасан**
- Гэмт хэрэг хамгийн их үйлдэгддэг цаг **22-06**
- Гэмт хэрэг хамгийн ихээр үйлдэж байгаа хүний нас **18-24**
- Согтуугаар үйлдсэн **276**
- Эмэгтэй хүн үйлдсэн **272**
- Хүүхэд үйлдсэн **19**
- Хохирогч иргэн **3894**
- Нас барсан **49**
- Гэмтсэн **994**
- Хохирлын дүн **31893.7 сая**
- Нөхөн төлүүлсэн хэмжээ **3374.9 сая**
- Хамгийн их бүртгэгдсэн гэмт хэрэг **Хулгайлах**

№	Хороо	2017	2018	БГХ-т эзлэх хувь
1	20-р хороо	284	468	10.3
2	5-р хороо	199	357	7.9
3	2-р хороо	191	311	6.9
4	4-р хороо	199	308	6.8
5	7-р хороо	150	301	6.6
6	6-р хороо	202	258	5.7
7	1-р хороо	184	251	5.5
8	3-р хороо	151	231	5.1
9	8-р хороо	148	215	4.7
10	18-р хороо	182	199	4.4
11	14-р хороо	157	191	4.2
12	11-р хороо	112	182	4.0
13	16-р хороо	153	165	3.6
14	13-р хороо	121	160	3.5
15	22-р хороо	88	133	2.9
16	9-р хороо	85	127	2.8
17	17-р хороо	132	126	2.8
18	12-р хороо	119	118	2.6
19	10-р хороо	69	101	2.2
20	19-р хороо	83	85	1.8
21	15-р хороо	87	83	1.8
22	21-р хороо	60	68	1.5
23	23-р хороо	48	63	1.4

Баянгол дүүргийн хэмжээнд 23 хороо байх бөгөөд хороо тус бүрт 2018 онд БГХ-ийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 7, 5, 20, 2, 11-р хороонд хамгийн их өссөн бол 15, 17, 12 дугаар хороонд буурсан байна. 2018 онд Баянгол дүүрэгт бүртгэгдсэн 4501 гэмт хэргийн 10.3%-ийг 20-р хороо дангаараа эзэлж байгаа нь анхаарал татаж байна.

Гэмт хэрэг хамгийн ихээр үйлдэгддэг гараг нь Баасан гараг байх бөгөөд энэ гарагт үйлдсэн гэмт хэрэг Даваа, Мягмар, Пүрэв гарагт үйлдсэн гэмт хэргээс бага хэмжээний буюу 0.4-0.2%-ийн зөрүүтэй байна. БГХ-ээс согтуугаар үйлдсэн 50 буюу 15.4%-иар, хүүхэд үйлдсэн 39 буюу 3 дахин тус тус буурсан эерэг үзүүлэлттэй байна.

Баянгол дүүрэгт өндөр үзүүлэлттэй бүртгэгдсэн болон зарим онцлог гэмт хэргийг төрлөөр нь харуулбал:

Эх сурвалж: ЦЕГ, Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын алба

№	Гэмт хэргийн төрөл	БГХ		Өсөлт, бууралтын хувь	Нийт гэмт хэрэгт эзлэх хувь
		2017 он	2018 он		
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	87	64	-26.4	1.4
	Үүнээс Хүнийг алах	16	14	-12.5	0.3
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	985	1023	3.9	22.7
	Үүнээс Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	17	10	-41.2	0.2
3	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	62	47	-24.2	1.0
	Үүнээс Хүчиндэх	26	43	65.4	1.0
4	Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг	4	24	6.0 дахин	0.5
5	Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг	3	2	-33.3	0.04
6	Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	7	5	-28.6	0.1
7	Хүүхдийн эсрэг гэмт хэрэг	1	7	7.0 дахин	0.2
8	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	1710	3114	82.1	69.2
	Үүнээс Хулгайлах	829	1465	76.7	32.5
	Залилах	511	1047	2.0 дахин	23.3
	Дээрэмдэх	206	272	32.0	6.0
9	Эдийн засгийн гэмт хэрэг	21	31	47.6	0.7
10	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	162	52	-3.1 дахин	1.2
11	Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг	21	19	-9.5	0.4
12	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	20	16	-20.0	0.4
13	Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг	6	4	-33.3	0.1
14	Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	8	4	-50.0	0.1
15	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	96	77	-19.8	1.7
	Үүнээс АТХХАБАЖ зөрчих	69	77	11.6	1.7

Баянгол дүүрэгт Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргээс Хулгайлах, Залилах, Дээрэмдэх гэмт хэргүүд, Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг тус тус хамгийн их дүнтэй байх бөгөөд эдгээр гэмт хэрэг нь Баянгол дүүрэгт БГХ-ийн 2695 буюу 59.8%-ийг эзэлж байна.

Хүүхдийн эсрэг гэмт хэрэг 1 бүртгэгдэж, Үндэсний аюулгүй байдлын эсрэг, Соёлын өвийн эсрэг, Хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг гэмт хэрэг тус бүр бүртгэгдээгүй байна.

Тодорхой төрлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа /2018 он/

ЭХХША-нд хамаарах БГХ, түүнийг хянасан, шийдвэрлэсэн талаарх нэгдсэн статистикийг ЭХТА-д хуульчлагдсан гэмт хэргийн бүлгээр, түлхүү үйлдэгддэг болон анхаарал татсан зарим гэмт хэргийг төрлөөр нь харуулбал:

Эх сурвалж: ЦЕГ, УЕПГ, ШЕЗ, ШШГЕГ

№	Гэмт хэргийн төрөл	ЦБ	ПБ		ШБ		ШШГБ ¹²
			2002	2015	2002	2015	
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг /10-р бүлэг/	64		307	-	15	-
	Үүнээс Хүнийг алах 91/10.1	14	0	16	-	12	-
	Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх 95/10.4	46	0	282	-	0	-
2	ХЭМХБЭГХ /11-р бүлэг/	1023		1427	-	659	-
	Үүнээс Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах 96/11.1	18	0	36	-	28	-
	Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулах 99/11.6	951	0	1271	-	558	-
3	Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх 120 ¹ /11.7	10	0	25	-	4	-
	ХБЭЧХБЭГХ /12-р бүлэг/	47		95	-	15	-
4	Үүнээс Хүчиндэх 126/12.1	43	0	85	-	15	-
	ХХЧБЭЭГХ /13-р бүлэг/	24		37	-	3	-
5	Үүнээс Хүн худалдаалах 113/13.1	1	0	8	-	0	-
	ХХУТЭЭЧЭГХ /14-р бүлэг/	2		0	-	0	-
6	Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг /15-р бүлэг/	5		13	-	0	-
7	Хүүхдийн эсрэг гэмт хэрэг /16-р бүлэг/	7		10	-	4	-
8	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг /17-р бүлэг/	3114		4531	--	160	-
	Үүнээс Хулгайлах 145/17.1	1465	2	2117	-	59	-
	Дээрэмдэх 146,147/17.2	272	0	406	-	14	-
	Залилах 148/17.3	1047	1	1454	-	52	-
9	Мал хулгайлах 17.12	0	-	1	-	0	-
	Эдийн засгийн гэмт хэрэг /18-р бүлэг/	31		33	-	2	-
10	ҮАБЭГХ /19-р бүлэг/	0		0	-	0	-
11	ОНАБАСЭГХ /20-р бүлэг/	52		21	-	22	-
	Үүнээс Олон нийтийн амгалан тайван байдал алдагдуулах 181/20.16	9	0	-	-	4	-
12	Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг /21-р бүлэг/	19		34	-	0	-
13	НААСЭГХ /23-р бүлэг/	16		20	-	5	-
14	ХБОЭГХ /24-р бүлэг/	4		1	-	6	-
15	Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг /25-р бүлэг/	0		0	-	0	-
16	ЦМАБЭГХ /26-р бүлэг/	4		15	-	1	-
17	ХАБТХАЖЭГХ /27-р бүлэг/	77		7	--	71	-
	Үүнээс АТХХАБАЖЗ гэмт хэрэг 215/27.10	77	0	-	-	71	-
18	Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг /28-р бүлэг/	0		0	-	0	-
19	ХТАБЭТЭГХ /29-р бүлэг/	0		0	-	0	-

¹² ШШГБ-ын хорих ял эдлүүлэх ажиллагаанд холбогдох статистик мэдээлэл нь нутаг дэвсгэрээр гардаггүй тул дээрх хүснэгтээр үзүүлэх тодорхой төрлийн гэмт хэрэгт хорих ялаар шийтгэгдэн хоригдож буй хүний мэдээллийг судалгааны багт ирүүлээгүй болно.

Баянгол дүүрэгт 2018 онд ЦБ-д 4501 гэмт хэрэг бүртгэгдэж, ПБ нь 2002 оны ЭХ-р 7, 2015 оны ЭХ-р 6521 гэмт хэрэгт тус тус ХБМБ-ын ажиллагаа явуулж, ШБ-аас 2015 оны ЭХ-р 965 эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэсэн байна.

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад ЦБ-д бүртгэгдсэн гэмт хэрэг 1297 буюу 40.5%-иар, ПБ-д нийт ХБМБ явуулсан хэрэг 3103 буюу 90.5%-иар тус тус өссөн байна.

Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс, нийгмийн байдал

Баянгол дүүрэгт 2018 онд БГХ 40.5%-иар өссөн хэдий ч түүнд холбогдон шалгагдсан хүний тоо 12.3%-иар буурсан эерэг дүнтэй байна.

Гэмт хэрэгт холбогдон шалгагдсан хүнд хамаарах хууль сахиулах болон шүүх эрх мэдлийн байгууллагын нэгдсэн статистикийг гэмт хэрэг үйлдсэн зарим онцлогийн хамт харуулбал:

Эх сурвалж: ЦЕГ, УЕПГ, ШЕЗ, ШШГЕГ

д/д	Үзүүлэлт	ЦБ		ПБ		ШБ		ШШГБ	
		Шалгагдсан бүгд		Яллагдсан бүгд		Ял шийтгүүлсэн бүгд		Хорих ял эдэлж байгаа бүгд	
		2017	2018	2017	2018	2017	2018	2017	2018
1	Нийт хүн	1581	1387	1348	1138	679	999	-	-
	Эрэгтэй	1293	1115	1028	896	578	831	-	-
	Эмэгтэй	298	272	311	221	101	168	-	-
	Хүүхэд	58	19	46	33	10	5	-	-
	14-15 нас	19	2	12	9	1	0	-	-
	16-17 нас	39	17	34	24	9	5	-	-
	18-24 нас	441	384	326	289	325	18-29 насны 515	-	-
	25-29 нас	366	290	312	235			-	-
	30-34 нас	254	262	200	212	116	175	-	-
	35-39 нас	155	138	151	119	228	35-дээш насны 304	-	-
	40-44 нас	123	143	106	75			-	-
	45-49 нас	86	58	72	58			-	-
	50-54 нас	52	51	39	46			-	-
	55-59 нас	28	31	22	18			-	-
	60-64 нас	12	11	5	4			-	-
	65-69 нас	3	0	3	0			-	-
	70-аас дээш	3	0	4	0			-	-
	Тодорхойгүй	-	-	62	47	-	-	-	-
2	Согтуугаар	316	276	-	-	-	71	-	-
3	Мансуурсан үедээ	20	46	-	-	-	0	-	-
4	Бүлэглэж	211	187	-	-	-	-	-	-
5	Галт зэвсгээр	0	1	-	-	-	-	-	-
6	Урьд ял шийтгүүлсэн	24	75	83	29	-	189	-	-

2018 онд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд холбогдон шалгагдсан бүгд тоог өмнөх онтой харьцуулахад ЦБ-ын мэдээллээр БГХ-т холбогдон шалгагдсан бүгд 1387 байгаа нь 194 буюу 12.2%-иар, ПБ-д 2018 онд үүсгэсэн хэрэг дэх яллагдсан бүгд 1138 байгаа нь 210 буюу 15.5%-иар тус тус буурсан эерэг үзүүлэлттэй байгаа бол ШБ-д ял шийтгүүлсэн бүгд 999 байна.

ЦБ-ын хэмжээнд БГХ-т нийт холбогдон шалгагдсан бүгд 1387 хүний 1115 буюу 90.4%-ийг эрэгтэй, 272 буюу 19.6%-ийг эмэгтэй, 19 буюу 1.3%-ийг хүүхэд, ШБ-аас ял шийтгүүлсэн

999 хүний 831 буюу 83.1%-ийг эрэгтэй, 168 буюу 16.9%-ийг эмэгтэй, 5 буюу 0.5%-ийг хүүхэд тус тус эзэлж байна.

Гэмт хэрэгт хамаарах зарим онцлогийг өмнөх онтой харьцуулахад ЦБ-ын хэмжээнд шалгагдсан хүний 19.8% нь согтуурсан үедээ, 3.3% нь мансуурсан үедээ, 13.4% нь бүлэглэж, 0.07% нь галт зэвсэг хэрэглэн, 5.4% нь урьд ял шийтгүүлж байсан холбогдогч тус тус эзэлж байгаа бол ШБ-аас ял шийтгүүлсэн хүний 7.1% нь согтуугаар, 1 хүн буюу 18.9% нь урьд ял шийтгүүлсэн хүн байна.

ЦБ-ын мэдээллээр мансуурсан үедээ гэмт хэрэгт холбогдон шалгагдсан хүний тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад 26 буюу 2.3 дахин их байгаа нь анхаарал татаж байгаа бол урьд ял шийтгүүлсэн холбогдогчийн тоо 51 буюу 3.1 дахин, согтуурсан үедээ гэмт хэрэг үйлдсэн холбогдогчийн тоо 40 буюу 12.6%-иар тус тус буурсан эерэг үзүүлэлт гарчээ.

Гэмт хэргийн хохирогч, хохирол

Баянгол дүүрэгт 9419 хүн, 1 хуулийн этгээд хохирсон байна. Бүртгэгдсэн гэмт хэргийн хохирогч, хохирол түүнд хамаарах нэгдсэн статистикийг харуулбал:

Эх сурвалж: ЦЕГ, УЕПГ, ШЕЗ

Үзүүлэлт	ЦБ		ПБ		ШБ	
	2017 он	2018 он	2017 он	2018 он	2017 он	2018 он
Хүн	9419	3894	1140	2144	-	1017
Эрэгтэй	3081	2101	351	1078	-	
Эмэгтэй	6338	1793	789	1066	-	422
Хүүхэд	182	152	30	73	-	44
18-24 нас	879	642	159	341	-	183
25-29 нас	1571	750	188	405	-	209
30-34 нас	1630	703	215	383	-	219
35-39 нас	1288	511	148	280	-	127
40-44 нас	1147	372	114	208	-	90
45-49 нас	861	273	100	175	-	45
50-54 нас	778	208	56	119	-	45
55-59 нас	568	134	58	70	-	26
60-64 нас	246	76	20	37	-	9
65-69 нас	146	27	10	19	-	4
70-аас дээш	123	46	7	24	-	16
Нас барсан	82	49	79	74	-	15
Гэмтсэн	1201	994	678	692	-	779
Хуулийн этгээд	1	2	12	1	-	4
Учирсан хохирол	76576.1	31893.7	-	-	-	2626.6
Нөхөн төлүүлсэн хохирол	26069.1	3374.9	-	-	-	2281.6

2018 онд Баянгол дүүрэгт БГХ-ийн улмаас хохирсон хохирогчийн насны бүлгүүд дэх дүнг харвал бүх насны ангилалд 2-5 дахин буурсан байна. Мөн 2018 онд эмэгтэй хохирогчийн тоо өмнөх оныхоос 3.5 дахин буурчээ.

3. БАЯНЗҮРХ ДҮҮРЭГ

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа

2018 онд Баянзүрх дүүрэг дэх цагдаагийн хэлтсүүд нь иргэд, хуулийн этгээдээс 27219 гомдол, мэдээлэл хүлээн авснаас 13089 буюу 48.1%-ийг гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл эзэлж байгаа бөгөөд гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээллээс 7522 буюу 57.4% нь бүртгэгдсэн байна.

Прокурорын байгууллага нийт 16560 хэрэгт ХБМБ-ын ажиллагаа, тухайн жилд шинээр үүссэн 10153 хэрэгт ХБМБ тус тус явуулсан нь өмнөх оны мөн үеэс нийт ХБМБ явуулсан хэрэг 72%-иар, тухайн жилд ХБМБ явуулсан хэрэг 59.4%-иар өсжээ. Мөн 2018 онд 5010 хэргийн хэрэг бүртгэлтийг хааж, 643 хэргийг нэгтгэж, 49 хэргийг хэрэгсэхгүй болгож, 1696 хэргийг шүүхэд шилжүүлж, хэрэг бүртгэлтийн 9094, мөрдөн байцаалтын 77 хэргийн тус тус үлдэгдэлтэй, тухайн жилд үүсгэсэн хэрэгт 2071 яллагдагч ялагдсан байна.

Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх 2015 оны Эрүүгийн хуулиар 1709 хэргийг хянан шийдвэрлэж, 1767 хүнд ял оногдуулснаас 396 хүнийг хорих, 227 хүнийг нийтэд тустай ажил хийлгэх ялаар, 1144 хүнийг торгох ялаар тус тус шийтгэсэн байна.

Шийдвэр гүйцэтгэх байгууллагад Баянзүрх дүүрэгт харьяалалтай 290 хоригдол 2018 онд ял эдэлж байна.

Бүртгэгдсэн гэмт хэрэг

2018 онд Баянзүрх дүүрэгт 7522 буюу улсын хэмжээнд БГХ-ийн 20.7% нь бүртгэгдсэн бөгөөд өмнөх оны мөн үеэс бүртгэгдсэн гэмт хэрэг 1583 буюу 26.6%-иар өссөн¹³ байна. Баянзүрх дүүрэгт БГХ-ийн хураангуй мэдээлэл болон тоон үзүүлэлтийг хороо тус бүрээр буурах дарааллын дагуу хүснэгтээр үзүүлбэл:

Хураангуй:

- Улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэрэгт эзлэх хувь **20.7**
- Улаанбаатар хотод эзлэх хувь **29.3**
- Хамгийн их бүртгэгдсэн **14-р хороо**
- Хамгийн бага бүртгэгдсэн **28-р хороо**
- Хороодын дундаж нь **268.6**
- Гэмт хэрэг хамгийн их үйлдэгддэг газар **Гэр орон сууц**
- Гэмт хэрэг хамгийн их үйлдэгддэг гараг **Даваа**
- Гэмт хэрэг хамгийн их үйлдэгддэг цаг **14-19**
- Гэмт хэрэг хамгийн ихээр үйлдэж байгаа хүний нас **18-24**
- Согтуугаар үйлдсэн **396**
- Эмэгтэй хүн үйлдсэн **341**
- Хүүхэд үйлдсэн **136**
- Хохирогч иргэн **7098**
- Нас барсан **105**
- Гэмтсэн **1502**
- Хохирлын дүн **38700.6 сая**
- Нөхөн төлүүлсэн хэмжээ **3496.6 сая**
- Хамгийн их бүртгэгдсэн гэмт хэрэг **Хулгайлах**

№	Хороо	2017	2018	Эзлэх хувь
1	14-р хороо	519	736	9.78
2	5-р хороо	359	442	5.88
3	4-р хороо	313	413	5.49
4	26-р хороо	174	397	5.28
5	1-р хороо	207	394	5.24
6	7-р хороо	266	392	5.21
7	16-р хороо	258	376	5.00
8	6-р хороо	262	371	4.93
9	22-р хороо	269	347	4.61
10	8-р хороо	305	307	4.08
11	2-р хороо	243	289	3.84
12	11-р хороо	231	257	3.42
13	25-р хороо	176	246	3.27
14	3-р хороо	198	239	3.18
15	13-р хороо	194	235	3.12
16	27-р хороо	204	216	2.87
17	15-р хороо	158	201	2.67
18	18-р хороо	192	199	2.65
19	21-р хороо	184	199	2.65
20	12-р хороо	188	176	2.34
21	23-р хороо	164	171	2.27
22	19-р хороо	158	158	2.10
23	10-р хороо	104	140	1.86
24	9-р хороо	136	137	1.82
25	20-р хороо	160	135	1.79
26	24-р хороо	95	131	1.74
27	17-р хороо	109	124	1.65
28	28-р хороо	113	94	1.25

¹³ 2016-2017 онд 1721 буюу 40.8%-иар өссөн дүнтэй байжээ.

Баянзүрх дүүрэгт 28 хороо байх бөгөөд хороо тус бүр дэх 2018 онд БГХ-ийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1, 7, 16, 14-р хороонд хамгийн их өссөн бол 12, 20, 28 дугаар хороонд буурсан байна. 2018 онд Баянгол дүүрэгт бүртгэгдсэн 7522 гэмт хэргийн 9.7%-ийг 14-р хороо дангаараа эзэлж байгаа нь хамгийн өндөр дүнтэй байна.

Гэмт хэрэг хамгийн ихээр үйлдэгддэг гараг нь Даваа гараг байх бөгөөд энэ гарагт үйлдсэн гэмт хэрэг Лхагва, Пүрэв, Баасан гарагт үйлдсэн гэмт хэргээс 0.6-1%-ийн зөрүүтэй байна.

Баянзүрх дүүрэгт өндөр үзүүлэлттэй бүртгэгдсэн болон зарим онцлог гэмт хэргийг төрлөөр нь харуулбал:

Эх сурвалж: ЦЕГ, Мэдээлэл дүн шинжилгээ, шуурхай удирдлагын алба

№	Гэмт хэргийн төрөл	БГХ		Өсөлт, бууралтын хувь	Нийт гэмт хэрэгт эзлэх хувь
		2017 он	2018 он		
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	130	104	-20.0	1.4
	Үүнээс: Хүнийг алах	25	22	-12.0	0.3
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	1344	1620	21.5	21.5
	Үүнээс: Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	14	26	85.7	0.3
3	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	67	90	34.3	1.2
	Үүнээс: Хүчиндэх	51	77	51.0	1.0
4	Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг	10	19	90.0	0.2
5	Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг	2	1	-50.0	0.01
6	Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	6	7	16.7	0.1
7	Хүүхдийн эсрэг гэмт хэрэг	2	4	2.0 дахин	0.05
8	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	3984	5391	35.3	71.8
Үүнээс	Хулгайлах	2678	3198	19.4	42.5
	Залилах	635	1201	89.1	16.0
	Дээрэмдэх	337	533	58.2	7.1
	Мал хулгайлах	16	23	43.8	0.3
9	Эдийн засгийн гэмт хэрэг	23	47	2.0 дахин	0.6
10	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	169	53	-68.6	0.7
11	Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг	12	15	25.0	0.2
12	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	21	24	14.3	0.3
13	Хүрээлэн байгаа орчны эсрэг	7	2	-71.4	0.02
14	Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	8	12	4	0.2
15	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	137	108	-21.2	1.4
	Үүнээс: Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих	108	106	-1.9	1.4
16	Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг	-	2	-	0.02

Баянзүрх дүүрэгт Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргээс Хулгайлах, Залилах, Дээрэмдэх гэмт хэргүүд, Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг тус тус хамгийн их дүнтэй байх бөгөөд эдгээр гэмт хэрэг нь Баянзүрх дүүрэгт БГХ-ийн 7011 буюу 93.2%-ийг эзэлж байна.

Хүний хувийн, улс төрийн эрх эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг 1 бүртгэгдэж, Үндэсний аюулгүй байдлын эсрэг, Соёлын өвийн эсрэг, Хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг гэмт хэрэг тус бүр бүртгэгдээгүй байна. Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг БГХ-ийн дүнг өмнөх оныхтой харьцуулбал 68.6%-иар буурсан эерэг үзүүлэлт гарчээ.

Тодорхой төрлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа /2018 он/

ЭХХША-нд хамаарах БГХ, түүнийг хянасан, шийдвэрлэсэн талаарх нэгдсэн статистикийг ЭХТА-д хуульчлагдсан гэмт хэргийн бүлгээр, түлхүү үйлдэгддэг болон анхаарал татсан зарим гэмт хэргийг төрлөөр нь харуулбал:

Эх сурвалж: ЦЕГ, УЕПГ, ШЕЗ, ШШГЕГ

№	Гэмт хэргийн төрөл	ЦБ	ПБ		ШБ		ШШГБ ¹⁴
			2002	2015	2002	2015	
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг /10-р бүлэг/	104		529	-	24	-
	Хүнийг алах 91/10.1	22		32	-	21	-
	Үүнээс Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх 95/10.4	78		480	-	0	-
2	ХЭМХБЭГХ /11-р бүлэг/	1620		2204	-	1071	-
	Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах 96/11.1	20		47	-	51	-
	Үүнээс Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулах 99/11.6	1520		1991	-	907	-
	Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх 120 ¹ /11.7	26		37	-	16	-
3	ХБЭЧХБЭГХ /12-р бүлэг/	90		153	-	36	-
	Үүнээс Хүчиндэх 126/12.1	77		135	-	33	-
4	ХХЧБЭЭГХ /13-р бүлэг/	19		34	-	1	-
	Үүнээс Хүн худалдаалах 113/13.1	2		2	-	0	-
5	ХХУТЭЭЧЭГХ /14-р бүлэг/	1		2	-	0	-
6	Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг /15-р бүлэг/	7		14	-	1	-
7	Хүүхдийн эсрэг гэмт хэрэг /16-р бүлэг/	4		11	-	1	-
8	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг /17-р бүлэг/	5391	20	7042	-	445	-
	Хулгайлах 145/17.1	3198	12	4068	-	198	-
	Үүнээс Дээрэмдэх 146,147/17.2	533	6	594	-	73	-
	Залилах 148/17.3	1201	4	1651	-	91	-
	Мал хулгайлах 17.12	23		21	-	1	-
9	Эдийн засгийн гэмт хэрэг /18-р бүлэг/	47		60	-	6	-
10	ҮАБЭГХ /19-р бүлэг/	0		1	-	1	-
11	ОНАБАСЭГХ /20-р бүлэг/	53		39	-	28	-
	Үүнээс Олон нийтийн амгалан тайван байдал алдагдуулах 181/20.16	5		8	-	2	-
12	Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг /21-р бүлэг/	15		39	-	7	-
13	НААСЭГХ /23-р бүлэг/	24		36	-	2	-
14	ХБОЭГХ /24-р бүлэг/	2		5	-	1	-
15	Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг /25-р бүлэг/	0		1	-	0	-
16	ЦМАБЭГХ /26-р бүлэг/	12		9	-	0	-

¹⁴ ШШГБ-ын хорих ял эдлүүлэх ажиллагаанд холбогдох статистик мэдээлэл нь нутаг дэвсгэрээр гардаггүй тул дээрх хүснэгтээр үзүүлэх тодорхой төрлийн гэмт хэрэгт хорих ялаар шийтгэгдэн хоригдож буй хүний мэдээллийг судалгааны багт ирүүлээгүй болно.

17	ХАБТХАЖЭГХ /27-р бүлэг/ Үүнээс АТХХАБАЖЗ гэмт хэрэг 215/27.10	108 106	8 7	- -	81 81	- -
18	Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг /28-р бүлэг/	2	3	-	1	-
19	ХТАБЭТЭГХ /29-р бүлэг/	0	0	-	0	-

Баянзүрх дүүрэгт дэх Цагдаагийн байгууллагад 7522 гэмт хэрэг бүртгэгдэж, Прокурорын байгууллага нь 2002 оны ЭХ-р 20, 2015 оны ЭХ-р 10134 гэмт хэрэгт тус тус ХБМБ-ын ажиллагаа явуулж, Шүүх байгууллагаас 2015 оны ЭХ-р 1709 эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэсэн байна.

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад ЦБ-д бүртгэгдсэн гэмт хэрэг 1583 буюу 26.7%-иар, ПБ-д нийт ХБМБ явуулсан хэрэг 3780 буюу 59.3%-иар тус тус өссөн байна.

Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс, нийгмийн байдал

2018 онд Баянзүрх дүүрэгт БГХ 26.7%-иар, холбогдон шалгагдсан хүний тоо 92 буюу 4.5%-иар өссөн байна.

Гэмт хэрэгт холбогдон шалгагдсан хүнд хамаарах хууль сахиулах болон шүүх эрх мэдлийн байгууллагын нэгдсэн статистикийг гэмт хэрэг үйлдсэн зарим онцлогийн хамт харуулбал:

Эх сурвалж: ЦЕГ, УЕПГ, ШЕЗ, ШШГЕГ

д/д	Үзүүлэлт	ЦБ		ПБ		ШБ		ШШГБ	
		Шалгагдсан бүгд		Яллагдсан бүгд		Ял шийтгүүлсэн бүгд		Хорих ял эдэлж байгаа бүгд	
		2017	2018	2017	2018	2017	2018	2017	2018
1	Нийт хүн	2027	2119	1895	2071	890	1767	-	-
	Эрэгтэй	1709	1778	1537	1757	769	1552	-	-
	Эмэгтэй	318	341	358	313	121	215	-	-
	Хүүхэд	112	136	116	117	32	41	-	-
	14-15 нас	33	60	33	43	9	10	-	-
	16-17 нас	79	76	83	74	23	31	-	-
	18-24 нас	459	486	381	510	441	18-29 насны 772	-	-
	25-29 нас	438	403	414	381			-	-
	30-34 нас	372	380	332	334	174	443	-	-
	35-39 нас	211	219	213	231			-	-
	40-44 нас	186	218	155	172			-	-
	45-49 нас	112	135	104	141			-	-
	50-54 нас	81	64	78	71	243	35-дээш насны 511	-	-
	55-59 нас	34	41	33	44			-	-
	60-64 нас	16	28	11	18			-	-
	65-69 нас	5	8	4	7			-	-
	70-аас дээш	1	1	3	3			-	-
	Тодорхойгүй	-	-	43	19	-	-	-	-
2	Согтуугаар	351	396	-	-	-	341	-	-
3	Мансуурсан үедээ	14	42	-	-	-	0	-	-
4	Бүлэглэж	211	243	-	-	-	-	-	-
5	Галт зэвсгээр	0	1	-	-	-	-	-	-
6	Урьд ял шийтгүүлсэн	29	106	129	134	-	232	-	-

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд 2018 онд холбогдон шалгагдсан бүгд тоог өмнөх онтой харьцуулахад ЦБ-ын мэдээллээр БГХ-т холбогдон шалгагдсан бүгд 2119 байгаа нь 95 буюу 4.6%-иар, ПБ-д 2018 онд үүсгэсэн хэрэг дэх яллагдсан бүгд 2071 байгаа нь 176 буюу 9.2%-иар тус тус өссөн байгаа бол ШБ-д ял шийтгүүлсэн бүгд 1767 байна.

ЦБ-ын хэмжээнд БГХ-т нийт холбогдон шалгагдсан бүгд 2119 хүний 1778 буюу 83.9%-ийг эрэгтэй, 341 буюу 16%-ийг эмэгтэй, 136 буюу 6.4%-ийг хүүхэд, ШБ-аас ял шийтгүүлсэн 1767 хүний 1552 буюу 87.8%-ийг эрэгтэй, 215 буюу 12.2%-ийг эмэгтэй, 41 буюу 2.3%-ийг хүүхэд тус тус эзэлж байна.

Гэмт хэрэгт хамаарах зарим онцлогийг өмнөх онтой харьцуулахад ЦБ-ын хэмжээнд шалгагдсан хүний 18.6% нь согтуурсан үедээ, 1.9% нь мансуурсан үедээ, 11.4% нь бүлэглэж, 0.04% нь галт зэвсэг хэрэглэн, 5% нь урьд ял шийтгүүлж байсан холбогдогч тус тус эзэлж байгаа бол ШБ-аас ял шийтгүүлсэн хүний 19.2% нь согтуугаар, 232 хүн буюу 13.1% нь урьд ял шийтгүүлсэн хүн байна.

ЦБ-ын мэдээллээр мансуурсан үедээ гэмт хэрэгт холбогдон шалгагдсан хүний тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад 28 буюу 3 дахин их, урьд ял шийтгүүлсэн холбогдогчийн тоо 77 буюу 3.6 дахин, согтуурсан үедээ гэмт хэрэг үйлдсэн холбогдогчийн тоо 45 буюу 12.8%-иар тус тус өссөн нь анхаарал татаж байна.

Гэмт хэргийн хохирогч, хохирол

ЦБ-ын мэдээллээр Баянзүрх дүүрэгт 7098 хүн, 6 хуулийн этгээд хохирсон байна. ГХ-ийн хохирогч, хохирлын талаарх хууль сахиулах болон шүүх эрх мэдлийн байгууллагын нэгдсэн статистикийг харуулбал:

Эх сурвалж: ЦЕГ, УЕПГ, ШЕЗ

Үзүүлэлт	ЦБ		ПБ		ШБ		
	2017 он	2018 он	2017 он	2018 он	2017 он	2018 он	
Хүн	5281	7098	4974	8875	-	1846	
үүнээс	Эрэгтэй	2784	3779	2153	4544	-	1181
	Эмэгтэй	2497	3319	2821	4331	-	665
	Хүүхэд	275	366	175	364	-	111
	18-24 нас	752	1085	667	1328	-	349
	25-29 нас	959	1284	829	1546	-	409
	30-34 нас	876	1225	862	1532	-	461
	35-39 нас	676	878	651	1138	-	247
	40-44 нас	541	747	544	921	-	123
	45-49 нас	445	549	417	680	-	55
	50-54 нас	333	408	313	542	-	47
	55-59 нас	214	291	222	393	-	34
	60-64 нас	102	147	120	211	-	7
	65-69 нас	63	65	56	78	-	1
	70-аас дээш	45	53	72	81	-	2
	Нас барсан	156	105	334	413	-	56
	Гэмтсэн	1589	1502	1552	1965	-	1213
	Хуулийн этгээд	10	6	0	1	-	1
Учирсан хохирол	36096.8	38700.6	-	-	-	8690.7	
Нөхөн төлүүлсэн хохирол	22097.2	3496.6	-	-	-	6158.2	

2018 онд Баянзүрх дүүрэг дэх ЦБ-д БГХ-ийн улмаас хохирсон хохирогчийн насны бүлгүүд дэх дүнг харвал бүх насны ангилалд өссөн дүнтэй байгаа нь анхаарал татаж байгаа бол нас барсан хохирогч 32.6%-иар, гэмтсэн хүний тоо 5.4%-иар, хохирсон хуулийн этгээдийн тоо 40%-иар тус тус буурсан эерэг дүн гарчээ.

4. СОНГИНОХАЙРХАН ДҮҮРЭГ

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа

2018 онд Сонгинохайрхан дүүрэг дэх цагдаагийн хэлтсүүд нь иргэд, хуулийн этгээдээс 16921 гомдол, мэдээлэл хүлээн авснаас 9018 буюу 53.3 хувь нь гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл эзэлж байгаа бөгөөд гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээллээс 3692 буюу 40.9 хувь нь бүртгэгдсэн байна.

Прокурорын байгууллага нийт 9096 хэрэгт ХБМБ-ын ажиллагаа, тухайн жилд шинээр үүссэн 5839 хэрэгт ХБМБ тус тус явуулсан нь өмнөх оны мөн үеэс нийт ХБМБ явуулсан хэрэг 71.6 хувиар, тухайн жилд ХБМБ явуулсан хэрэг 66.2 хувиар өсжээ. Мөн 2018 онд 3278 хэргийн хэрэг бүртгэлтийг хааж, 612 хэргийг нэгтгэж, 81 хэргийг хэрэгсэхгүй болгож, 1052 хэргийг шүүхэд шилжүүлж, хэрэг бүртгэлтийн 3866, мөрдөн байцаалтын 184 хэргийн тус тус үлдэгдэлтэй, тухайн жилд үүсгэсэн хэрэгт 1434 яллагдагч яллагдсан байна.

Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх 2015 оны Эрүүгийн хуулиар 1110 хэргийг хянан шийдвэрлэж, 1113 хүнд ял оногдуулснаас 375 хүнийг хорих, 214 хүнийг нийтэд тустай ажил хийлгэх ялаар, 524 хүнийг торгох ялаар тус тус шийтгэсэн байна.

Шийдвэр гүйцэтгэх байгууллагад Сонгинохайрхан дүүрэгт харьяалалтай 344 хоригдол 2018 онд ял эдэлж байна.

Бүртгэгдсэн гэмт хэрэг

2018 онд Сонгинохайрхан дүүрэгт 3692 буюу нийт гэмт хэргийн 10.4 хувь нь бүртгэгдсэн бөгөөд өмнөх оны мөн үеэс БГХ 1 буюу 0.03 хувиар өссөн байна. Сонгинохайрхан дүүрэгт БГХ-ийн хураангуй мэдээлэл болон тоон үзүүлэлтийг хороо тус бүрээр буурах дарааллын дагуу хүснэгтээр үзүүлбэл:

Хураангуй:

- Улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэрэгт эзлэх хувь **21.8**
- Улаанбаатар хотод эзлэх хувь **30.8**
- Хамгийн их бүртгэгдсэн **22-р хороо**
- Хамгийн бага бүртгэгдсэн **28-р хороо**
- Хороодын дундаж нь **246.9**
- Гэмт хэрэг хамгийн их үйлдэгддэг газар **Гэр орон сууц**
- Гэмт хэрэг хамгийн их үйлдэгддэг гараг **Даваа**
- Гэмт хэрэг хамгийн их үйлдэгддэг цаг **22-06**
- Гэмт хэрэг хамгийн ихээр үйлдэж байгаа хүний нас **18-24**
- Согтуугаар үйлдсэн **357**
- Эмэгтэй хүн үйлдсэн **223**
- Хүүхэд үйлдсэн **104**
- Хохирогч иргэн **3617**
- Нас барсан **117**
- Гэмтсэн **978**
- Хохирлын дүн **7506.8 сая**
- Нөхөн төлүүлсэн хэмжээ **2271.1 сая**
- Хамгийн их бүртгэгдсэн гэмт хэрэг **Хулгайлах**

№	Хороо	2017	2018	Эзлэх хувь
1	22-р хороо	256	264	7.15
2	6-р хороо	117	194	5.25
3	29-р хороо	176	187	5.07
4	32-р хороо	141	164	4.44
5	26-р хороо	183	154	4.17
6	1-р хороо	160	148	4.01
7	7-р хороо	179	147	3.98
8	21-р хороо	109	145	3.93
9	24-р хороо	147	136	3.68
10	19-р хороо	169	134	3.63
11	14-р хороо	106	129	3.49
12	20-р хороо	166	120	3.25
13	2-р хороо	134	116	3.14
14	25-р хороо	122	115	3.11
15	31-р хороо	130	112	3.03
16	18-р хороо	105	109	2.95
17	3-р хороо	76	108	2.93
18	9-р хороо	70	96	2.60
19	12-р хороо	101	94	2.55
20	23-р хороо	127	93	2.52
21	5-р хороо	62	92	2.49
22	16-р хороо	85	90	2.44
23	4-р хороо	58	88	2.38
24	17-р хороо	75	88	2.38
25	11-р хороо	96	86	2.33
26	13-р хороо	96	84	2.28
27	15-р хороо	92	81	2.19
28	27-р хороо	92	81	2.19
29	30-р хороо	84	65	1.76
30	8-р хороо	59	64	1.73
31	10-р хороо	58	59	1.60
32	28-р хороо	60	49	1.33

Сонгинохайрхан дүүрэгт 32 хороо байх бөгөөд хороо тус бүр дэх 2018 онд БГХ-ийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3, 4, 5, 6, 21-р хороонуудад хамгийн их өссөн бол 7, 19, 20, 23-р хороонд буурсан байна. 2018 онд Сонгинохайрхан дүүрэгт бүртгэгдсэн 7903 гэмт хэргийн 7.1 хувийг 22-р хороо дангаараа эзэлж байгаа нь хамгийн өндөр дүнтэй байна.

Гэмт хэрэг хамгийн ихээр үйлдэгддэг гараг нь Даваа гараг байх бөгөөд энэ гарагт үйлдсэн гэмт хэрэг Лхагва, Пүрэв, Баасан гарагт үйлдсэн гэмт хэргээс 0.6-5.1 хувийн зөрүүтэй байна.

Сонгинохайрхан дүүрэгт өндөр үзүүлэлттэй бүртгэгдсэн болон зарим онцлог гэмт хэргийг төрлөөр нь харуулбал:

Эх сурвалж: ЦЕГ, Мэдээлэл дүн шинжилгээ, шуурхай удирдлагын алба

№	Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн хэрэг		Өсөлт, бууралтын хувь	Нийт гэмт хэрэгт эзлэх хувь
		2017 он	2018 он		
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	94	103	9.6	2.8
	Үүнээс: Хүнийг алах	32	30	-6.3	0.8
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	876	981	12.0	26.6
	Үүнээс: Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	38	26	-31.6	0.7
3	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	60	79	31.7	2.1
	Үүнээс: Хүчиндэх	41	69	68.3	1.9
4	Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг	5	5	0.0	0.1
5	Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг	4	-	-	-
6	Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	4	-	-	-
7	Хүүхдийн эсрэг гэмт хэрэг	4	4	0.0	0.1
8	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	2262	2340	3.4	63.4
	Үүнээс: Хулгайлах	1630	1474	-9.6	39.9
	Залилах	286	487	70.3	13.2
	Дээрэмдэх	190	199	4.7	5.4
	Мал хулгайлах	15	27	80.0	0.7
9	Эдийн засгийн гэмт хэрэг	38	23	-39.5	0.7
10	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	135	25	-81.5	0.8
11	Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг	9	5	-44.4	0.1
12	Авлигын гэмт хэрэг	7	8	14.3	0.2
13	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	14	9	-35.7	0.2
14	Хүрээлэн байгаа орчны эсрэг	11	5	-54.5	0.1
15	Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг	-	1	-	-
16	Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	1	3	3.0 дахин	0.1
17	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	167	101	-39.5	2.7
	Үүнээс: Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих	133	98	-26.3	2.7

Тодорхой төрлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа /2018 он/

ЭХХША-нд хамаарах БГХ, түүнийг хянасан, шийдвэрлэсэн талаарх нэгдсэн статистикийг ЭХТА-д хуульчлагдсан гэмт хэргийн бүлгээр, түлхүү үйлдэгддэг болон анхаарал татсан зарим гэмт хэргийг төрлөөр нь харуулбал:

Эх сурвалж: ЦЕГ, УЕПГ, ШЕЗ, ШШГЕГ

№	Гэмт хэргийн төрөл	ЦБ	ПБ		ШБ		ШШГБ
			2002	2015	2002	2015	
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг /10-р бүлэг/	103		534	-	33	-
	Хүнийг алах 91/10.1	30		33	-	29	-
	Үүнээс Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх 95/10.4	71		492	-		-
2	ХЭМХБЭГХ /11-р бүлэг/	981		1380	-	659	-
	Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах 96/11.1	34		41	-	47	-
	Үүнээс Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулах 99/11.6	897		1212	-	542	-
	Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх 120 ¹ /11.7	26		50	-	9	-
3	ХБЭЧХБЭГХ /12-р бүлэг/	79		145	-	32	-
	Үүнээс Хүчиндэх 126/12.1	69		132	-	28	-
4	ХХЧБЭЭГХ /13-р бүлэг/	5		16	-	1	-
	Үүнээс Хүн худалдаалах 113/13.1	2		1	-		-
5	ХХУТЭЭЧЭГХ /14-р бүлэг/			1	-		-
6	Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг /15-р бүлэг/				-		-
7	Хүүхдийн эсрэг гэмт хэрэг /16-р бүлэг/	4		6	-	1	-
8	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг /17-р бүлэг/	2340		3682	--	143	-
	Хулгайлах 145/17.1	1474	4	2348	-	45	-
	Дээрэмдэх 146,147/17.2	199		307	-	28	-
	Залилах 148/17.3	487	2	673	-	2	-
	Мал хулгайлах 17.12	27		39	-	265	-
9	Эдийн засгийн гэмт хэрэг /18-р бүлэг/	23		36	-		-
10	ҮАБЭГХ /19-р бүлэг/				-		-
11	ОНАБАСЭГХ /20-р бүлэг/	25		40	-	13	-
	Үүнээс Олон нийтийн амгалан тайван байдал алдагдуулах 181/20.16	9		12	-	1	-
12	Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг /21-р бүлэг/	5		19	-		-
13	НААСЭГХ /23-р бүлэг/	9		13	-	6	-
14	ХБОЭГХ /24-р бүлэг/	5		9	-	6	-
15	Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг /25-р бүлэг/	1		0	-		-
16	ЦМАБЭГХ /26-р бүлэг/	3		3	-		-
17	ХАБТХАЖЭГХ /27-р бүлэг/	101		9	--	93	-
	Үүнээс АТХХАБАЖЗ гэмт хэрэг 215/27.10	98		8		93	-
18	Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг /28-р бүлэг/			2	-	1	-
19	ХТАБЭТЭГХ /29-р бүлэг/				-		-

2018 онд Сонгинохайрхан дүүрэг дэх Цагдаагийн байгууллагад 3692 гэмт хэрэг бүртгэгдэж, Прокурорын байгууллага нь 2002 оны ЭХ-р 6, 2015 оны ЭХ-р 5835 гэмт хэрэгт тус тус ХБМБ-ын ажиллагаа явуулж, Шүүх байгууллагаас 2015 оны ЭХ-р 1110 эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэсэн байна.

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад ЦБ-д бүртгэгдсэн гэмт хэрэг 1 буюу 0.03%-иар, ПБ-д нийт ХБМБ явуулсан хэрэг 2319 буюу 65.8%-иар тус тус өссөн байна.

Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс, нийгмийн байдал

2018 онд Сонгинохайрхан дүүрэгт БГХ 0.03%-иар өссөн бол холбогдон шалгагдсан хүний тоо 3.2%-иар буурсан байна.

Гэмт хэрэгт холбогдон шалгагдсан хүнд хамаарах хууль сахиулах болон шүүх эрх мэдлийн байгууллагын нэгдсэн статистикийг гэмт хэрэг үйлдсэн зарим онцлогийн хамт харуулбал:

Эх сурвалж: ЦЕГ, УЕПГ, ШЕЗ, ШШГЕГ

д/д	Үзүүлэлт	ЦБ		ПБ		ШБ		ШШГБ	
		Шалгагдсан бүгд		Яллагдсан бүгд		Ял шийтгүүлсэн бүгд		Хорих ял эдэлж байгаа бүгд	
		2017	2018	2017	2018	2017	2018	2017	2018
1	Нийт хүн	1689	1635	1245	1434	626	1113	-	-
	Эрэгтэй	1477	1412	1010	1209	579	1040	-	-
	Эмэгтэй	212	223	235	222	47	73	-	-
	Хүүхэд	116	104	65	105	12	16	-	-
	14-15 нас	33	53	17	52	1	0	-	-
	16-17 нас	83	51	48	53	11	16	-	-
	18-24 нас	422	340	267	260	297	18-29 насны 487	-	-
	25-29 нас	363	316	239	272			-	-
	30-34 нас	228	303	181	245	114	336	-	-
	35-39 нас	191	195	163	168	203	35-дээш насны 274	-	-
	40-44 нас	168	171	115	148			-	-
	45-49 нас	99	121	74	100			-	-
	50-54 нас	51	63	34	57			-	-
	55-59 нас	34	14	25	14			-	-
	60-64 нас	11	3	8	5			-	-
	65-69 нас	1	2	1	0			-	-
	70-аас дээш	5	3	4	5	-	-		
	Тодорхойгүй	-	-	64	30	-	-	-	-
2	Согтуугаар	309	357	-	-	-	376	-	-
3	Мансуурсан үедээ	10	9	-	-	-	1	-	-
4	Бүлэглэж	192	134	-	-	-	-	-	-
5	Галт зэвсгээр	2	0	-	-	-	-	-	-
6	Урьд ял шийтгүүлсэн	92	151	107	41	-	183	-	-

2018 онд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд холбогдон шалгагдсан бүгд тоог өмнөх онтой харьцуулахад ЦБ-ын мэдээллээр БГХ-т холбогдон шалгагдсан бүгд 1635 байгаа нь 54 буюу 3.2%-иар, ПБ-д 2018 онд үүсгэсэн хэрэг дэх яллагдсан бүгд 1434 байгаа нь 189 буюу 15.1%-иар тус тус өссөн байгаа бол ШБ-д ял шийтгүүлсэн бүгд 1113 байна.

ЦБ-ын хэмжээнд БГХ-т нийт холбогдон шалгагдсан бүгд 1635 хүний 1412 буюу 86.3%-ийг эрэгтэй, 223 буюу 13.7%-ийг эмэгтэй, 104 буюу 6.3%-ийг хүүхэд, ШБ-аас ял шийтгүүлсэн 1113 хүний 1040 буюу 93.4%-ийг эрэгтэй, 73 буюу 6.6%-ийг эмэгтэй, 16 буюу 1.4%-ийг хүүхэд тус тус эзэлж байна.

Гэмт хэрэгт хамаарах зарим онцлогийг өмнөх онтой харьцуулахад ЦБ-ын хэмжээнд шалгагдсан хүний 21.8% нь согтуурсан үедээ, 1.8% нь мансуурсан үедээ, 8.1% нь бүлэглэж,

9.2% нь урьд ял шийтгүүлж байсан холбогдогч тус тус эзэлж байгаа бол ШБ-аас ял шийтгүүлсэн хүний 33.7% нь согтуугаар, 16.4% нь урьд ял шийтгүүлсэн хүн байна.

ЦБ-ын мэдээллээр урьд ял шийтгүүлсэн холбогдогчийн тоо 59 буюу 64.1%-иар, согтуурсан үедээ гэмт хэрэг үйлдсэн холбогдогчийн тоо 48 буюу 15.5%-иар өссөн нь тус тус анхаарал татаж байна.

Гэмт хэргийн хохирогч, хохирол

ЦБ-ыг мэдээллээр Сонгинохайрхан дүүрэгт 3617 хүн, 6 хуулийн этгээд хохирсон байна. ГХ-ийн хохирогч, хохирлын талаарх хууль сахиулах болон шүүх эрх мэдлийн байгууллагын нэгдсэн статистикийг харуулбал:

Тооцох арга зүй: Судалгаанд хамрагдсан шийдвэр гаргалт нь хүртээмжтэй, хариуцлагатай гэдэгт итгэдэг хүн амын тоог судалгаанд хамрагдсан 18 түүнээс дээш насны хүн амын тоонд харьцуулж, хувиар илэрхийлнэ.

$$\frac{\text{Шийдвэр гаргалт нь хүртээмжтэй, хариуцлагатай гэдэгт итгэдэг хүн амын эзлэх хувь}}{\text{Судалгаанд хамрагдсан 18 түүнээс дээш насны нийт хүн амын тоо}} * 100 \%$$

Хүртвэр: Судалгаанд хамрагдсан шийдвэр гаргалт нь хүртээмжтэй, хариуцлагатай гэдэгт итгэдэг 18 түүнээс дээш насны хүн амын тоо

Хуваарь: Судалгаанд хамрагдсан 18 түүнээс дээш насны нийт хүн амын тоо

Түүврийн хүрээ: Мэдээллийг тухайн улсын өрхүүдэд оршин сууж буй хүн амын хэл соёл, харьяалал, хууль ёсны оршин суугаа байдлаас үл хамааран үндэсний хэмжээнд төлөөлөх магадлал бүхий түүвэр дээр үндэслэн цуглуулна. Бүх өрхийн 18 түүнээс дээш насны хүн ам асуулгад хариулж болно. Түүврийн хүрээ, түүвэр сонголтын аргууд нь зорилтот бүлэг дэх хүн ам, өрх бүрийг тэг биш байх магадлалтай сонголтын магадлалаар хангах ёстой.

Зорилтот бүлэг: 18, түүнээс дээш насны хүн ам

Үзүүлэлтийн задаргаа: Судалгааны үр дүнг энэ хоёр асуулгад үндэслэн хүйс, орлогын түвшин, боловсролын түвшин, оршин суугаа газар (засаг захиргааны бүс, муж, муж, дүүрэг; хот, хөдөө), хөгжлийн бэрхшээлийн байдал, үндэсний хэмжээнд хамааралтай хүн амын бүлэг, нас ангиллаар гаргах

Зөвлөмж: Уг үзүүлэлтийг ҮСХ-ны ӨНЭЗС-ны модуль судалгаа Ардчилсан засаглал судалгааны үр дүнгээс гарган авах боломжтой.

Зорилт. 16.10 Үндэсний хууль тогтоомж болон олон улсын гэрээ хэлэлцээрт нийцүүлэн олон нийтийг мэдээлэл олж авах боломжоор хангах, үндсэн эрх чөлөөг хамгаалах

16.10.1. Сүүлийн 12 сарын хугацаанд сэтгүүлчид, хэвлэл мэдээллийн ажилтнууд, ҮЭ-ийн болон хүний эрхийг хамгаалах байгууллагын ажилтнуудыг амийг нь хөнөөсөн, хулгайлсан, хүчээр сураггүй болгосон, дур зоргоороо баривчлан эрүүдэн шүүсэн тохиолдлын тоо

Тодорхойлолт: Энэхүү үзүүлэлтийг сэтгүүлч, үйлдвэрчний эвлэл болон хүний эрхийг хамгаалах байгууллагын ажилтнуудын эсрэг үйлдсэн аллага, хүчээр сураггүй алга болгосон, эрүүдэн шүүсэн, дур мэдэн хорьсон, хулгайлсан болон бусад хор хөнөөлтэй үйлдлүүдийн тоогоор тодорхойлно.

Тооцох арга зүй: Энэ үзүүлэлтийг өмнөх 12 сарын хугацаанд тохиолдсон мэдээлэгдсэн гэмт хэргийн нийт хохирогчийн тоогоор тодорхойлно.

Үзүүлэлтийн задаргаа: Хүйс, насны бүлгээр, зөрчлийн төрлөөр, гэмт хэрэгтний байдлаар, осол, зөрчил гарсан байршлаар

Зөвлөмж: Одоогоор эх үүсвэр тодорхойгүй. Цаашид ЦЕГ-ын бүртгэлийн маягтад нэмэлт тодруулга оруулснаар гарган авах боломжтой үзүүлэлт.

16.10.2. Олон нийтийн мэдээлэл авах эрхийг үндсэн хууль, хууль тогтоомж, дүрэм, журам, бодлогын түвшинд баталгаажуулж, хуульчилсан эсэх

Тодорхойлолт: Олон нийтийн мэдээлэл авах эрхийг хангах Үндсэн хууль, хууль тогтоомж, бодлогын түвшинд баталгаажуулж, хуульчилсан улс орны тоо

Тооцох арга зүй: ТХЗ-ын 16.10.2-ыг үнэлэхийн тулд доорх 3 шалгуур асуулгыг ашиглана.

1. Олон нийтийн мэдээлэл авах эрхийг хангах үндсэн хууль, хууль тогтоомж, бодлогын арга хэмжээ бий юу?
2. Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын гэрээ, конвенцыг үндсэн хууль, бусад хууль тогтоомж, бодлогын баримт бичигтээ тусгасан эсэх
3. Эдгээрийг хэрэгжүүлэхийн тулд ямар механизмыг хэрэгжүүлдэг вэ?

Үзүүлэлтийн задаргаа: Иргэдийн оршин суух байдал нь тэдний мэдээлэл олж авах чадварт хэрхэн нөлөөлж байгаагаас хамаарч үзүүлэлтийг задалж болно (жишээ нь: хөдөө, суурин, хөдөөгийн болон хотын оршин суугчид төрийн байгууллагуудын мэдээллийг хэрхэн олж авдаг вэ). Мэдээлэл олж авах чадварт хүйс хэрхэн нөлөөлж байгаа эсэх талаар нь бас ангилж болно. Цаашилбал, хөгжлийн бэрхшээл нь олон нийтийн мэдээллийн хүртээмжид хэрхэн нөлөөлж байгааг мөн үнэлэх боломжтой.

Зөвлөмж: Одоогоор мэдээллийн эх үүсвэр тодорхойгүй. Цаашид Хууль зүй, дотоод хэргийн яамнаас гаргах шаардлагатай үзүүлэлт.

Зорилт 16.а Хүчирхийллээс сэргийлэх, терроризм, гэмт хэрэгтэй тэмцэх зорилгоор бүх түвшинд ялангуяа хөгжиж буй орнуудын чадавхыг бэхжүүлэх үүднээс олон улсын хамтын ажиллагаагаар дамжуулан үндэсний холбогдох байгууллагуудын үйл ажиллагааг сайжруулах

16.а.1. Парисын зарчмыг мөрдлөг болгодог хүний эрхийн байгууллагатай эсэх

Тодорхойлолт: Үндэсний хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй хүний эрхийн байгууллагууд Парисын зарчмыг мөрдлөгө болгодог эсэхийг хэмжинэ.

Тооцох арга зүй: Үндэсний хүний эрхийн байгууллагын магадлан итгэмжлэлийн ангиллаар, тухайлбал А, В эсвэл С гэж тодорхойлно.

Үзүүлэлтийн задаргаа: Энэ үзүүлэлтийг задлан харуулах боломжгүй боловч хүний

эрхийн байгууллага, хүний эрхийн комисс, зөвлөх байгууллага, судалгааны институт

Зөвлөмж: Одоогоор мэдээллийн эх үүсвэр тодорхойгүй. Цаашид Хууль зүй, дотоод хэргийн яамнаас гаргах шаардлагатай үзүүлэлт.

Зорилт 16.в Тогтвортой хөгжлийн үл ялгаварласан хууль, бодлогыг хөхүүлэн дэмжиж, мөрдүүлэх

16.в.1. Олон улсын хүний эрхийн хуулиар хориглосон ялгаварлан гадуурхах явдлын аль нэг тохиолдолд сүүлийн 12 сарын дотор гадуурхагдан, доромжлуулснаа хувьдаа мэдэрсэн гэж мэдүүлсэн хүн амын эзлэх хувь

Тодорхойлолт: Энэхүү үзүүлэлтийг олон улсын хүний эрхийн хууль тогтоомжоор хориглосон үндэслэл (баримт бичиг) дээр үндэслэн сүүлийн 12 сарын туршид ялгаварлан гадуурхалт, дарамт шахалт үзүүлсэн гэж өөрийгөө мэдээлдэг хүн амын (насанд хүрэгчдийн) эзлэх хувиар тодорхойлдог. Хүний эрхийн олон улсын хууль гэдэг нь хүний эрхийг сурталчлах, хамгаалахад чиглэсэн олон улсын эрх зүйн хэрэгслийг, түүний дотор Хүний эрхийн түгээмэл тунхаглал, НҮБ-аас баталсан хүний эрхийн олон улсын гэрээг хэлнэ.

Тооцох арга зүй: Сүүлийн 12 сарын туршид нэг буюу хэд хэдэн хориотой үндэслэлээр ялгаварлан гадуурхагдсан, дарамтлуулсан гэж үзсэн хүний тоог нийт судалгаанд оролцогчдын тоонд хувааж, хувиар илэрхийлнэ.

$$\frac{\text{Ялгаварлан гадуурхагдсан хүний эзлэх хувь}}{\text{сүүлийн 12 сард}} = \frac{\text{Ялгаварлан гадуурхагдсан 15 – 49 насны хүний тоо}}{\text{Судалгаанд хамрагдсан 15 – 49 насны хүн амын тоо}} * 100 \%$$

Хүртвэр: Олон улсын хүний эрхийн хууль, тогтоомжоор хориглосон үндэслэлээр ялгаварлан гадуурхагдсан 15-49 насны хүний тоо

Хуваарь: Судалгаанд хамрагдсан 15-49 насны хүн амын тоо

Хүснэгт 8. Сүүлийн 12 сард ялгаварлан гадуурхагдан, доромжлуулснаа мэдүүлсэн хүн амын эзлэх хувь

	Улсын дүн	Насны бүлгээр						
		15-19	20-24	25-29	30-34	35-39	40-44	45-49
Сүүлийн 12 сард ялгаварлан гадуурхалт мэдэрсэн эмэгтэйчүүдийн хувь	16.3	17.3	16.2	18.1	16.1	16.0	17.3	12.6
Яс үндэс	1.9	2.3	1.7	2.6	2.0	1.4	2.0	1.1
Хүйс	1.8	2.9	1.2	2.7	1.5	2.2	1.1	0.9
Бэлгийн чиг хандлагаар	0.8	0.6	1.6	0.5	0.8	0.6	1.2	0.6
Насны бүлгээр	3.5	3.6	3.2	2.6	2.9	4.5	4.6	3.5
Шашин шүтлэгээр	1.5	3.2	1.4	1.5	1.5	1.5	1.1	0.8
Хөгжлийн бэрхшээлээр	1.5	1.1	1.4	1.6	1.1	1.3	1.4	0.8
Нутаг усаар	2.4	1.3	2.0	3.6	2.7	2.7	2.7	1.4
Хот, хөдөөгөөр	2.8	3.2	2.9	2.9	3.4	2.8	2.9	1.1
Амьжиргааны түвшин (баян, ядуу)	4.8	3.2	4.5	4.9	4.7	5.8	5.3	4.7
Амьдарч байгаа газар (орон сууц, гэр хороолол)	3.4	2.6	3.6	4.4	3.4	3.2	2.7	3.3
Боловсролын түвшнээр	3.9	2.7	2.2	4.0	4.8	4.8	4.5	2.9
Бусад шалтгаанаар	3.2	4.2	2.5	3.4	3.9	3.5	3.1	1.8
Сүүлийн 12 сард ялгаварлан гадуурхалт мэдэрсэн эрэгтэйчүүдийн хувь	14.6	15.3	20.5	16.4	10.4	14.6	13.8	13.1
Яс үндэс	2.4	2.8	3.1	4.5	2.0	2.1	2.0	0.3
Хүйс	0.8	0.6	0.9	0.7	0.8	1.3	1.1	-
Бэлгийн чиг хандлагаар	0.6	0.8	0.5	-	0.4	0.8	1.2	0.4

Насны бүлгээр	1.5	3.0	2.4	1.4	0.3	1.5	0.7	1.7	
Шашин шүтлэгээр	1.3	1.3	1.9	1.2	1.5	0.7	0.8	1.7	
Хөгжлийн бэрхшээлээр	1.0	1.2	1.3	0.7	0.9	1.5	1.2	0.3	
Нутаг усаар	2.5	2.0	1.4	3.7	1.5	2.6	4.2	1.8	
Хот, хөдөөгөөр	2.6	3.0	2.6	3.4	2.5	3.3	2.4	0.9	
Амьжиргааны түвшин (баян, ядуу)	4.4	2.7	4.9	4.6	5.1	5.9	3.9	3.4	
Амьдарч байгаа газар (орон сууц, гэр хороолол)	3.1	2.8	4.7	2.6	2.6	3.7	2.7	2.9	
Боловсролын түвшнээр	2.7	1.6	3.7	3.4	3.2	2.4	1.3	3.2	
Бусад шалтгаанаар	1.8	3.4	2.6	1.9	1.4	1.2	0.4	2.3	
Судалгаанд хамрагдсан	Эмэгтэй	10794	1206	1184	1762	1998	1644	1564	1436
	Эрэгтэй	4477	586	455	788	811	656	627	553

Эх үүсвэр: Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа, 2018 он

Үзүүлэлтийн задаргаа: хүйс, нас, орлого, хүйсээр, арьсны өнгөөр, үндэс угсаагаар, шилжин суурьшсан байдлаар, хөгжлийн бэрхшээлээр, газарзүйн байршил болон үндэсний нөхцөл байдалд хамаарах бусад шинж чанараар. Уг үзүүлэлтийн задаргааг SDG зорилтот 17.18 -ыг харгалзан тодорхойлно.

Зөвлөмж: Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгааны үр дүнгээс илүү дэлгэрэнгүй мэдээллийг авах боломжтой.

16.7. Бүх түвшинд хурдан шуурхай, бүх талын оролцоог хангасан, оролцооны аргад тулгуурласан, төлөөллийн шийдвэр гаргадаг болох

16.7.1. Төрийн албан хаагчид, төрийн албаны ангиллаар, хүйсээр, насны бүлгээр, хувиар

Тодорхойлолт: Төрийн улс төрийн алба, төрийн захиргааны алба, төрийн тусгай алба, төрийн үйлчилгээний албанд ажиллаж байгаа нийт төрийн албан хаагчийн тоог ойлгоно.

Тооцох арга зүй: Төрийн албан хаагчдын тоонд үндэслэн тооцно.


Үзүүлэлтийн задаргаа: Төрийн албан хаагчдын тоо, төрийн албаны ангиллаар, хүйсээр, насны бүлгээр, хувиар

Хүснэгт 9. Төрийн албан хаагчдын тоо, төрийн албаны ангиллаар

	Улсын дүн	Төрийн албан хаагчдын тоо, төрийн албаны ангиллаар			
		Улс төрийн алба	Захиргааны алба	Тусгай алба	Үйлчилгээний алба
2017	192 475	3 430	18 952	37 433	132 660
2018	193 557	3 403	19 034	38 083	133 037


Эх үүсвэр: Ажиллах хүчний судалгаа

Зураг 1. Төрийн албан хаагчдын тоо, насны ангиллаар, 2017 он



Эх үүсвэр: Ажиллах хүчний судалгаа

Зураг 2. Төрийн албан хаагчдын тоо, албан тушаалын ангилал, хүйсээр, 2017 он



Эх үүсвэр: Ажиллах хүчний судалгаа

Зөвлөмж: НҮБ-аас гаргасан зөвлөмжид шийдвэр гаргалт тухайлбал: Хөгжлийн бэрхшээлтэй хүн ам, хүн амын зорилтот бүлгүүд улсын хууль тогтоомжид байр сууриа тусгасан эсэх, үндэсний хууль тогтоох байгууллагад хүн амын төлөөлөл шийдвэр гаргах түвшинд эзэлж буй байр суурийг гаргах хувь, үндэсний хууль тогтоох байгууллагад хүн амын янз бүрийн төлөөллийн эзлэх хувь, цаашлаад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн болон хууль эрх зүйн хувьд хамааралтай хүн амын үндэсний хууль тогтоох байгууллагад төлөөллийг хангах үүднээс улс орнуудын баталсан сонгуулийн болон үндсэн хуулийн заалтыг авч үзэх шаардлагатай гэж зөвлөжээ. НҮБ-ын зөвлөмжтэй танилцахад 16.7-р зорилтын шаардлагыг бүрэн дүүрэн хангахгүй байна (16.7.1 Төрийн албан хаагчид, төрийн албаны ангиллаар,

хүйсээр, насны бүлгээр). НҮБ-ын зөвлөмж илүү шийдвэр гаргах түвшинд их хурлын дарга, гишүүдийн бүрэлдэхүүнд хүн амын бүлэг бүрийн төлөөллийн эзлэх хувь хэмжээ, үндэсний хууль тогтоомжид жирийн иргэдийн санал тусаж байгаа эсэх рүү анхаарахыг зөвлөжээ.

16.9. 2030 он гэхэд хүн бүрт албан ёсны үнэмлэх, түүний дотор төрсний гэрчилгээ олгох

16.9.1. Төрөлтийг нь иргэний бүртгэлийн байгууллага бүртгэсэн 5-аас доош насны хүүхдийн эзлэх хувь

Тодорхойлолт: Төрөлт нь иргэний эрх бүхий байгууллагад бүртгэгдсэн 5 хүртэлх насны хүүхдийн эзлэх хувийг ойлгоно.

Тооцох арга зүй: Төрөлт нь иргэний харьяалагдах улсын бүртгэлийн байгууллагад бүртгэгдсэн тав хүртэлх насны хүүхдийн тоог нийт хүн амын тав хүртэлх насны хүүхдийн тоонд харьцуулж, хувиар илэрхийлнэ.

$$\frac{\text{Төрөлт нь улсын бүртгэлд бүртгэгдсэн 5 хүртэлх насны хүүхдийн тоо}}{\text{Нийт хүн амын 5 хүртэлх насны хүүхдийн тоо}} * 100 \%$$

Хүртвэр: Төрөлт нь улсын бүртгэлд бүртгэгдсэн 5 хүртэлх насны хүүхдийн тоо

Хуваарь: Нийт хүн амын 5 хүртэлх насны хүүхдийн тоо

Үзүүлэлтийн задаргаа: Хүйс, нас, орлого, оршин суугаа газар, газарзүйн байршлаар

Зөвлөмж: Улсын бүртгэлийн ерөнхий газрын мэдээллээс гарах боломжтой.

Зорилт 11.7 2030 он гэхэд хүн бүрийг, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхдүүд, өндөр настнууд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг аюулгүй, бүх талын оролцоог хангасан, хүртээмжтэй, ногоон болон нийтийн эзэмшлийн талбайгаар хангах

11.7.2. Сүүлийн 12 сард бие махбодын хохирол амссан, бэлгийн дарамтад орсон хүн амын эзлэх хувь

Зөвлөмж: ТХЗ-ын бүс дундын ажлыг хэсгийн хуралдаанаар ТХЗ-ын 241 шалгуур үзүүлэлтийг дараах 3 түвшинд ангилсан. Энэ үзүүлэлт нь НҮБ-ын <https://unstats.un.org/sdgs/metadata/> сайтад одоогоор 3-р түвшний үзүүлэлтэд орсон учраас ашиглах арга зүй, үзүүлэлтийн задаргаа тодорхойгүй байна. Харин Монгол Улсын хувьд ЦЕГ-ын хохирогчийн захиргааны маягтад өөрчлөлт хийснээр мэдээллийн баазаас гаргах боломж бүрдэнэ.

Зорилт 10.7 Төлөвлөлт, зохицуулалт сайтай шилжилт хөдөлгөөний бодлого хэрэгжүүлэх замаар хүмүүсийн зохион байгуулалттай, аюулгүй, байнгын, хариуцлагатай шилжилт хөдөлгөөнийг дэмжих

10.7.2. Шилжин суурьших сайн бодлогыг хэрэгжүүлдэг эсэх

Тодорхойлолт: ТХЗ-ийн 10.7.2 үзүүлэлт нь шилжилт хөдөлгөөний үндэсний бодлогын төлөв байдал, цаг хугацааны явцад ийм бодлого хэрхэн өөрчлөгдөж байгааг тодорхойлох зорилготой.

Тооцох арга зүй: Энэ үзүүлэлтийг 6 чиглэлийн нийт 30 дэд асуулгаар гаргах болно.

1-р чиглэлээс бусад бүх дэд чиглэл нь "Тийм" эсвэл "Үгүй" гэсэн хариулттай.

"1" бол "Тийм", "0" бол "Үгүй" гэсэн кодтой. 1-р чиглэлийн дэд ангиллын хувьд гурван боломжит хариулт байна. Цагаачлалын статусаас үл хамааран "Тийм" бол "1" "Үгүй" бол "0" гэж кодолно. Зөвхөн хууль ёсны цагаачлалын статустай хүмүүст "0.5" гэж кодолно.

$$D_i = \frac{\sum_j^n s_{ji}}{n} * 100\%$$

D_i -чиглэл

$\sum_j^n s_{ji}$ - дэд категориуд

n- чиглэл бүрийн дэд категориудын нийт тоо

Хүртвэр: Шилжилт хөдөлгөөний талаарх дэд категори

Хуваарь: Чиглэл бүрийн дэд категориудын нийт тоо

Мэдээллийн задаргаа: Хүснэгт 10. Чиглэл ба дэд категори

Зөвлөмж: Энэ мэдээллийг НҮБ-аас улс орнуудын Засгийн газраас жил бүр цуглуулдаг бөгөөд Тогтвортой хөгжлийн зорилтын хүрээнд цаашид доорх шалгуур хүснэгтээр мэдээллийг цуглуулахаар НҮБ-аас зөвлөмждөө тусгасан байна.

Хүснэгт 10. ТХЗ-ын 10.7.2-ын Чиглэл ба дэд категори

Чиглэл	Дэд категори
1. Засгийн газар нь харьяалалгүй хүмүүст дараах үйлчилгээ, халамжийн тэтгэмж авах эрхийг тэгш хүртэх боломж олгодог уу?	а. Эрүүл мэндийн зайлшгүй тусламж болон бусад шаардлагатай тусламж
	б. Олон нийтийн боловсрол
	в. Ижил хөдөлмөрт ижил цалин олгох
	г. Нийгмийн хамгаалал
	д. Шударгаар хандах
2. Засгийн газар нь шилжилт хөдөлгөөн, цагаачлалыг зохицуулах бодлого, стратеги, институттай юу?	а. Үндэсний шилжилт хөдөлгөөний бодлогыг хэрэгжүүлэхэд зориулагдсан Засгийн газрын агентлаг
	б. Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөнтэй хамааралтай шилжилт хөдөлгөөний тогтвортой замыг буй болгох үндэсний бодлого
	с. Цагаачдыг оруулах эсвэл нэгтгэхийг дэмжих үндэсний бодлого, стратеги
	д. Шилжилт хөдөлгөөний бодлогод хүйсийг харгалзсан албан ёсны механизм
	е. Шилжилт хөдөлгөөний бодлогод нийцсэн албан ёсны мэдээллээр хангах
3. Засгийн газар шилжилт хөдөлгөөний бодлогод оролцог, оролцогч талуудын оролцоог дэмжих, улс орнуудын хамтын ажиллагааг хөгжүүлэх зорилгоор дараах арга хэмжээг авч байгаа эсэх	а. Яам хоорондын шилжилт хөдөлгөөний талаарх зохицуулалтын механизм
	б. Хөдөлмөрийн шилжилт хөдөлгөөнтэй холбоотой 2 талын харилцан тохиролцсон гэрээ
	в. Шилжилт хөдөлгөөнийг дэмжих бүс нутгийн хэлэлцээрүүд
	г. Бусад орон хамтран ажиллах гэрээ
	д. Шилжилт хөдөлгөөний бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэхэд иргэний нийгэм ба хувийн хэвшлийн оролцоулах албан ёсны механизм

<p>4. Шилжилт хөдөлгөөний хөгжлийн эерэг нөлөөллийг нэмэгдүүлэх, шилжин ирэгсдийн нийгэм, эдийн засгийн сайн сайхан байдлыг хангахын тулд Засгийн газар дараах арга хэмжээг авч байна уу?</p>	<p>а. Хөдөлмөрийн шилжилт хөдөлгөөний бодлогыг хөдөлмөрийн зах зээлийн бодит болон төлөвлөсөн хэрэгцээтэй уялдуулах, тогтмол үнэлэх</p> <p>б. Нийгмийн хамгааллын тэтгэмжийн дэмжлэг үзүүлэх</p> <p>в. Гадаадад олж авсан ур чадвар, ур чадварыг хүлээн зөвшөөрөхөд туслах</p> <p>г. Мөнгөн гуйвуулгын урсгалыг дэмжих, сурталчлах</p> <p>д. Гадаад ажилчдыг сонгоход шударга, ёс зүйтэй сонгон шалгаруулалтыг дэмжих</p>
<p>5. Засгийн газар олон улсын хилээр хүчээр нүүлгэн шилжүүлсэн дүрвэгсэд болон бусад хүмүүст хариу арга хэмжээ авахын тулд дараах арга хэмжээг авч байгаа юу?</p>	<p>а. Олон улсын хилээр зугтсан хүмүүсийг хүлээн авах, боловсруулах, таних систем</p> <p>б. Хүнс, ариун цэврийн байгууламж, боловсрол, эмнэлгийн тусламж гэх мэт үндсэн хэрэгцээг харгалзан нүүлгэн шилжүүлсэн хүн амын урьдчилан сэргийлэх төлөвлөгөө</p> <p>г. Хямралын эсвэл хямралын дараах нөхцөлд гадаадад амьдарч буй иргэдэд тусламж үзүүлэх тодорхой арга хэмжээ</p> <p>д. Гамшгийн үеийн нүүлгэн шилжүүлэлтийн нөлөөллийг шийдвэрлэх тодорхой заалт бүхий гамшгийн эрсдлийг бууруулах үндэсний стратеги</p> <p>е. Олон улсын хилээр хүчээр нүүлгэн шилжүүлсэн, буцах боломжгүй хүмүүст түр хугацаагаар оршин суух, түр зуурын хамгаалалт олгох</p>
<p>6. Засгийн газар дараах арга хэмжээнүүдийн дагуу тогтмол эсвэл тогтмол бус гадаад улс руу шилжих хөдөлгөөний асуудлыг шийддэг үү?</p>	<p>а. Визийн зөрчлийг хянах систем</p> <p>б. Ирэх зөвшөөрлийн урьдчилсан хяналт</p> <p>в. Насанд хүрээгүй болон ганцаараа яваа хүүхдэд зориулсан хангамж</p> <p>г. Шилжүүлгийн мэдээлэл, сурталчилгааны олон нийтийг хамарсан ажил</p> <p>д. Хүн худалдаалах, хууль бусаар хил нэвтрэх албан ёсны стратегит анхаарлаа хандуулах</p>

Эх үүсвэр: <https://unstats.un.org/sdgs/metadata>

Зорилго 5. Жендэрийн тэгш байдлыг хангаж, бүх эмэгтэйчүүд, охидыг чадавхжуулах

Зорилт 5.2.1. Сүүлийн 12 сард одоогийн болон өмнөх дотны хамтрагчийн зүгээс хүчирхийлэлд өртөж байсан 15, түүнээс дээш насны охид, эмэгтэйчүүдийн эзлэх хувь, хүчирхийллийн хэлбэрээр

Тодорхойлолт: Энэ үзүүлэлт нь өмнөх 12 сард одоогийн болон хуучин дотны хамтрагчийн зүгээс бие махбодын, бэлгийн болон сэтгэлзүйн хүчирхийлэлд өртсөн 15, түүнээс дээш насны охид, эмэгтэйчүүдийн эзлэх хувиар тодорхойлогдоно.

Тооцох арга зүй: Хамтрагчийн хүчирхийлэлд өртсөн 15-49, 15-64 насны охид, эмэгтэйчүүдийн тоог тухайн цаг жилийн нийт хүн амын 15-49, 5-64 насны охид, эмэгтэйчүүдийн тоонд харьцуулж, хувиар илэрхийлнэ.


$$\text{Дотно хамтрагчийн зүгээс хүчирхийлэлд өртсөн охид, эмэгтэйчүүдийн эзлэх хувь} = \frac{\text{Хамтрагчийн хүчирхийлэлд өртсөн 15 – 49, 15 – 64 насны эмэгтэйчүүдийн тоо}}{\text{Нийт хүн амын 15 – 49, 15 – 64 насны эмэгтэйчүүдийн тоо}} * 100 \%$$

Хүртвэр: Хамтрагчийн зүгээс хүчирхийлэлд өртсөн 15-49, 15-64 насны охид, эмэгтэйчүүдийн тоо

Хуваарь: Нийт хүн амын 15-49, 15-64 насны охид, эмэгтэйчүүдийн тоо

Үзүүлэлтийн задаргаа: Хүчирхийллийн хэлбэр, нас, орлогын түвшин/хөрөнгө, боловсрол, үндэс угсаа, хөгжлийн бэрхшээл, газарзүйн байршил, хүчирхийллийн давтамж зэргээр гаргана.


Зураг 3. Сүүлийн 12 сард одоогийн болон өмнөх дотно хамтрагчийн зүгээс хүчирхийлэлд өртсөн 15-64 насны охид, эмэгтэйчүүдийн эзлэх хувь, хүчирхийллийн хэлбэрээр



Эх үүсвэр: Жендэрт суурилсан хүчирхийллийн судалгаа

Судалгааны түүврийн хэмжээ: Судалгаанд 21 аймаг, 9 дүүргийн 7860 өрхийн 15-64 насны 6319 эмэгтэйчүүдийг хамруулсан болно.

Зураг 4. Сүүлийн 12 сард одоогийн болон өмнөх дотно хамтрагчийн зүгээс хүчирхийлэлд өртөж байсан 15, түүнээс дээш насны охид, эмэгтэйчүүдийн эзлэх хувь, насны ангилал, хүчирхийллийн хэлбэрээр



Эх үүсвэр: Жендэрт суурилсан хүчирхийллийн судалгаа.

Зөвлөмж: Үзүүлэлтийн задаргааг Жендэрт суурилсан хүчирхийллийн судалгааны тайлангийн хавсралт хэсгээс авах боломжтой.

Зорилт 5.2.2 Дотны хамтрагчаас бусад этгээдийн зүгээс бэлгийн хүчирхийлэлд өртсөн 15-49, 15-64 насны охид, эмэгтэйчүүдийн тухайн насны хүн амд эзлэх хувь, үйлдэгдсэн газраар

Тодорхойлолт: Энэ үзүүлэлт нь өмнөх 12 сард дотно хамтрагчаас бусад хүмүүсийн бэлгийн хүчирхийлэлд өртсөн 15, түүнээс дээш насны охид, эмэгтэйчүүдийн эзлэх хувиар тодорхойлогдоно.

Тооцох арга зүй: Өмнөх 12 сарын хугацаанд дотно хамтрагчаас бусад хүмүүсийн бэлгийн хүчирхийлэлд өртсөн 15, түүнээс дээш насны охид, эмэгтэйчүүдийн тоог нийт хүн амын 15, түүнээс дээш насны эмэгтэйчүүд, охидын тоонд харьцуулж, хувиар илэрхийлнэ.


$$\text{Бусдын зүгээс хүчирхийлэлд өртсөн охид, эмэгтэйчүүдийн эзлэх хувь} = \frac{\text{Бусдын зүгээс хүчирхийлэлд өртсөн 15 – 49, 15 – 64 насны эмэгтэйчүүдийн тоо}}{\text{Нийт хүн амын 15 – 49, 15 – 64 насны эмэгтэйчүүдийн тоо}} * 100 \%$$

Хүртвэр: Бусдын зүгээс хүчирхийлэлд өртсөн 15-49, 15-64 насны охид, эмэгтэйчүүдийн тоо
Хуваарь: Нийт хүн амын 15-49, 15-64 насны охид, эмэгтэйчүүдийн тоо

Үзүүлэлтийн задаргаа: Нас, үйлдэгдсэн газар, орлого/хөрөнгө, боловсрол, үндэс угсаа хөгжлийн бэрхшээлийн байдал, газарзүйн байршил, хүчирхийлэл үйлдэгчтэй харьцах харьцаа (хүчирхийлэгчийн хүйс орно), бэлгийн хүчирхийллийн давтамж, төрлөөр гаргана.

Зөвлөмж: Уг үзүүлэлтийг задаргаагаар “Жендэрт суурилсан хүчирхийллийн судалгаа”-ны мэдээллээс гарган авах боломжтой. (Судалгааны тайлангийн хавсралт хэсгээс үзүүлэлтийг задаргаагаар авч болно.)

Зураг 5. Дотны хамтрагчаас бусад этгээдийн бэлгийн хүчирхийлэлд өртсөн 15-49, 15-64 насны охид, эмэгтэйчүүдийн тухайн насны хүн амын тоонд эзлэх хувь



3. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

- **Дүгнэлт.** Хууль зүй дотоод хэргийн яам нь Тогтвортой хөгжил-2030-ын хүрээнд хууль зүйн салбарын үйл ажиллагааг үнэлэх 7 зорилтын хүрээнд 26 үзүүлэлтийг гаргах үүрэг хүлээж байна. Одоогоор зарим үзүүлэлтүүд хууль зүйн салбарын захиргааны болон албан ёсны мэдээллээс, зарим үзүүлэлтүүд ҮСХ-ны судалгаануудаас гарах боломжтой байгаа боловч ихэнх үзүүлэлтүүд задаргаагаар гарах боломжгүй байгаад анхаарлаа хандуулах хэрэгтэй байна. Тогтвортой хөгжлийг үнэлэхэд гэмт хэрэг, хүчирхийллийн статистикт хамаарах 17 үзүүлэлт байна. Цаашид гарахгүй байгаа үзүүлэлтүүдийг Монгол Улс гаргадаг болох хэрэгцээ байна гэж дүгнэж байна.

Зөвлөмж 1. Тогтвортой хөгжлийн зорилтыг үнэлэх гарахгүй үзүүлэлтүүдийг гаргадаг болох, гарч буй ерөнхий үзүүлэлтүүдийг задаргаагаар гаргадаг болох;

Зөвлөмж 2. Тогтвортой хөгжлийн үзүүлэлт тооцох арга зүйг буй болгох;

Зөвлөмж 3. Тогтвортой хөгжлийн зорилтыг үнэлэх гарахгүй байгаа үзүүлэлтүүдийг гарган авахын тулд өрхөд суурилсан хохирогчийн судалгааг зохион байгуулж явуулах.

ДОЛООДУГААР
БҮЛЭГ

ГЭМТ ХЭРГИЙН
ХОХИРЛЫН
СТАТИСТИКТ ХИЙСЭН
ДҮН ШИНЖИЛГЭЭ



1. ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОХ ЯВДЛЫН (VICTIMIZATION) ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ГЭМТ ХЭРЭГ ХОХИРОХ ШАЛТГААН НӨХЦӨЛ, НӨЛӨӨЛӨХ ХҮЧИН ЗҮЙЛ

Виктимизаци (victimization) буюу хохирох явдал нь шинэ тутам хөгжиж байгаа виктимологийн үндсэн ойлголт бөгөөд хувь хүн, байгууллага (хуулийн этгээд) тодорхой орон зай, цаг хугацаанд объектив болон субъектив хүчин зүйл, тохироо, хохирогчийн гэмт хэрэгт хохирох эрсдлээс хамаарч гэмт хэргийн золиос болох үйл явц, түүний үр дагавар хор уршгийг хэлнэ.

2004 онд НҮБ-ын Нийгэм эдийн засгийн хорооны Статистикийн албанаас “Эрүүгийн шүүн таслах ажиллагааны салбарын статистик мэдээллийн тогтолцоог боловсруулах удирдамж”¹-ийг батлан гаргасан нь дэлхийн улс орнуудын эрүүгийн болон гэмт явдлын тоо бүртгэлийг ижилтгэх чухал нөхцөл болсон.

Монгол Улсын гэмт хэргийн албан ёсны статистикт хохирох явдлыг зөвхөн хүн ам зүй, эрүүгийн эрх зүйн шинжээр нь ерөнхий хэдхэн үзүүлэлтээр ойлгож, дүгнэж ирсэн нь гэмт хэрэгт хохирох явдлын судалгааг үнэн зөв гаргах, улмаар гэмт хэрэгт хохирох эрсдэл, хохирох явдлын шалтгаан нөхцөл, хохирох явдалд нөлөөлж буй объектив, субъектив хүчин зүйл, хохирогч-хувь хүн, хуулийн этгээдийн дүр төрх, гэмт хэрэгт хохирох эрсдлийг тооцох шалгуур үзүүлэлт үнэлгээ байхгүйгээс гэмт хэрэгт хохирохоос урьдчилан сэргийлэх ажил, арга хэмжээг шинжлэх ухааны үндэстэйгээр боловсруулах боломжгүй байна.

Монгол Улсын гэмт хэргийн албан ёсны (шүүх, прокурор, цагдаагийн болон бусад) статистикийн цөөн хэдэн үзүүлэлт нь гэмт хэрэгт хохирох явдлын үнэн бодит байдлыг тогтоох эрдэм шинжилгээ судалгааны болон хэрэглээний шаардлага хангахгүй, зөвхөн танин мэдэхүйн шинжтэй хэдхэн ерөнхий үзүүлэлт тоо гарч байгаа нь туйлын харамсалтай.

Ийм ч учраас дэлхийн ихэнх хөгжиж буй болон хөгжингүй улс оронд гэмт хэргийн статистик, түүний дотор гэмт хэрэгт хохирох явдлын статистикийн мэдээллийг “Гэмт хэрэгт хохирох явдлын судалгаа” хийж баталгаажуулдаг.

Гэмт явдал, хар тамхитай тэмцэх талаарх НҮБ-ын хорооноос 2010 онд Хохирох явдлын тандалт судалгаа нь гэмт хэргийн болон виктимологийн албан ёсны статистикийн цоорхойг нөхөх чухал ач холбогдолтой гэж үзэж, “Гэмт хэрэгт хохирох явдлын судалгаа хийх талаарх Удирдамж”-ийг батлан гаргасан².

Энэхүү Удирдамж нь:

1) Виктимизацийн судалгааны ерөнхий мэдээлэл (зорилго, хохирогчийн судалгааны түүхэн хөгжил: хувьсал, өнөөгийн байдал, Гэмт хэргийн улмаас хохирох явдлын судалгааны хязгаарлалт гэх зэрэг);

2) Гэмт хэрэгт хохирох явдлын төлөвлөлт (хохирох явдлын судалгаа болон гэмт явдлын албан ёсны статистикийн бусад төрөл, цагдаагийн албанд бүртгэсэн гэмт хэрэг болон хохирох явдлын судалгааны онцлог, ялгаа);

¹ Департамент по экономическим и социальным вопросам Статистический отдел (Методологические исследования Серия F No 89)., Руководство по разработке системы статистических данных в области уголовного правосудия. Организация Объединенных Наций Нью-Йорк., 2004.

² Управление организации объединенных наций по наркотикам и преступности., Европейская экономическая комиссия организации объединенных наций. Руководство по обследованиям виктимизации. Организация объединенных наций. Женева., 2010.

3) Арга зүйн асуудлууд (судалгааны зорилго, зорилт, судалгааны ажлын хэсэг, төсөв, хугацаа, бусад хязгаарлалт, судалгааны түүвэр сонголт, мэдээлэл цуглуулах үе шат, хохирох явдлын судалгааны процесс гэх зэрэг);

4) Хохирох явдал гэмт явдлыг судлах аргачлал, судалгааны бүтэц, элемент гэх зэрэг);

5) Асуулгын дизайн, ярилцлага, мэдээллийг боловсруулах, үнэлэх, шинжлэх, судалгааны ёс зүйн баримжаа, мэдээллийг албан ёсны болгох түгээх зэргийг тодорхой зааж өгчээ.

Эрдэмтэд гэмт хэрэгт хохироход хүргэж байгаа үндсэн шалтгаан, хүчин зүйлүүдийг илрүүлэх, нийгмийн янз бүрийн давхарга, иргэдэд аюулгүйн зан үйлийн талаар практикийн зөвлөмж боловсруулах явцдаа адил төрлийн гэмт халдлагын үед зарим этгээд хохирохоос зайлсхийж чадаж байхад, нөгөө хэсэг нь яагаад хохироод байна гэсэн асуудалтай байнга тулгардаг байна. Энэ асуудлыг шийдвэрлэхийн тулд хохирох явдал, түүний бүрдэл хэсгүүд болох хохирох үйл явц, түүний үр дагавар болох хохирлыг судлах зайлшгүй шаардлагатай.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 22 дугаар зүйлд: “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг хэрэгжүүлэгч улсын хэмжээнд, тодорхой нутаг дэвсгэрийн хэмжээнд, эсхүл тодорхой төрлийн гэмт хэрэг, зөрчлийн гаралтын түвшний талаар олон нийтийн санал асуулгыг 2 жил тутам, гэмт хэрэгт хохирох эрсдэлийн судалгааг 3 жил тутам зохион байгуулна” гэжээ. Хохирох явдал, хохирох эрсдэлийн судалгааг ийнхүү 3 жил тутам явуулахаар төсөөлсөн нь гэмт хэргийн улмаас хохирох явдлын судалгааг гадаадын улс орнуудын энэ төрлийн судалгааны жишигт дөхөж очсон чухал алхам болно.

Гэмт хэрэгт хохирох явдлын өнөөгийн байдал, гэмт хэрэгт нөлөөлөх шалтгаан нөхцлийг статистикийн болон хохирох явдлын тандалт судалгааны үр дүнгээр үнэн зөв илэрхийлэх учраас эхлээд онол, арга зүйн үндсийг тодорхойлж, судалгааны нарийвчилсан арга аргачлалыг боловсруулахыг өнөөгийн нөхцөл шаардаж байна.

Хойшид энэ ажлыг гэмт явдалтай тэмцэх чиг үүрэгтэй төрийн ба төрийн бус байгууллагууд энэ салбарын эрдэмтэн, судлаачдын оролцоотойгоор тодорхой цаг хугацаа, хүч хөрөнгө гаргаж төслийн хэмжээнд боловсруулах нь нэн шаардлагатай байна.

Цагаан ном зохиогчдын захиалгын дагуу энэ асуудлыг онолын түвшинд бичсэн боловч, зарим нэгэн байгууллагын, тухайлбал ННФ-ын саналаар зөвхөн тоон үзүүлэлтийн уншилт шаардсаны дагуу онол, танин мэдэхүйн ихэнх хэсгийг хасав.

Виктимологийн талаар ямар нэгэн ойлголтгүй шийдвэр гаргах эрх бүхий этгээд, гадаад дотоодын төсөл хэрэгжүүлж байгаа этгээдүүдэд “Цагаан ном”-оор дамжуулан онол, танин мэдэхүйн зарим ойлголт өгөх, тулгамдаж буй асуудалд анхаарал хандуулахын тулд цөөн хэдэн зурвас үлдээв.

1.1. Гэмт хэрэгт хохирох явдлын тоон үзүүлэлт: бүтэц, хөдөлгөөн

Виктимологийн статистикийг мэдээллийн эх сурвалжаар нь: виктимологийн албан ёсны статистик; хохирох явдлын (тандалт) судалгаа гэсэн хоёр үндсэн төрөлтэй.

Виктимологийн албан ёсны статистик нь шүүх, прокурор, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх болон хуулийн бусад байгууллагаас албан ёсоор бүртгэгдсэн болон шүүн тасалсан гэмт хэргийн статистикийн хүрээнд хөтлөгдөж байгаа дэд статистикийг хэлнэ.

Хүснэгт 1. 2017-2018 онд гэмт хэргийн улмаас хохирол учирсан байдал

д/д	Он	Нийт хохирогч иргэн	Эмэгтэй	Нас			
				18 хүртэлх	18-30 нас	31-35 нас	36-аас дээш
1	2017	37173	18148	1758	10332	6153	18930
2	2018	33566	14673	1689	9649	5650	16578
	Дүн	70739	32821	3447	19981	11803	35508

2017 онд нийт 32259 гэмт хэрэгт 37173 хүн хохирсон бол 2018 онд 36220 гэмт хэрэгт 33566 хүн хохирчээ. Үүнээс үзэхэд 2018 онд гэмт хэрэг туйлын үзүүлэлтээр 12.2% нэмэгдсэн боловч, хохирсон хүн 8.7%-иар буурсан үзүүлэлттэй байна. Хэдийгээр хохирсон этгээдийн тоо буурсан мэт харагдаж байгаа боловч, “хохилогчгүй” гэгдэх байгаль орчныг хамгаалах журмын эсрэг, мансуурах, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлттэй холбоотой гэмт хэрэг нөлөөлж байгааг дурдах нь зүйтэй.

1.2. Гэмт хэргийн хохирогч: гэмт хэрэгт өртөмтгий эмзэг хохирогчийн онцлог

НҮБ-ын 1985 оны “Гэмт хэрэг болон албан тушаалын байдлаа урвуулан ашигласны улмаас хохирогчдын талаарх хууль цаазын үндсэн зарчмын тухай тунхаглал”-д зааснаар, хохирогч гэсэн ойлголтод: “...гишүүн улсуудын дагаж мөрдөж байгаа албан тушаалын байдлаа урвуулан ашиглахыг хориглосон хуулиудыг оролцуулаад, эрүүгийн хуулийг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйн улмаас бие мах бодийн болон оюун санааны хохирол учирсан, сэтгэл санааны дарамтад орсон, эд хөрөнгийн хохирол учирсан, эсхүл үндсэн эрх нь ноцтойгоор зөрчигдсэн бие хүн болон хамт олныг ойлгоно”³ гэж заажээ.

Эрүүгийн байцаан шийтгэх хууль тогтоомжид зааснаар эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны хохирогч гэдэг нь гэмт хэргийн улмаас түүнд нэр төр, алдар хүнд, санаа сэтгэл, бие эрхтэн, эд хөрөнгийн хохирол учирсантай (объектив шалгуур) холбоотойгоор хуулиар тогтоосон журмын дагуу хохирогч гэж хүлээн зөвшөөрсөн (субъектив шалгуур) этгээд мөн. Иймд Эрүүгийн процессын оролцогч хохирогчийн тухай ойлголт нь объектив /агуулга/ ба субъектив /хэлбэр/ шалгууруудын албан ёсны нэгдэл юм.

Виктимолгийн шинжлэх ухаанд хохирогч бие хүнийг судлах, төрөлжүүлэх, ангилах олон шалгуур үзүүлэлтийг боловсруулсан.

Гэмт хэрэгт өртөгдөж болзошгүй, далд буюу потенциал⁴ хохирогч (potential victims) /түүний хувьд бодит хор уршиг хараахан бий болоогүй/; бодит хохирогч /хохирол нэгэнт учирсан/, мөн бодит хохирогчийн нэг өвөрмөц төрөл болох нуугдмал буюу латент⁵ (latent victims) /бодитойгоор хохирсон боловч ямар нэгэн шалтгаанаар албан ёсны бүртгэлээс гадна үлдсэн/ хохирогчийг⁶ ялган авч үзэх жишээтэй.


³ Хүний эрх. Шүүх эрх мэдлийн салбар дахь хүний эрх. НҮБ. УБ., 1996. 174 тал.

⁴ potentia-хүч чадал гэсэн латин гаралтай үг

⁵ latent-нуугдмал, үл үзэгдэх гэсэн утгатай латин гаралтай үг

⁶ Д.В.Ривман. Криминальная виктимология. СПб., 2002. С 36.


График 1.



Хүний хувийн тодорхой шинж чанар, зан үйл, хүмүүсийн хамтлаг, нийтлэгийн онцлог, мөн албаны болон ажил төрлийн байдал нь тухайн этгээдэд бие махбод, оюун санааны болон эд хөрөнгийн хохирол учрах илүү боломж, эрсдэл, гэмт хэрэгт илүү өртөмтгий байдлыг бий болгоно.

Эмэгтэйчүүд, хүүхэд, өндөр настнууд нь гэмт хэрэгтнээс бие бялдрын хувьд сул дорой байдаг учраас хүч хэрэглэсэн гэмт хэрэгт залуу эрчүүдээс илүү өртөх жишээтэй. Зарим тодорхой тохиолдолд гэмт хэргийн хохирогч нь зөвхөн эмэгтэйчүүд, эсхүл насанд хүрээгүй хүүхэд байж болно. Гэмт хэрэгт илүү өртөгдөх боломж нь мэргэжил, олон нийтийн өмнө хүлээсэн үүрэг зэрэг нийгмийн тодорхой ажил үүргийг тухайн этгээд гүйцэтгэхтэй мөн холбоотой. Тухайлбал, ченжүүд, мөнгө хураагч, таксины жолооч нар бэлэн мөнгө авч явдаг учраас дээрмийн хэрэгт илүү өртөмтгий байх эрсдэлтэй. Хувь хүний төрөлхийн болон олдмол энэ эмзэг, өртөмтгий байдлууд нь тодорхой тохироо бүрдэх үед, хор уршиг учрах урьдчилсан нөхцөл болон хувирдаг. Гэвч өртөмтгий байдал нь хохирогч болох эрсдэлийн боломжийг дангаараа бүрдүүлэхгүй. Үүнд гэмт хэргийн тохироо олон зүйлийг шийдвэрлэнэ. Өртөмтгий байдал нь тодорхой тохирооны бүрдэл хэсгийн хувьд зөвхөн түүний урьдчилсан нөхцөл болно.


График 2.



Түүнчлэн виктимологийн шинжлэх ухаанд гэмт хэргийн улмаас өөрт нь хохирол учирсан тухай фактаа ямар нэгэн шалтгаанаар нууж, ил болохоос зайлсхийх санаа зорилготой, эсхүл гэмт хэрэгт хохирсон талаар огт мэдээгүй явж байгаа нуугдмал /латент/ хохирогч ихээхэн сонирхол татна. Судалгаанаас үзэхэд гэмт хэрэгт хохирсон хүмүүсийн 73.2% нь ямар нэгэн объектив, субъектив шалтгаанаас болж хуулийн байгууллагад хандаагүй байна. Эдгээр хүмүүсийн 31% нь хэрэг сунжрахаас төвөгшөөсөн, 37.6% нь хуулийн байгууллагын хүнд суртлаас, 9.7% нь ичиж зовсон буюу нэр төрөө бодсон, 29.9% нь ямар нэгэн үр дүн гарахгүй, 14.6% нь гэмт хэрэгтний өшөө хонзон, дарамтаас айсан гэсэн дүн гарсан байна.

Хохирогч нь гэмт хэргийн улмаас эрх, эрх чөлөө хууль ёсны ашиг сонирхолд нь бие махбод, эд хөрөнгө, ёс суртахууны хохирол учирсан бие хүн, хуулийн этгээд мөн.

График 3.



Гэмт хэрэгт хохирсон нийт хүний 36 наснаас дээш хүмүүс гэмт хэргийн золиос болох хамгийн эрсдэлтэйг харуулж байна.

Гэмт хэрэгт хохирох нөхцөл, байдалд хүргэж болох хувийн бодит сөрөг зан чанарууд нь тодорхой тохироонд хувь хүний дотоод ертөнцөөр дамжин илэрнэ. Практикт бие хүний нэг чанар хэзээ ч ганцаар биш, харин ямар нэгэн хэмжээгээр нэгдэн нийлэх, цогцлогдож байж тодорхой үр дагаварт хүргэнэ. Иймд хувийн шинж чанаруудын хэв шинжийн янз бүрийн зохицол, виктим ач холбогдол нь туйлын биш, харин янз бүрийн гэмт хэргийн тохирооны онцлогт харьцангуй байдаг.

Иймд гэмт хэргийн хохирогчийн нийгэм-сэтгэл зүйн хэв маягийн ангилалтыг боловсруулах явцад, “гэмт хэрэгтэн-бие хүн” гэсэн загварчлалаар “хохирогч-бие хүн” гэсэн ойлголтыг авч хэрэглэх нь шинжилгээ, судалгааны болон практикийн зорилгод ихээхэн хэрэгтэй байна.

Иймд хохирогчийг дараах шалгуураар ангилж болно. Үүнд:

1. Хохирогчийн нийгэм-хүн ам зүйн онцлог шинж (нас, хүйс, нийгэмд гүйцэтгэх үүрэг, гэмт хэрэгтэнтэй харилцан хамаарал);
2. Хохирогчийн зан суртахуун-сэтгэцийн шинжээр нь (бэлгийн замбараагүй байдал, мансууруулах бодис ба согтууруулах ундаанд дурлах, сувдаг шунахай, харгис, түрэмгий, бүдүүлэг, хэрцгий, аймхай хулчгар, идэвхгүй, хардамтгай, итгэмтгий, гэнэн хөнгөмсөг, сайхан сэтгэл, шүүмжлэлгүй, хашир, болгоомжгүй, ёс суртахууны тогтвортой, хэрсүү, эелдэг ая зан, зоримог, эрэлхэг, биеийн бэлтгэл сайн, эсхүл сул дорой зэргээр илэрч харагдана. Эдгээр бүх шинж чанар

нь тодорхой нөхцөл тохироо, зан үйлд илэрч, гэмт хэрэг үйлдэгдэхэд саад болох буюу түүнийг өдөөж, хөгжөөж болно.

3. Зан үйлийн хэв маяг (идэвхтэй, идэвхгүй, өдөөгч, гэнэн гэх зэрэг);
4. Эрүүгийн ба эрүүгийн процессын эрх зүйн ангилалт (эрх зүйн болон нийгмийн байдал, хүн ам зүйн шинж, гүйцэтгэх үүрэг, учирсан хохирлын төрөл, давтамж, хүнд хөнгөн, хор уршиг, гэмт хэргийн төрлөөр).

Хүснэгт 2.

Д/д	Он	Нийт хохирогч иргэн	Нийгмийн байдал							
			ажилтан, хувиараа хөдөлмөр эрхлэгч, малчин	төрийн албан хаагч	оюутан	сурагч	сургууль завсардсан хүүхэд	тэнэмэл	хоригдол	ажилгүй
1	2017	37173	19824	2146	961	680	40	96	13	13413
2	2018	33566	21330	3247	860	701	54	38	16	7320
Нийт		70739	41154	5393	1821	1381	94	134	29	20733

Хувь хүний зан үйл дэх эрсдэлд нөлөөлөх субъектив хүчин зүйлүүдийг виктим эрсдэлийн үнэлэмж, гэм буруугийн асуудлуудтай холбоотойгоор: нийгмийн болон хувийн хүчин зүйл гэж ангилна. Мөрдөн байцаалтын практикаас харахад тодорхой “төрлийн” хүмүүс гэмт хэрэгт илүүтэй их өртөгдөх нь ажиглагддаг. Энэхүү “заяа төөрөг, хувь тавилан” гэмээр энэ байдалд:

- гэм буруутай ба гэм буруугүй зан үйл;
- хувийн, нийгмийн болон мэргэжлийн, эсхүл өөр бусад бүлгийн хамаарал зэрэг нөлөөлж болно.

Тийм ч учраас амь нас хохирох, гэмтэх, эсхүл дээрэмдэх халдлагын аюулд архичид, биеэ үнэлэгчид, эсхүл биеэ барих чадваргүй, бүдүүлэг хэрцгий хүмүүс илүү өртөмтгий байдаг онцлогтой.

Виктимологийн хамгийн гол хүчин зүйлийн нэг бол архидан согтууралт мөн. Хохирогчийн согтуурсан байдал нь өөрийн хяналт алдагдсан, хамгаалах боломж ихээхэн хэмжээгээр буурсан зэргээс болж олонх тохиолдолд гэмт сэдэлт үүсэх, хэрэгжих нөхцөлийг бүрдүүлнэ.

Гэмт хэрэгт хохирох явдалд ямар ч гэм буруугүйгээр өртөгдөх бүлэгт олон хүмүүс хамрах бөгөөд тэд өөрийн мэргэжлийн болон эд хөрөнгийн байдлаас болж аллага, дээрэм, тонуулын хохирогч болох нь элбэг байдаг. Жишээлбэл: таксины жолооч, мөнгө хураагч, цагдаагийн ажилтан, бизнес эрхлэгчид, ченжүүд; ганзагын наймаачид, жуулчид, гадаадын ажилчдыг дээрэмдэх, амь насыг нь бүрэлгэх зэрэг байж болно.


Виктимологийн механизм, тохироонд хийсэн судалгаа шинжилгээнээс үзэхэд гэмт хэрэгт ганцаарчлан өртөгдөх тохиолдолд ихэвчлэн хохирогчийн “гэм буруутай” зан үйл ихээхэн үүрэг гүйцэтгэсэн байдаг. Энэ нь хүн амины болон дээрэмдэх гэмт хэрэгт илүү тод ажиглагдана.

Гэвч хохирогчийг сонгох сонголт нь ихэвчлэн түүний бодит зан үйлтэй холбоогүй нөхцөл байдал бас нөлөөлдөг бол аюул занал нь тодорхой этгээд болон тодорхой төрлийн этгээдээс /жишээлбэл, хүнийг алах гэмт хэрэг үйлдэх үед/ гэмт хэрэгтний хувьд төвөг удсан буюу тааламжгүй байдалд хүргэсэн, түүнчлэн хохирогчийн ажлын шинж чанар, эсхүл тохирооны онцлогоос /тохиолдлын тохироо/ хамаарсан зэргээс бий болдог онцлогтой. Эдгээр тохиолдолд гэмт үйлдлийн үр дагаварт хохирогчийн ямар нэгэн “гэм буруу”

харьцангуйгаар үгүйсгэгдэж байгаа юм.

Харин гэмт хэргийн хохирогчийн “гэм буруутай” зан үйлийн тохиолдлын дунд хамгийн ноцтой хэсгийг өдөөн хатгалт эзэлнэ. Жишээлбэл: Польшийн криминологич Брунон Холыстын явуулсан судалгаагаар хүнийг алах гэмт хэргийн 49%-д нь хохирогчийн өдөөн хатгасан зан үйл гол үүрэгтэй байсныг тогтоожээ. Бүлэглэн хүчиндсэн гэмт хэрэгт хохирогчийн өдөөн хатгасан /санаатай болон санаагүй/ зан үйл, эсхүл түүний хөнгөмсөг байдал зэрэг нь шүүгчийн субъектив төсөөлөлд нөлөөлөх тохиолдол ч байдаг.

График 4. Хохирогч гадаадын иргэн (2017-2018 он)



Хүүхдийн эрхийн конвенцод⁷ гэмт хэрэг болон эрх мэдлээ урвуулан ашигласны улмаас хохирсон хүүхэд болон насанд хүрээгүй этгээдийг шүүн таслах ажиллагааны талаар ерөнхий заалтууд орсон юм⁸.

Хүүхдийн эрхийн тухай Конвенцын 39 дүгээр зүйлд: “Оролцогч улсууд хүүхдийг үл хайхрах, мөлжих, зүй бусаар ашиглах, эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бус, нэр төрийг нь доромжилсон харьцаа, хандлага, зэвсэгт мөргөлдөөний хохирогч хүүхдийг бие бялдар, сэтгэл зүйн хувьд нөхөн сэргээх, нийгмийн амьдралд буцаан оруулахад тус дөхөм болох шаардлагатай бүх арга хэмжээг авна. Ийнхүү нөхөн сэргээх, нийгэмд нэгтгэх үйл явц нь хүүхдийн эрүүл мэнд, нэр төр, үе тэнгийнхний хүндэтгэл хангагдсан нөхцөлд хэрэгжих ёстой” гэжээ.

Гэмт хэргийн гэрч, хохирогч хүүхдийг хамгаалах тухай зохих үндэслэлүүд Олон улсын эрүүгийн шүүхийн тухай Ромын дүрэм⁹, Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенц, түүний протокол¹⁰, Авилгалын эсрэг НҮБ-ын конвенц¹¹ зэрэгт тусгалаа олжээ.

Гэрч, хохирогч хүүхдүүд нь маш эмзэг байдаг тул тэдний насны онцлог, төлөвшлийн түвшин, хувь хүний онцгой хэрэгцээ, гэмт хэргийн улмаас учирсан бие махбод, оюун санааны хохирол зэргийг харгалзан тэднийг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулахдаа нэмж таагүй байдал учруулахгүй, гэмтээхгүй байхад онцгой анхаарах шаардлагатай байдаг. Мөн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хохирогч хүүхдүүд нь гэмт хэргийн цорын ганц гэрч болох нь цөөнгүй байна.

⁷ United Nations, Treaty Series, vol. 1577, No. 27531.

⁸ Ibid., arts. 19, 39 и 40.

⁹ United Nations, Treaty Series, vol. 2187, No. 38544, arts. 68, 75 и 79.

¹⁰ United Nations, Treaty Series, vols. 2225, 2237, 2241 и 2326, No. 39574, arts. 6-8.

¹¹ United Nations, Treaty Series, vol. 2349, No. 42146, art. 32.

Ийм учраас эдгээр байдлыг хүлээн зөвшөөрч НҮБ-ын Эдийн засгийн болон Нийгмийн Зөвлөл 2005/20 тогтоолоор “Гэмт хэргийн гэрч буюу хохирогч хүүхдүүд¹² оролцохтой холбоотой асуудлаарх шүүн таслах ажиллагаанд хамаарах Удирдах зарчмууд” 2005 оны долдугаар сарын 22-ны өдөр баталсан юм. Олон улсын энэ баримт бичэгт тодорхойлсноор “Гэрч, хохирогч хүүхэд” гэдэг нь тодорхой гэмт хэрэг буюу эсхүл эрэн сурвалжлагдаж байгаа гэмт хэрэгтэн буюу гэмт хэргийн бүлэглэлийг эрэн сурвалжлах үйл явцад тэдний гүйцэтгэсэн үүргээс үл хамааран гэмт хэргийн гэрч буюу хохирогч болсон 18 нас хүрээгүй болон өсвөр насныхныг хэлнэ.

Харамсалтай нь манай орон энэ баримт бичигт нэгдэн ороогүй байна. Энэ баримт бичгээр гэрч, хохирогч хүүхдүүдтэй анхаарал халамжтай, хүндэтгэн харьцах эрх, ялгаварлан гадуурхахаас хамгаалуулах эрх, мэдэх эрх, сонирхох, өөрийн саналыг илэрхийлэх, болгоомжлох эрх, тусламж авах эрх, хувийн эрх, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үед хүнд тохиорооноос хамгаалуулах эрх, аюулгүй байх эрх, нөхөн төлбөр авах эрх зэрэг үндсэн эрхийг баталгаажуулсан.

Цаашид гэрч, хохирогч хүүхдийн эрх зүйн байдлыг дээрдүүлэх, олон улсын стандартад нийцүүлэх талаар тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэх энэ талаар тусгайлан судлах шаардлагатай.

Хохирогч этгээд, ялангуяа эмзэг хохирогчийг зөвхөн эмэгтэй, хүүхэд гэсэн ангилалтаар хязгаарлан авч үзэх нь эмзэг хохирогчийн дүр төрхийг илэрхийлж чадахгүй. Иймд хохирогчийг дурдсан ангилалтаар нарийвчлан ангилах, өөрийн орны онцлогт тохирсон шалгуур үзүүлэлтийг боловсруулах шаардлагатай.


1.3. Гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршиг, нөхөн төлөлт

1985 онд НҮБ-ын Ерөнхий ассамблейн шийдвэрээр баталсан “Гэмт хэрэг болон албан тушаалын байдлаа урвуулан ашигласны улмаас хохирогчдын талаарх хууль цаазын үндсэн зарчмын тухай Тунхаглал”-д хохирогч этгээдэд учирсан хор хохирлыг арилгах асуудлыг шийдвэрлэхэд зарчмын ач холбогдолтой дараах заалтуудыг тусгасан юм:

- 1) Зохих нөхцөл байдал бүрдсэн үед эрх зүй зөрчигч өөрөө буюу эсхүл түүний үйл ажиллагааны төлөө хариуцлага хүлээгч гуравдагч этгээд нь хохирогч, түүний гэр бүл, тэжээн тэтгүүлэгчдэд нөхөн төлбөрийг шударгаар олгоно. Хор хохирлыг ийнхүү арилгах нь эд хөрөнгө буцаан олгох, гэм хор, хохирлыг нөхөн төлөх, хохирлыг арилгахад гарсан зардлыг төлүүлэх, үйлчилгээ үзүүлэх, эрхийг нь сэргээх явдал хамаарна /8§/;
- 2) Засгийн газар нь хохирол арилгах явдлыг эрүүгийн ял шийтгэлийн нэгэн төрөл болгон хуульчлах талаар авч үзвэл зохино /9§/;
- 3) Нөхөн төлбөрийг эрх зүйн зөрчил гаргагчаас болон бусад эх үүсвэрээс бүрэн хэмжээгээр гаргуулан авах боломжгүй бол төр нь дараах этгээдэд санхүүгийн нөхөн олговор олгох арга хэмжээ авна. Үүнд: хүнд гэмт хэргийн улмаас бие махбодид нь ихээхэн гэмтэл учирсан, эсхүл бие, сэтгэл санааны эрүүл мэндийн байдлыг алдагдуулсан хохирогчид; гэмт явдлын улмаас нас барсан, бие, оюун санааны хувьд үйл ажиллагааны чадамжгүй болсон хохирогчийн гэр бүлийн гишүүд, тэжээлгэн тэтгүүлэгчид зэрэг /12§/;
- 4) Хохирол нөхөн төлбөр, олговрын үндэсний фонд байгуулах, бэхжүүлэх, өргөжүүлэхэд нөлөө үзүүлэх. Шаардлагатай үед, тухайлбал, төрөөс хохирсон иргэндээ нөхөн төлбөр, олговрыг хариуцан олгох чадваргүй зэрэг тохиолдолд бусад фонд байгуулж болно /13 §/ гэжээ.

¹² 2005 оны Удирдах зарчмуудын 9 зүйлийн “а” хэсэг.

График 5.



Хохирогчийн эрхийг хамгаалах, хангах олон улсын стандартад “гэмт хэргийн хохирогч нь гэмт хэргийн улмаас учирсан бие махбодын ба сэтгэцийн гэмтэл, сэтгэл зүйн хор уршиг, алдагдсан орлого, эмчилгээний төлбөр, төрөөс тогтоосон, нийгмийн халамжийн тогтолцооноос нөхөн төлбөр авах эрхтэй. Мөн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гэмт этгээдээс нөхөн төлбөр авах боломжоор хангагдсан байх ёстой. Гэмт хэрэгтнээс нөхөн төлбөрийг цувруулан төлөхөөр тогтоосон үед нөхөн олговор олгох замаар хохирогчийн хохирлыг шууд арилгаж, эрх зүй зөрчигчөөс дараа нь гаргуулж авах эрх төрд нээлттэй байна. Хүч хэрэглэсэн гэмт хэргийн хохирогчийн тэжээн тэтгүүлэгчид нь тэжээгчээ алдсаны болон хохирогчийн нийгмийн байдлаас хамаарсан хэмжээний тусгай нөхөн төлбөр, олговрыг авах эрхтэй” гэжээ.

Нөхөн олговрын журам нь эд хөрөнгийн хохирол учруулсан гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг бие даан төлөх чадваргүй гэмт этгээдийн хохирогч болон хүч хэрэглэсэн гэмт хэргийн хохирогчид эхний ээлжид хамаарна¹³.

2018 онд хохирсон иргэд хохирсон хүн 8.7%-иар буурсан

Хүснэгт 3.

Д/д	Он	Нийт хохирогч иргэн	Нас барсан хүн
1	2017	32259	1129
2	2018	36220	934
	Дүн	68479	2063

¹³ Нямсүрэн Ч. Гэмт хэргийн виктимологи. Уб., 2005. 256 дахь тал.

График 6.



Гадаад улс орнуудын туршлагаас дүгнэлт хийхэд хохирогчийг хамгаалах, түүнд туслах арга хэмжээ нь дараах хэд хэдэн чиглэлтэй байна:

- 1) Эд хөрөнгөд халдсаны улмаас учирсан эд хөрөнгийн хохирлыг алдагдсан орлогын хамт нөхөн төлөх;
- 2) Бие махбодын хүчирхийллийн үр дагавар болсон (эрүүл мэнд, амь насанд учирсан) эд хөрөнгийн хохирлыг нөхөн төлөх;
- 3) Оюун санааны хохирлыг арилгах (эд хөрөнгийн хэлбэрээр буюу хохирлыг арилгах бусад хэлбэрээр);
- 4) Хохирогчийг ёс суртахуун-сэтгэл зүйн хувьд нөхөн сэргээж, нийгэмд дасан зохицоход нь туслах;
- 5) Дахин хохирохоос нь хамгаалж, аюулгүй байдлыг нь хангах.

Эдгээр үндсэн чиглэлээс урган гарсан зорилтуудыг шийдвэрлэх нь эцсийн дүндээ тухайн улсын иргэд болон нутаг дэвсгэр дээр оршин суугаа бусад этгээдийг хамгаалах нэг чухал чиг үүрэг бүхий төрийн эзлэх байр суурийг тодорхойлохтой нягт холбоотой. Практикт үндэслэгдсэн онолын, мөн түүхэн амьдралаар шалгагдсан тухайн суудлыг шийдвэрлэх хэд хэдэн арга замыг тодорхойлж болно:

- 1) Хохирогчид учирсан эд хөрөнгийн хохирлыг гэмт хэрэгтнээс нөхөн сэргээлгэх буюу нөхөн төлүүлэх;
- 2) Хохирогчид учирсан эд хөрөнгийн хохирлыг хохирогчийг хамгаалах зорилгоор байгуулагдсан олон нийтийн фонд, байгууллагын хөрөнгөөр нөхөн төлөх;
- 3) Хохирогчид учирсан эд хөрөнгийн хохирлыг төрөөс нөхөн олговор олгох замаар шийдвэрлэх;
- 4) Хохирогчийг бие махбод болон оюун санааны хувьд нөхөн сэргээх (гэмтэл, өвчин, сэтгэл зүйн хямралыг эмчлэх, зарим тохиолдолд өөрийн гэм буруу, хохирол учирсан байдлаас нь гэтэлгэх);
- 5) Нийгмийн сэтгэл зүйг хохирогчид ашигтайгаар эргүүлэх, бичил түвшинд болон түүний эргэн тойронд ёс суртахууны тааламжтай байдлыг бүрдүүлэх;
- 6) Гэмт хэргийн дараах (посткриминаль) үеийн нөлөөлөл, халдлагаас хохирогчийг хамгаалах, арга хэмжээ, хөтөлбөрийг хэрэгжүүлэх.

Хүснэгт 4.

Он	Гэмтсэн хүн	Гэмтлийн зэрэг			Хүйс, нас				
		Хөнгөн	Хүндэвтэр	Хүнд	Эмэгтэй	18 хүртэлх	18-30	31-35	36-аас дээш насны
2017	10513	8344	1404	765	-	1251	4350	1785	3127
2018	9283	7444	1261	578	738	1073	5604	600	2006
Дүн	19796	15788	2665	1343	738	2324	9954	2385	5133

График 7.

Гэмтсэн хүний насны ангилал 2017-2018 он





График 8.

Гэмтлийн зэрэг /2017-2018 он/




Хүснэгт 5.

№	Он	Учирсан нийт хохирол (сая.төг)	Битүүмжилсэн хөрөнгө (сая.төг)	Нөхөн төлүүлсэн хохирол (сая.төг)
1	2017	198073.2	36668.5	74508.2
2	2018	193315.1	12777.3	32444.1
	Дүн	391388.3	49445.8	106952.1

График 9.

Нийт хохирол, битүүмжилсэн хөрөнгө
(2017-2018 онд сая.төг)



7.4. Гэмт хэрэгт хохирох эрсдэл: тооцох аргачлал, аюулгүй байдлын зэрэглэл

Орчин үеийн америкийн криминологийн бүтээлүүдэд “Victim precipitation” гэдэг нь гэмт хэрэг үйлдэхэд санаатай буюу болгоомжгүйгээр хөнгөвчлөл үзүүлж буй хохирогчийн зан үйл¹⁴ мөн гэж тодорхойлжээ.

Хохирох эрсдэл нь субъектээс нийгэмд аюултай үзэгдлийн хохирогч болох магадлал учраас виктимологийн ерөнхий онолын ойлголтоор энэ нь нийгмийн /аюулгүйн хэм хэмжээний зан үйлийн гажилт ба гүйцэтгэх үүргийн хохирогчийн байдлын тодорхойлолт/, сэтгэцийн /эмгэг виктимность, гэмт хэрэг болон бусад гаж үзэгдлээс айх/, ёс суртахууны /өөрийгөө хохирогч хэмээн тооцох, гэмт явдлын болон виктим-субкультурын зан үйлийн журам, виктимоген хэм хэмжээг дагаж мөрдөх гэх зэрэг/ үзэгдэл мөн.

Гэмт хэрэгт хохирох хамтын эрсдэлийн үзүүлэлтүүд нь /түүний түвшин, бүтэц зохион байгуулалт, төрөл, хөдөлгөөн гэх зэрэг/ чухамдаа гэмт явдлын буюу хамтын (нийтлэг) виктимизацийн үр дүнг тусгаж чадна.¹⁵ Ийм учраас хэрэгжиж байгаа хохирох хамтын эрсдэл нь виктимизацийн байдлаар /түвшин, бүтэц ба хөдөлгөөн/ тодорхойлогдоно.

Хохирох эрсдэлийн түвшин гэдэг нь бие хүнд хохирол учруулж байгаа гэмт хэргийн туйлын тоогоор илэрхийлэгдэх тоо хэмжээ бөгөөд эдгээр гэмт хэргийн хохирогчийн тоо, түүнчлэн гэмт хэргийн улмаас хохирол учирсан тохиолдолд эрсдэлийн түвшин нь гэмт хэрэг ба хохирогчоос илүү байж болно.

Хохирох эрсдэлийн индекс /буюу коэффициент/ нь хохирч болох эрсдэлийг тодорхойлж байгаа харьцангуй хэмжүүрүүдийг тусгана. Тэд нь зарчмын хувьд гэмт явдлын индекс тэй адил төсөөтэй байна.

¹⁴ Freda Adler, Gerhard O.W. Mueller, William S. Laufer. Criminology second edimion. New York., 1995. P.522.

¹⁵ Коновалов. В.П. Изучение потерпевших с целью совершенствования профилактики правонарушении. М.: ВНИИ МВД СССР. 1982.С 10.

Хохирох эрсдэлтэй этгээдүүдийн индекс нь тодорхой цаг үеийн, аль нэг нутаг дэвсгэр дэх, нийт хүн амын 10 мянга, эсхүл 100 мянган хүнийг харгалзсан гэмт хэргийн хохирогчийн тооноос бодож гаргана. Энэ үзүүлэлт нь зөвхөн харьцангуй тоогоор илэрхийлэгдэнэ.

Энэ тооцоо нь:

$$K_{ээ} = \frac{XT}{XA} \cdot 1000$$

гэсэн томъёогоор илэрхийлэгдэнэ. Үүнд:

$K_{ээ}$ = Хохирох эрсдэлийн коэффициент;

XT= хохирогчийн тоо;

XA= бүс нутгийн нас үл харгалзсан бүх хүн ам.

Хохирох тусгай эрсдэл нь:

$$K_{тээ} = \frac{XT}{XA} \cdot 1000$$

гэсэн нэр томъёогоор тооцогдоно. Үүнд:

$K_{тээ}$ = тусгай эрсдэлийн коэффициент буюу өөрөөр хэлбэл тодорхой гэмт хэргийн үр дагаврын эрсдэл;

XT=тодорхой төрлийн гэмт хэргийн хохирогчийн тоо;

XA=бүс нутгийн нас үл харгалзсан бүх хүн ам.

Мөн зөвхөн гэмт хэргийн хохирогчоор тооцогдсон бодит эрсдэлээс гадна, гэмт хэргийн нийт хохирогчийн коэффициентыг мөн адил томъёогоор гаргах болно. Тухайлбал:

$$K_{бх} = \frac{ГХХ}{XA} \cdot 1000$$

$K_{бх}$ = нийт хүн амын хохирох эрсдэл;

ГХХ=гэмт хэргийн бүх хохирогчдын тоо;

XA=бүс нутгийн нийт хүн ам;

Мөн дараах томъёогоор тодорхой төрлийн гэмт хэрэгт хохирох тусгай эрсдэлийг тооцож болно.

$$K_{бхтэ} = \frac{ГХХ_T}{XA} \cdot 1000$$

Үүнд:

$K_{бхтэ}$ = тодорхой төрлийн гэмт хэргийн тусгай эрсдэлийн коэффициент;

ГХХ_T = тодорхой төрлийн гэмт хэргийн хохирогчийн тоо;

XA=бүс нутгийн бүх хүн ам.

Бүх гэмт хэргийн хохирол учруулах аюулын коэффициентыг дараах томъёогоор тооцно:

$$K_{хуа} = \frac{XT}{XT_б} \times 1000$$

$$K_{хуа/бх/} = \frac{ГХХ}{XT_б}$$

зэрэг томъёогоор тооцно. Үүнд: $K_{хуа}$ = хохирол учруулах аюулын коэффициент; $XT_б$ = бодит хохирогчийн тоо;

Тодорхой төрлийн гэмт хэргийн хохирол учруулах аюулын коэффициентыг дараах томъёогоор бодож олно:

$$K_{тхуа} = \frac{ГХХ_T}{XT_бт}$$

$$K_{тхуа} = \frac{XT_T}{XT_бт}$$

Үүнд:

$K_{тхуа}$ = тодорхой төрлийн гэмт хэргээс хохирол учруулах аюулын коэффициент;

$XT_бт$ = тодорхой төрлийн гэмт хэргийн бодит хохирогчийн тоо;

XT_T = тодорхой төрлийн бүх гэмт хэргийн хохирогчийн тоо.

Хохирол гэдэг нь байгалийн гамшиг, учрал зэрэг үйл явдал, хүмүүсийн зан үйлийн /үйлдэл ба эс үйлдэхүй/ улмаас учирсан алдагдлыг хэлнэ. Ийм учраас хохирол нь объектив буюу субъектив шалтгаанаар бий болно. Байгалийн гамшиг, учрал гэх зэрэг гэнэтийн аюул, занал нь хүний хүсэл зоригоос үл хамаарч, ямагт объектив шалтгаантай байх нь зүйн хэрэг. Гэмт хэргийн виктимологийн талаас авч үзэхэд гэмт явдлын хохирол нь зөвхөн гэмт хэрэгт хохирох явдлын /виктимизацийн/ үр дагавар мөн.

НҮБ-ын 1985 оны “Гэмт хэрэг болон албан тушаалын байдлаа урвуулан ашигласны улмаас хохирогчдын талаарх хууль цаазын үндсэн зарчмын тунхаглал”-д зааснаар гэмт хэргийн хохирол нь: “...эрүүгийн хуулийг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйн улмаас бие махбодын болон оюун санааны гэмтэл учирсан, сэтгэл санааны дарамтад орсон, эд хөрөнгийн хохирол учирсан, эсхүл үндсэн эрх нь зөрчигдөх...”¹⁶ зэргийг оруулан тооцсон байна. Иймд хохирол нь эд хөрөнгийн, бие махбодын, оюун санааны зэрэг уламжлалт ангилалтаас гадна үндсэн эрх зөрчигдсөн гэсэн өөр төрөл байж болох олон улсын эрх зүйн үндэслэл байдаг.

1.5. Гэмт хэрэгт хохирохоос урьдчилан сэргийлэх ажил, үр дүн, чиг хандлага

Виктимологийн урьдчилан сэргийлэх ажиллагаа гэдэг нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилтыг шийдвэрлэхэд гэмт хэргийн хохирогчтой холбоотой боломжийг ашиглах явдал мөн. Ийм учраас дэлхийн олон улс оронд гэмт явдлаас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд виктимологийн урьдчилан сэргийлэх арга хэмжээг шинээр боловсруулж өргөнөөр ашиглах боллоо.

Гэмт явдалтай тэмцэх арга хэмжээний нэг бүрэлдэхүүн хэсэг бол гэмт явдлаас урьдчилан сэргийлэх ажил мөн. Криминологи, виктимологийн шинжлэх ухаанд: prevention (урьдчилан сэргийлэх гэсэн утгатай латин үг) ба prophylactic (урьдчилан хамгаалах гэсэн утгатай грек үг) гэсэн хоёр нэр томъёо хэрэглэгдэж байна. Ихэнх эрдэмтдийн тайлбар, толь бичигт энэ хоёр ойлголтыг ижил утгатай гэж байгаа боловч, гэмт хэрэгтэй тэмцэх практикт “превенци” гэдэг нь урьдчилан сэргийлэх арга хэмжээ, харин “профилактика” нь урьдчилан сэргийлэх ажил, өөрөөр хэлбэл урьдчилан сэргийлэх цогцолбор арга хэмжээ гэсэн утгаар голлон хэрэглэгдэж байна.

Орчин үед “гэмт хэргийг урьдчилан сэргийлэх”, “гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” гэсэн хоёр ойлголт, нэр томъёо зэрэгцэн оршиж байна. Нэг нь тухайн үзэгдлийг гаргуулахгүй байх, нөгөө нь тухайн үзэгдэлд өртүүлэхгүй байх гэсэн утгаар тайлбарлаж болно. Ийм учраас криминологийн шинжлэх ухаан нь гэмт хэргийг болон гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нийтлэг асуудлыг, виктимологийн шинжлэх ухаан нь гэмт хэргээс хохирч болзошгүй этгээдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, өөрөөр хэлбэл **гэмт хэрэгт хохирохоос урьдчилан сэргийлэх** асуудлыг судална гэж ойлгож болно.


Гэмт явдлыг урьдчилан сэргийлэх ба эрх зүй зөрчигчидтэй харилцах талаарх НҮБ-ын VII конгресс дээр олон улсын эдийн засгийн шинэ харилцаа, түүний хөгжлийн чиглэлээр гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ба эрүүгийн процессын тулгуур зарчмуудыг баталсан байдаг. Тухайн баримт бичгийн үндэслэлд зааснаар НҮБ-ын гишүүн улс орнуудын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажиллагааг сайжруулах зорилгоор “гэмт хэргийн хохирогчдыг эрх зүйн хамгаалалтын үр нөлөөтэй арга хэрэгслээр хангахын тулд хууль зүйн болон бусад шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг” зөвлөмж болгосон билээ¹⁷.

¹⁶ Хүний эрх. Шүүх эрх мэдлийн салбар дахь хүний эрх. НҮБ. УБ., 1996. 174 дэх тал.

¹⁷ Руководящие принципы в области предупреждения преступности и уголовного правосудия в контексте развития и нового международного экономического порядка // Международные соглашения и рекомендации Организации Объединенных Наций в области защиты прав человека и борьбы с преступностью: Сб. междунар. документов. - М.: Академия МВД СССР, 1989. - С. 154.

График 10.

Гэмт халдлагад өртөх шалтгаан, нөхцөл
(2017-2018 он)



Германы эрдэмтэн Г.Кайзер урьдчилан сэргийлэх ажлын анхдагч, хоёрдогч, гуравдагч ажиллагаа гэсэн төрлийг авч үзжээ¹⁸. Урьдчилан сэргийлэх анхдагч /превенци/ ажиллагаа нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл хэрэгт нийгэм-улс төр, эдийн засаг, нийгэм-соёлын зайлшгүй шаардлагатай урьдчилсан нөхцөл, хувь хүн нийгэмших хамгийн оновчтой нөхцөлийг бий болгоход чиглэсэн зорилгоор тодорхойлогдоно. Хоёрдогч превенци нь ихэвчлэн хууль цаазын бодлого, урьдчилан сэргийлэх нийтлэг арга хэмжээний хүрээнд түүний хэрэгжилт зэргээр тодорхойлогдоно. Гуравдагч превенци нь юуны түрүүнд рецидив гэмт явдалтай эрүүгийн эрх зүйн болон цагдаагийн арга хэрэгслүүдээр тэмцэх тэмцлийг авч үзсэн байна¹⁹.

АНУ-д гэмт хэргээс болон гэмт хэрэгт хохирохоос урьдчилан сэргийлэх нь гэмт явдлын түвшин, тулгарч байгаа гэмт хэргийн аюулыг бууруулах гэсэн өргөн утгаар тайлбарлагдаж байна. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бүтэц нь: 1) гэмт хэргээс орчин тойрны болон хөршийн хамгаалалтыг бий болгох, 2) гэмт хэрэг үйлдэгдэх магадлал өндөртэй тохирооны эрсдэлийг бууруулах, 3) гэмт хэрэг үйлдэгдэх боломжийг таслан зогсооход анхаарал төвлөрүүлж байна. Үйл ажиллагааны энэ гурван салбар (аюулгүй орчин /safe environment/, хохирч болзошгүй өндөр эрсдэл /high-risk potential/, үйлдэгдэж болзошгүй гэмт хэрэг /and future crime/) нь анхдагч, хоёрдох, гуравдах урьдчилан сэргийлэх гэсэн агуулгыг илэрхийлж байгаа юм²⁰.

Ийм учраас гэмт явдлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ нь: нэгдүгээрт, гэмт хэрэг үйлдэж болзошгүй этгээдэд өөрт нь нөлөөлж гэмт хэрэг үйлдүүлэхээс урьдчилан сэргийлэх; хоёрдугаарт, гэмт хэрэг үйлдэгдэхэд нь тус дөхөм үзүүлж байгаа шалтгаан нөхцөлийг арилгах хоёр талт үйл ажиллагаа мөн. Гэмт хэрэгт хохирохоос урьдчилан сэргийлэх виктимологийн арга хэмжээ нь гэмт хэрэг үйлдэгдэх шалтгаан, нөхцөлийг арилгах арга хэмжээний нэг үндсэн хэлбэр болно.

Виктимологийн урьдчилан сэргийлэх арга хэмжээ нь нийгмийн түвшинд эдийн засаг, улс төр, үзэл суртал, зохион байгуулалт, эрх зүйн шинжтэй арга хэмжээний хүрээнд хэрэгжинэ. Гэвч эдгээр арга хэмжээ нь гэмт явдал гарах, гэмт явдалд хохирох хүчин зүйлүүдийг арилгах, гэмт хэрэг үйлдэгдэх эрсдэлийг багасгах нөхцөл байдлыг бүрдүүлэх хэтийн зорилго, зорилтыг агуулна.

¹⁸ Кайзер Г. Общественное мнение об уголовном законе, виновности, наказаниях, преступниках и жертвах // Материалы IV советско-западногерманского симпозиума по проблемам криминологии, уголовного права и процесса. - Киев: Наукова думка, 1990.

¹⁹ Х.-Ю. Кернер. Криминология. Словарь- справочник., М.,1998. С 231.

²⁰ Brantingham, P. and F. Faust. (1976). "A conceptual model of crime prevention." Crime and Delinquency 22: 284-296.

Гэмт явдлаас урьдчилан сэргийлэх тусгай ажиллагаанд урьдчилан сэргийлэх зорилтыг шийдвэрлэхэд шууд чиглэсэн арга хэмжээнүүд багтана. Энэ арга хэмжээг хэрэглэх хүрээ нь гэмт хэрэг үйлдэж болзошгүй этгээд, гэмт хэрэгтнээр хязгаарлагдахгүй, мөн хохирогч /бодит (*actual victims*) буюу нууц (*latent victims*)/, түүнчлэн өөрийн зан чанарын хувьд гэмт хэргийн хохирогч болон төлөвшиж, эцэстээ гэмт хэргийн нэг оролцогч болон хувирах /хувирч болох/ эрсдэл бүхий этгээдүүд багтана²¹.

Энэхүү нөхцөл байдал нь виктимологийн урьдчилан сэргийлэх ажил²² (prophylactic) үүсч хөгжиж, виктим /өөртөө аюултай, эрсдэлтэй/ зан үйлээс урьдчилан сэргийлэх шинэ боломжийг нээнэ.

Виктимологийн урьдчилан сэргийлэх ажил нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нийгмийн тогтолцооны хүрээнд багтаж, гэмт хэргийн далд хохирогчийн хамгаалалтын боломжийг идэвхжүүлэх, тэдний аюулгүй байдлыг хангах, виктим, өртөмтгий сөрөг чанар, зан үйлийг арилгах замаар хувь хүний болон хамтын хохирох эрсдэлийг багасгахад чиглэгдсэн нийтлэг болон тусгай арга хэмжээний дэд тогтолцоо юм.

Виктимологийн урьдчилан сэргийлэх ажиллагаа нь:

- 1) Гэмт хэрэгт хохирч болзошгүй этгээд /хохирогч/ болон бодит хохирогч зэрэг өөрийн бие даасан нөлөөллийн объектой;
- 2) Криминологийн урьдчилан сэргийлэх ажлын мэдээ мэдээллээс гадна, мөн өөрийн гэсэн мэдээллийн өвөрмөц эх сурвалжтай;
- 3) Ажил, арга хэмжээний хэлбэр нь ихэвчлэн итгүүлэн үнэмшүүлэх арга дээр тулгуурлаж хэрэгжинэ;
- 4) Виктимологийн нийтлэг ба нэг бүрчилсэн урьдчилан сэргийлэх арга хэмжээ нь олон нийттэй харилцах боломжийн үндсэн дээр хэрэгжинэ;
- 5) Энэ арга хэмжээ нь хэдийгээр хохирол учруулах этгээд харахан тогтоогдоогүй байгаа боловч, хохирч болзошгүй этгээдийн /далд хохирогчийн/ тодорхой хэв маягт баримжаалж, хохирох үндэслэл байгаа аюултай /виктим/ тохироог саармагжуулах замаар хэрэгжинэ;
- 6) Виктимологийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний зорилт нь хохирч болзошгүй этгээдэд /юуны түрүүнд гэмт тохироо үүсгэх нөхцөлийг бүрдүүлсэн, санаачилсан, өдөөн хатгасан/ нөлөөлөх замаар гэмт хэрэгтэн-хохирогчийн гүйцэтгэх үүрэг нь солигдож байгаа "тонгороо /инверси/" гэж нэрлэгдэх гэмт хэргээс урьдчилан сэргийлнэ;
- 7) Зохион байгуулалтын өвөрмөц онцлог зэрэг шинжээр гэмт хэргийн криминологийн урьдчилан сэргийлэх ажиллагааны бие даасан чиглэл гэж үзэх боломжийг олгож байгаа юм.

Виктимологийн шинжтэй арга хэмжээнүүд нь хохирох эрсдэлийн нөхцөлийг бүрдүүлж, дэмжин тэтгэж байгаа хүчин зүйлүүдийг саармагжуулах буюу арилгах ажиллагаа юм.

Виктимологийн урьдчилан сэргийлэх ажил нь өөртөө гэмт хэргийн хохирогчийн хууль зөрчсөн, ёс суртахуунгүй зан үйлийн шалтгаан болсон буюу мөн хууль ёсны, онцгой идэвхтэй зан үйлийн үед хохирч болох эрсдэлийг нэмэгдүүлж байгаа хүчин зүйлүүдэд нөлөөлөх арга хэмжээнүүдийг агуулна. Ийм учраас түүний ач холбогдол нь тухайн хүчин зүйлүүдтэй холбоотой, урьд өмнө ашиглагдаж байгаагүй боломжийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх практикт нэвтрүүлэхэд оршино.

Виктимологийн урьдчилан сэргийлэх арга хэмжээ нь гэмт явдлаас урьдчилан сэргийлэх бусад бүхий л үйл ажиллагаатай нягт уялдаа холбоотой. Захиргааны хяналтад байгаа этгээдүүд нь гэмт хэрэг үйлдэх бүрэн бололцоотой байхын хамт, тэдний олонх нь

²¹ Д.В.Ривман.Криминальная виктимология. СПб., 2002. С 240-241.

²² Мөн тэнд үз.: Оросын эрдэмтэн Д.В.Ривман "виктимологийн профилактика буюу урьдчилан сэргийлэх ажил гэж гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгыг хэрэгжүүлэхийн тулд гэмт хэргийн хохирогчтой ямар нэгэн хэмжээгээр холбоотой боломжуудыг ашиглахыг ойлгоно" гэжээ.

гэмт хэрэгт хохирч болох өндөр магадлал, эрсдэлтэй байх жишээтэй. Юуны өмнө архидан согтуурах, мансуурах, жижгээр танхайрах, биеэ үнэлэхтэй холбоотой эрх зүйн зөрчилд байнга орооцолдож “хэл ам тарьж” байдаг этгээдүүд гэмт хэрэгт илүүтэй өртөгдөнө.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний амжилт, үр дүн нь энэхүү ажлын зохион байгуулалт, тактикаас олон талаар хамаарна. Нийтлэг болон тодорхой төрлийн гэмт хэргийн механизмыг үнэн зөв илтгэн харуулсан криминологийн хүчин зүйлүүдийн; гэмт хэрэг үйлдэгдсэн орон байр, цаг хугацаа, арга хэрэгсэл, мөн гэмт хэрэгтэн, хохирогчийн нийтлэг хэв маягуудын тоо бүртгэл хөтлөх нь чухал ач холбогдолтой. Эдгээр нь виктимологийн урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах, бэлтгэж байгаа болон сэдэгдэж байгаа тодорхой гэмт хэргийг таслан зогсоох арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлэхэд онцгой үүрэгтэй.

Гэмт хэрэг үйлдэж болзошгүй этгээд нь хуулийн байгууллагын анхаарлын төвд байсан, байх ч болно. Гэхдээ гэмт хэрэгт өртөгдөж болзошгүй этгээд, хохирогчид нь урьдчилан сэргийлэх ажлын бүрэн ашиглагдаагүй асар их нөөц боломж гэдэг нь эргэлзээгүй.

Виктимологийн урьдчилан сэргийлэх арга хэмжээг:


- Гэмт хэргийн урьдчилан сэргийлэх ажлын төрөл */ерөнхий, тусгай, нэгбүрчилсэн/;*
- Гэмт хэрэгт хохирох явдлын субъект */хувь хүн, хуулийн этгээд, нийгмийн нийтлэг, хамтлагийн дунд зохиох/;*
- Хувь хүнд хохирол учрах аюул дагуулсан тохирооны шинж чанар */стратегии, тактик, хойшлуулшгүй арга хэмжээ/;*
- Тодорхой төрлийн гэмт хэргийн криминологи, виктимологийн */хүч хэрэглэсэн, шунахайн гэмт явдлын, зохион байгуулалттай, болгоомжгүйн гэмт явдлын/ шинж;*
- Гэмт хэрэгт хохирох эрсдэл бүхий этгээдүүдийн хүн ам зүй, нийгэм- сэтгэл зүйн шинж */нас, хүйс, нийгмийн гарал, ажлын онцлог, хувь хүний зан чанар гэх зэрэг/ зэрэг үндэслэлээр ангилж болох хэтийн төлөв нээлттэй байна.*

Цаашид виктимологийн судалгааны урьдчилан сэргийлэх арга хэмжээний чиглэл цоо шинэ учраас түүний гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нөөц бололцоог судлан шинжлэх, гэмт хэрэгт хохирохоос урьдчилан сэргийлэх, дахин хохирохоос хамгаалах арга зүй, арга, аргачлал боловсруулах бүхий л хандлага, арга зам нээлттэй байна.

Дэлхийд шинэ дутам хөгжиж байгаа виктимологийн шинжлэх ухааны судалгааны гол асуудал болох гэмт хэрэгт хохирох явдал, гэмт хэрэгт хохирох эрсдэл, гэмт хэрэгт хохироход нөлөөлж буй объектив (нас, хүйс, төрийн болон нийгмийн статус, орон зай, цаг хугацаа, тохироо), субъектив (хувь хүний сэтгэцийн шинж, гэмт хэргийг өдөөх зан үйл, хохирох хувийн эрсдэл) шалтгаан нөхцөл, нийгэм, улс төр, эдийн засгийн болон хүн ам зүйн шилжилт хөдөлгөөн, гэмт хэргийн архитектур болон бусад хүчин зүйлийг нарийвчлан судлах арга зүй, арга, аргачлалыг орчин үеийн түвшинд боловсруулж, виктимологийн судалгааг төрийн бодлогын хэмжээнд авч хэрэгжүүлэхгүй бол гэмт хэрэгт хохирох явдлын гаралтын бодит байдлыг үнэн зөв тодохойлж, гэмт хэрэгт хохирохоос урьдчилан сэргийлэх хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх боломжгүй.

НАЙМДУГААР
БҮЛЭГ

МОНГОЛ УЛС ДАХЬ
НУУГДМАЛ ГЭМТ
ЯВДЛЫН ТҮВШИНГ
ТООЦСОН БАЙДАЛ



1. НУУГДМАЛ ГЭМТ ХЭРГИЙН ТҮВШИНГ СУДЛАХ ШААРДЛАГА, ҮНДЭСЛЭЛ

Гэмт хэргийн индексийн гаргадаг Олон Улсын байгууллагын судалгаагаар 2017 онд Монгол Улс дахь иргэдийн аюулгүй байдлын түвшин 32.8%, иргэд гэмт хэрэгт өртөх эрсдэл буюу гэмт хэргийн түвшин 67.2%-тай байсан нь дэлхийн 118 улсаас 12 дугаар байрт орж байсан бол 2018 оны эцсийн байдлаар иргэдийн аюулгүй байдлын түвшин 37.4%, гэмт хэргийн түвшин 62.5%-тай болж өмнөх жилтэй харьцуулахад нөхцөл байдал бага зэрэг сайжирч 16 дугаар байрт оржээ. Харьцуулсан судалгааны дүнгээс үзэхэд Монголчуудын 70,5% нь ойрын 3 жилийн хугацаанд гэмт хэрэг өснө гэж санаа зовниж байгаа бол эд хөрөнгөө хулгайд алдана, бусдын халдлагад өртөнө гэхээс 60% нь түгшиж байна гэжээ¹.

Дээрх судалгааны дүнгээс иргэдийн аюулгүй байдлыг хангах шаардлага зүй ёсоор гарч байгаа ба үүнд Монгол Улс дахь гэмт хэргийн нөхцөл байдлыг бодитойгоор тодорхойлж, нуугдмал гэмт хэргийн түвшинг тооцох шаардлага урган гарч байна.

Судалгааны ажлын зорилго нь Монгол Улс дахь нуугдмал гэмт явдлын түвшинг иргэдийн хохирсон байдлын судалгаагаар дамжуулан тогтооход чиглэгдсэн. Дээрх зорилтын хүрээнд 1/ Монгол Улс дахь 2018 оны нуугдмал гэмт хэргийн түвшинг тооцоолох, 2/ аймаг, нийслэл, дүүргүүд дэх нуугдмал гэмт хэргийн түвшинг тодорхойлох, 3/ тодорхой төрлийн нуугдмал зарим гэмт хэргийг тодорхойлоход чиглэгдсэн.

2. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Түүврийн хэмжээ:

Иргэдийн судалгаанд² нийт 810 иргэн хамрагдсанаас 632 нь 21 аймгаас, 178 нь Улаанбаатар хотын 6 дүүргээс тус тус оролцсон болно. Судалгааны түүвэрлэлтэд нийслэлийн 6 дүүрэг, 21 аймгийн төвөөс тус бүр 30 оршин суугчийг сонгон авсан бөгөөд 2018 оны байдлаар тухайн нутаг дэвсгэртээ амьдарсан байх шаардлага тавьсан. Энэхүү судалгаа нь өмнөх жилтэй харьцуулахад түүврийн хэмжээг нэмэгдүүлж бүх аймгийг хамруулсан онцлогтой.

Судалгаанд оролцогчдын талаас илүү хувь нь эмэгтэйчүүд (54.9) байсан бол 45.1% нь эрэгтэйчүүд байв. Насны бүлгээр авч үзвэл, 60.4% нь 25-44 насныхан, 20 орчим хувь нь 24-өөс доош болон 55-аас дээш насныхан эзэлж байна. Оролцогчдын боловсролын хувьд 45% нь дээд боловсролтой, 52% нь бүрэн болон бүрэн бус дунд, 3 орчим хувь нь бага болон боловсролгүй иргэд байв. Нийт оролцогчдын 40 орчим хувь нь 500.000 төгрөгөөс доош орлоготой байсан ба 33.2% нь гэр хороололд, 15.2% нь түрээсийн болон урт хугацааны зээлээр авсан орон сууцанд, үлдсэн нь орон сууц болон байшинд тус тус амьдардаг гэж хариулжээ.

Судалгаанд ашигласан мэдээлэл ба асуулт:

НҮБ-ын гэмт хэрэг, мансууруулах бодистой тэмцэх хорооноос гаргасан “Гэмт хэрэгт хохирох явдлын түвшинг тооцох” /National crime victimization survey/ аргачлалын зарчимд тулгуурласан. Гэмт хэрэгт хохирох явдлын түвшинг тооцох гэдэг нь гэмт хэрэг, халдлагад өртсөн боловч цагдаагийн байгууллагад мэдэгдээгүй байгаа нуугдмал гэмт хэргийн түвшинг хохирогчоор дамжуулан тодорхойлох аргачлал.

Энэхүү судалгааг Дотоод хэргийн их сургуулийн Цагдаагийн сургуулийн Эрүүгийн

¹“Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа-2018”. УБ., 2019.

² Дотоод хэргийн их сургуулийн Цагдаагийн сургуулийн Эрүүгийн эрх зүй, криминологийн тэнхимийн багш, судлаачдын хамтарсан баг 2019 оны 06 дугаар сарын 03-ны өдрөөс 2019 оны 09 дүгээр сарын 20-ны хооронд түүвэрт багтсан аймаг, нийслэлийн дүүргийн иргэдийн дунд явуулсан.

эрх зүй, криминологийн тэнхимийн багш, судлаачдын хамтарсан баг 2019 оны 6 дугаар сарын 03-ны өдрөөс 2019 оны 9 дүгээр сарын 20-ны хооронд түүвэрт багтсан аймаг, нийслэлийн дүүргийн иргэдийн дунд явуулсан. Судалгааны хүрээнд “Та өнгөрсөн 1 жилийн хугацаанд гэмт хэргийн хохирогч болж байсан уу? ”, “Өнгөрсөн 1 жилийн хугацаанд таны гэр бүлийн гишүүд, төрөл садан, эсвэл сайн таньдаг хүмүүсийн хэн нэгэн гэмт хэрэгт хохирч байсан уу?”, “Хэрэв хохирогч болж байсан бол цагдаа, хуулийн байгууллагад мэдэгдэж байсан уу?” гэсэн нуугдмал гэмт хэргийг илрүүлэхэд чиглэгдсэн өргөн хүрээний асуултууд багтсан. ЦЕГ-ын 2018 оны гэмт хэргийн статистик үзүүлэлтээс тодорхой төрлийн гэмт хэргийн үзүүлэлтийг авсан болно.

Үр дүнг тооцсон аргачлал:

Үр дүнг тооцохдоо дараах шалгуурыг баримталсан. Үүнд:

1. Судалгаанд оролцогчдоос Монгол Улсын хэмжээнд түгээмэл үйлдэгддэг тодорхой төрлийн 10 гэмт хэрэгт хохирч байсан тохиолдлыг асуулгын аргаар тодорхойлсон бөгөөд хариулыг 1=Тийм, 2= Үгүй гэсэн сонголттой байхаар тооцсон; (Хүснэгт 1)
2. Гэмт хэрэгт хохирсон гэж хариулсан оролцогчдын тоог 100% гэж үзвэл тэдний хэдэн хувь нь цагдаагийн байгууллагад энэ талаараа мэдээлэлж байсныг тооцоолсон; (Хүснэгт 2)
3. Судалгааны үр дүнгийн бодит байдлын шалгуурыг түүвэрлэлтийн техник, хэмжээ, оролцогчдын шинж байдал, томъёоллоор тодорхойлсон;
4. Нуугдмал гэмт хэргийн түвшинг улсын хэмжээнд болон тодорхой төрлийн гэмт хэргийн жишээн дээр гаргахдаа дараах томъёог ашиглан тооцоолсон.

Томьёо 1

$$y = X \left(\frac{1}{K} - 1 \right)$$

X - Цагдаад бүртгэгдсэн гэмт хэрэг

У - Нийт бүртгэгдсэн байх магадлалтай гэмт хэрэг

K- Гэмт хэрэгт өртөөд цагдаагийн байгууллагад мэдэгдсэн коэффициент, “K”-г тодорхойлохдоо гэмт хэрэгт хохирох эрсдэлийн судалгааны асуулгад хохирсон гэж хариулт өгөөд, тэднээс цагдаад мэдэгдсэн хүмүүсийн хувь хэмжээгээр (0-1) үнэлгээгээр тодорхойлно.

Томьёо 2.

$$S=Y-X$$

S- Цэвэр нуугдмал байх гэмт хэргийн тоо

Судалгааны мэдээллийг SPSS.21 програм ашиглан боловсруулсан бөгөөд судалгааны үр дүн, дүгнэлт нь зөвхөн тухайн судалгаагаар тогтоогдсон бодит байдалд үндэслэгдсэн болно

3. НУУГДМАЛ ГЭМТ ХЭРГИЙН ТҮВШИНГ ТООЦСОН БАЙДАЛ

3.1. Гэмт хэргийн чиг хандлагын талаарх төсөөлөл

Нуугдмал гэмт хэргийн түвшинг тодорхойлоход тухайн нутаг дэвсгэр дэх гэмт хэргийн нөхцөл байдлын талаарх иргэдийн төсөөлөл чухал үүрэгтэй байдаг. Хэрэв иргэд гэмт хэргийн нөхцөл байдлын талаар сөрөг төсөөлөлтэй байвал тухайн нутаг дэвсгэр дэх нуугдмал гэмт хэргийн түвшин өндөр байх магадлалтай гэж үздэг. Энэ нөхцөл байдлыг тодруулах зорилгоор судалгаанд оролцсон иргэдэд “Улсын хэмжээнд гэмт хэргийн түвшин ойрын ирээдүйд хэрхэн өөрчлөгдөх вэ?”, “Миний оршин сууж буй нутаг дэвсгэрийн хэмжээнд гэмт хэргийн түвшин ойрын ирээдүйд хэрхэн өөрчлөгдөх вэ?” гэсэн асуулт тавьж хариултыг 1-5 үзүүлэлтээр хэмжихэд дундаж үзүүлэлт 2.82 гарч байна. /Хүснэгт 1./

Хүснэгт 1. Гэмт хэргийн талаарх иргэдийн төсөөлөл

	Их буурна	Буурна	Тодорхой бус	Өснө	Их өснө	Дундаж
Улсын хэмжээнд гэмт хэргийн түвшин	3.2%	28.4%	48%	17.6%	2.8%	2,88
Миний оршин сууж буй нутаг дэвсгэрийн хэмжээнд гэмт хэргийн түвшин	4.6%	32.6%	47.3%	13.4%	2.3%	2,76

Гэмт хэргийн чиг хандлагын талаарх мэдрэмж улсын хэмжээнд **2.82** коэффициентийг илэрхийлж байна

Дээрх судалгаанаас үзэхэд улсын хэмжээний гэмт хэргийг нийт судалгаанд оролцогчдын 31,6% нь буурна гэж үзсэн бол өөрийн оршин сууж буй нутаг дэвсгэрийн гэмт хэргийг буурна гэж 37,2% нь тус тус хариулжээ. Улсын хэмжээнд гэмт хэрэг өснө гэж судалгаанд оролцогчдын 20,4%, орон нутгийн хэмжээнд 15,7% нь хариулснаас үзэхэд иргэд гэмт хэрэг буурна гэсэн хандлагатай байна. Харин аль аль үзүүлэлт дээр нь судалгаанд оролцогчдын 45-аас дээш хувь нь тодорхой бус гэсэн хариултыг сонгосон нь иргэд энэ талаар өөртөө итгэлгүй байгааг илэрхийлнэ. Судалгааны үр дүнгээр 1 гэсэн үнэлгээ рүү ойртох тусам гэмт хэргийг буурна гэж үзэх боломжтой бөгөөд энэ хандлага нь нуугдмал гэмт хэргийн түвшин бага байгааг илэрхийлдэг. Бидний судалгааны үр дүнгээр дундаж үзүүлэлт 2.82 гарч байгаа нь иргэд гэмт хэргийг буурна гэж үзэхгүй байгааг илэрхийлэх бөгөөд нуугдмал гэмт хэргийн түвшин өндөр байгааг харуулж байна.

3.2. Гэмт хэргээс түгших хандлагын түвшин

Нуугдмал гэмт хэргийн түвшинг хэмжих өөр нэг аргачлал нь гэмт хэргээс түгших, айх явдал. Гадаадын зарим оронд явуулсан гэмт хэрэгт хохирох эрсдэлийн судалгааны дүнгээс үзэхэд тодорхой төрлийн гэмт хэрэгт өртөж болзошгүй гэж айдас нэмэгдэх тусам тухайн нийгэм дэх нуугдмал гэмт хэргийн түвшин өндөр гэж үздэг. Өөрөөр хэлбэл, иргэд гэмт хэргээс айх, түгших хандлага өндөр байх нь хууль сахиулах байгууллага гэмт хэргийг бүрэн хяналтдаа авч чадаагүйгээс гэмт хэрэг нуугдмал шинжтэй болж, цагдаагийн байгууллагад бүртгэгдэхгүй байгааг илэрхийлдэг. Нөгөө талаар нийгэмд түгээмэл үйлдэгддэг хэдий ч цагдаагийн байгууллага бүрэн хяналтдаа авч чадаж байвал гэмт хэргээс иргэд түгших хандлага бага байдаг.

Энэ асуудлыг тодорхойлох зорилгоор тодорхой төрлийн 8 гэмт хэргээс түгших хандлагыг дараах асуултаар шалгасан болно. Хүснэгт №3-т үзүүлсэн дүнгээс үзвэл “Хэн нэгэн миний орон байранд хууль бусаар нэвтэрнэ” гэхээс айдаг гэсэн асуултад хариулсан байдлын дундаж нь 3.18 бол дараагийн дугаарт “Хэн нэгэн миний мөнгө болон үнэт эдлэлүүдийг хулгайлна” гэхээс айдаг гэсэн асуултын дундаж хариулт 3.14 гэсэн үзүүлэлттэй байна. Харин хамгийн бага үзүүлэлттэй байгаа гэмт хэргийн төрөлд бэлгийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 2,94 гэсэн үзүүлэлттэй байна. Бусад гэмт хэргийн дундаж үзүүлэлт 3,0 байгаа нь тийм ч сайн үзүүлэлт биш. /Хүснэгт 2./

Хүснэгт 2. Гэмт хэргээс түгших хандлагын үзүүлэлт

Асуулт	Огт айдасгүй байдаг	Айдасгүй байдаг	Тодорхой бус	Айдастай байдаг	Их айдастай байдаг	Дундаж
Миний амь нас, эрүүл мэндэд хэн нэгэн халдаж хохироож болзошгүй гэж	6.4%	22.5%	37.4%	30.4%	3.3%	3,01
Хэн нэгэн миний мөнгө болон үнэт зүйлсийг хүч хэрэглэж авна гэхээс /Дээрэмдэх/	5.7%	23.8%	34.9%	32.2%	3.5%	3,04
Хэн нэгэн миний мөнгө болон үнэт эдлэлүүдийг хулгайлна гэхээс	5.5%	20.8%	32.6%	36.1%	5.1%	3,14
Хэн нэгэн миний эд хөрөнгийг залилан мэхэлж авна гэхээс	5.2%	22%	38.7%	30.2%	3.8%	3,05
Хэн нэгний бэлгийн халдлагад өртөгдөнө гэхээс	8.7%	24.6%	36.1%	25.1%	5.4%	2,94
Мансуурах бодисын хамааралтай болно гэхээс	3.7%	22.4%	39%	30%	4.9%	3,09
Цахим сүлжээнд ямар нэгэн гэмт хэргийн хохирогч болно гэхээс	3.8%	21.1%	33.7%	35.4%	6%	3,18
Авилгын улмаас миний эрх ашиг хөндөгдөнө гэж	6.5%	26%	36.6%	26.3%	4.5%	3,96
Тодорхой төрлийн гэмт хэргийн айдас улсын хэмжээнд 3.05 коэффициентийг илэрхийлж байна.						

Дээрх судалгааны дүнгээс үзэхэд Монгол Улсад мансуурах бодистой холбоотой гэмт хэрэг, бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэг, ялангуяа орон байрнаас эд зүйлийг хулгайлах гэмт хэргээс иргэд хамгийн их түгших хандлагатай байна. Судалгааны хариулт 1 рүү дөхөх тусам эерэг үзүүлэлтийг илэрхийлэх бөгөөд судалгааны дундаж дүнг үзэхэд 3.05 байгаа нь гэмт хэргийн төсөөллөөс илүү гэмт хэрэгт өртөнө гэсэн айдастай байгааг харуулж байна.

3.3. Гэмт хэрэгт шууд болон шууд бусаар хохирсон байдал

Хохирогчоор дамжуулан нуугдмал гэмт хэргийн түвшинг тодорхойлдог аргачлалын дагуу судалгаанд оролцогчдоос Монгол Улсын хэмжээнд түгээмэл үйлдэгддэг 8 төрлийн гэмт хэрэгт хохирч байсан туршлагыг асууж, хариултад дүн шинжилгээ хийсэн болно. Эх олонлогоос түүвэрлэлт хийх замаар судалгаанд оролцогчдыг сонгож авсан бөгөөд эдгээр нь Монгол Улсын нөхцөл байдлыг илэрхийлэх чадвартай гэж үзсэн болно.

Хүснэгт 3-т гэмт хэргийн улмаас сүүлийн 1 жилийн хугацаанд гэмт хэрэгт шууд болон шууд бусаар хохирсон гэж өөрсдийгөө үзсэн иргэдийн хариултыг эрэмбэлэн харуулав. Судалгаанд оролцсон 30,2% нь авилгын улмаас хохирсон гэсэн үзүүлэлт хамгийн өндөр

байсан бол, дараагийн дугаарт 23,9% нь залилах гэмт хэргийн улмаас хохирч болзошгүй гэж түгшиж байна. Мөн хулгайлах, мансуурах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэргийн улмаас хохирч болзошгүй гэж түгших хандлага их байна. Харин хамгийн бага үзүүлэлттэй байгаа гэмт хэргийн хувьд дээрэмдэх, хүчиндэх гэмт хэргүүд орж байна.

Хүснэгт 3. Гэмт хэрэгт шууд болон шууд бусаар хохирсон байдал

№	Гэмт хэргийн төрөл	Тийм (%)	Үгүй (%)
1	Хулгайлах гэмт хэрэгт	23,2 (%)	76,8 (%)
2	Залилах гэмт хэрэгт	23,9 (%)	76,1 (%)
3	Дээрэмдэх гэмт хэрэгт	8,8 (%)	91,2 (%)
4	Авилгын гэмт хэрэгт	30,2 (%)	69,8 (%)
5	Хүчиндэх гэмт хэрэгт	6,2 (%)	93,8 (%)
6	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгт	13,3 (%)	87,7 (%)
7	Цахим гэмт хэрэгт	24,5 (%)	75,5 (%)
8	Мансуурах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэгт	16,5 (%)	84,5 (%)

Гэмт хэргийн улмаас хохирсон хүмүүс ямар арга хэмжээ авсан талаар тодруулах зорилгоор “Хэрэв та өөрөө эсвэл таны гэр бүлийн гишүүд, төрөл садан, эсвэл сайн таньдаг хүмүүсийн хэн нэгэн гэмт хэрэгт хохирч байсан бол цагдаа, хуулийн байгууллагад мэдэгдэж байсан уу?” гэсэн асуултад судалгаанд оролцогчдын өгсөн хариултыг аймаг тус бүрээр Хүснэгт 4-д нэгтгэн харуулав.

Хүснэгт 4. Гэмт хэргийн улмаас хохироод цагдаагийн байгууллагад мэдээлсэн байдал /аймгаар/

№	Нийслэл, дүүрэг, Аймаг	Судалгаанд оролцсон хүний тоо	Гэмт хэрэг, халдлагын улмаас хохирсон гэж хариулсан хүний тоо	Цагдаагийн байгууллагад мэдэгдсэн иргэдийн тоо	Хувь (%)	Нуугдмал байх магадлалын хувь (%)
1	Улсын дүн	810	161	103	63.9	36.0
2	Баян-Өлгий	30	9	6	66.6	33.3
3	Говь-Алтай	30	11	6	54.5	45.4
4	Завхан	30	12	5	41.6	58.3
5	Увс	30	10	5	50	50
6	Ховд	30	13	6	46.1	53.8
7	Архангай	30	11	7	63.6	36.3
8	Баянхонгор	30	10	6	60	40
9	Булган	30	8	4	50	50
10	Орхон	30	14	8	57.1	42.8
11	Өвөрхангай	30	10	7	70	30
12	Хөвсгөл	30	11	6	54.5	45.4
13	Говьсүмбэр	30	6	4	66.6	33.3
14	Дархан-Уул	30	14	8	57.1	42.8
15	Дорноговь	30	10	6	60	40

№	Нийслэл, дүүрэг, Аймаг	Судалгаанд оролцсон хүний тоо	Гэмт хэрэг, халдлагын улмаас хохирсон гэж хариулсан хүний тоо	Цагдаагийн байгууллагад мэдэгдсэн иргэдийн тоо	Хувь (%)	Нуугдмал байх магадлалын хувь (%)
16	Дундговь	30	9	7	77.7	22.2
17	Өмнөговь	30	12	8	66.6	33.3
18	Сэлэнгэ	30	14	9	64.2	35.7
19	Төв	30	12	9	75	25
20	Дорнод	30	11	8	72.7	27.2
21	Сүхбаатар	30	9	6	66.6	33.3
22	Хэнтий	30	11	8	72.7	27.2
23	Улаанбаатар	178	59	34	57.6	42.3

Мөн “гэмт хэрэгт хохирч байсан бол цагдаа, хуулийн байгууллагад мэдэгдэж байсан уу” гэсэн асуултад судалгаанд оролцогчдын өгсөн хариултыг тодорхой хэргийн төрлөөр нь хүснэгт 5-д нэгтгэн харуулав.

Хүснэгт 5. Гэмт хэргийн улмаас хохироод цагдаагийн байгууллагад мэдээлсэн байдал /гэмт хэргийн төрөл/

№	Гэмт хэргийн төрөл	Судалгаанд оролцсон иргэд	Хохирсон иргэдийн тоо	Цагдаагийн байгууллагад мэдэгдсэн иргэдийн тоо	Хувь (%)	Нуугдмал байх магадлалын хувь (%)
1	Хулгайлах гэмт хэрэгт	810	187	128	68.4 (%)	31,6.(%)
2	Залилах гэмт хэрэгт	810	194	115	59.2 (%)	40.8 (%)
3	Дээрэмдэх гэмт хэрэгт	810	112	79	70.5 (%)	29.5 (%)
4	Авилгын гэмт хэрэгт	810	245	103	42.0 (%)	58.0 (%)
5	Хүчиндэх гэмт хэрэгт /бэлгийн хүчирхийлэл/	810	50	34	68.0 (%)	32.0 (%)
6	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгт	810	108	71	65.7 (%)	34.3 (%)
7	Цахим гэмт хэрэгт	810	198	29	14.6 (%)	86.4 (%)
8	Мансуурах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэгт	810	199	134	67.3 (%)	32.7 (%)
Улсын хэмжээний дундаж		810	161	103	63.9(%)	26.1 (%)

3.4. Монгол Улс дахь нуугдмал гэмт явдлын түвшинг тооцсон байдал, 2018 он

Хүснэгт 4-т үндэслэн Монгол Улс дахь нуугдмал гэмт хэргийн түвшинг 2018 оны байдлаар тооцож хүснэгт 6-д үзүүлэв. Нуугдмал гэмт хэргийн түвшингээр хамгийн өндөр үзүүлэлттэй аймагт Булган 0,5, Баянхонгор, Орхон, Хөвсгөл, Дархан-Уул, Дорноговь, Дундговь аймаг, Улаанбаатар хот 0,4–өөс дээш үзүүлэлттэй байгаа бол Хэнтий, Дорнод, Дундговь аймгууд 0,2 гэсэн үзүүлэлттэй байна.

Хүснэгт 6. Нуугдмал гэмт хэргийн түвшинг аймаг, нийслэлээр тооцсон байдал

№	Нийслэл, дүүрэг, Аймаг	Бүртгэгдсэн гэмт хэрэг /2018 он/	Нийт үйлдэгдсэн байж болох гэмт хэргийн тоо /2018/	Нуугдмал байх магадлалтай тоо	Бүртгэгдсэнээс хэд дахин их
1	Улсын дүн	36,220	49,259	13039.2	0.36
2	Баян-Өлгий	318	424	106	0.33
3	Говь-Алтай	203	295	92	0.45
4	Завхан	235	372	137	0.58
5	Увс	332	498	166	0.5
6	Ховд	363	558	195	0.53
7	Архангай	519	707	188	0.36
8	Баянхонгор	581	813	232	0.4
9	Булган	344	516	172	0.5
10	Орхон	794	1,134	339	0.4
11	Өвөрхангай	670	871	201	0.3
12	Хөвсгөл	787	1,144	357	0.4
13	Говьсүмбэр	176	235	58	0.3
14	Дархан-Уул	818	1,168	350	0.4
15	Дорноговь	517	724	206	0.4
16	Дундговь	266	325	59	0.2
17	Өмнөговь	429	572	142	0.3
18	Сэлэнгэ	779	1,057	278	0.35
19	Төв	779	974	194	0.25
20	Дорнод	602	766	163	0.27
21	Сүхбаатар	366	488	121	0.33
22	Хэнтий	626	796	170	0.27
23	Улаанбаатар	25,652	36,503	10850	0.42

Дээрх судалгаанаас дүгнэхэд нуугдмал гэмт хэргийн түвшин хүн амын төвлөрөл ихтэй, гэмт хэргийн гаралт харьцангуй ихтэй бүс нутгуудад өндөр үзүүлэлттэй байна. Харин тодорхой төрлийн гэмт хэргийн нуугдмал байдлыг улсын хэмжээнд тооцоолж үзвэл Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодистой холбоотой хэрэг 0,86, Хүний эрүүл мэндэд хохирол учруулах гэмт хэрэг 0,58, Залилах гэмт хэрэг 0,40 гэсэн үзүүлэлттэй байгаа нь хамгийн өндөр үзүүлэлт юм. /Хүснэгт 7./

Хүснэгт 7. Зарим төрлийн гэмт хэргийн нуугдмал байх магадлалыг тооцоолсон байдал, 2018

№	Гэмт хэргийн төрөл, зүйл анги	Бүртгэгдсэн гэмт хэрэг /2018 он/	Нийт үйлдэгдсэн байж болох гэмт хэргийн тоо	Нуугдмал байх магадлалтай тоо	Бүртгэгдсэн-ээс хэд дахин их
1	Хулгайлах /ЭХТА 17.1, 17.12/	13424	17665	4241	0.31
2	Залилах /ЭХТА-ийн 17.3/	5372	7563	2191	0.40
3	Дээрэмдэх /ЭХТА-ийн 17.2/	1497	1938	441	0.29
4	Хүний эрүүл мэндэд хохирол учруулах гэмт хэрэг /ЭХТА-ийн 10.1, 11.1, 11.5, 11.6 дүгээр/	9326	14735	5409	0.58
5	Авилгын гэмт хэрэг /ЭХТА-ийн 22.1 22.4, 22.5/	1138	1502	364	0.32
6	Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг /ЭХТА-ийн 26 дугаар бүлэг/	42	56	14	0.34
7	Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодистой холбоотой хэрэг /ЭХТА-ийн 20.7, 20.8/	197	367	170	0.86
8	Хүчиндэх, бэлгийн мөлжлөг /ЭХТА-ийн 12.1, 12.2, 12.3/	621	824	203	0.32

4. ДҮГНЭЛТ

1. Нуугдмал гэмт хэргийн түвшин өндөр байх тусам, иргэдийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж, нийгмийн дэг журам алдагдаж, иргэд гэмт хэргээс түгших хандлага нэмэгдэж, олон нийт төрд ялангуяа шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагад итгэх хандлага сулардаг.
2. Нуугдмал гэмт хэргийн түвшинг тодорхойлох зорилгоор 810 иргэнээс авсан судалгааны дүнгээс үзэхэд улсын хэмжээнд нуугдмал байх гэмт хэргийн тоо 13039 гэсэн үзүүлэлт гарч байгаа нь өнөөгийн гэмт хэргийн түвшингээс 0.36 дахин их байгааг илтгэж байгаа ба энэ үзүүлэлт өмнөх жилтэй харьцуулахад буурсан үзүүлэлттэй байгаа нь эерэг үр дүн юм. Монгол Улс дахь гэмт хэргийн нуугдмал байх шинжийг харгалзан гэмт хэрэгтэй тэмцэх, хууль сахиулах байгууллагын бүтэц, зохион байгуулалт, орон тооны асуудлыг шинэчлэн тогтоох шаардлагатай.
3. Тодорхой төрлийн гэмт хэргийн дотроос мансуурах эм сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэг 0.8 дахин, хүний эрүүл мэндэд хохирол учруулах гэмт хэрэг 0,5 дахин их, залилах гэмт хэрэг 0,4 дахин байгаа нь анхаарал татаж байгаа боловч өмнөх жилтэй харьцуулахад буурсан үзүүлэлттэй байна.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

Нэг. Хууль тогтоомж

1. Эрүүгийн хууль. 2002.
2. Эрүүгийн хууль. 2015.
3. Зөрчлийн тухай хууль. 2017.
4. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль. 2017.
5. Прокурорын тухай. 2017.

Хоёр. Тайлан, эмхэтгэл

1. Монгол Улсад бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал. 2017.
2. Монгол Улсад бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал 2018.
3. Монгол Улсын шүүхийн тайлан. 2017.
4. Монгол Улсын шүүхийн тайлан. 2018.

Гурав. Тоон мэдээлэл

1. Цагдаагийн ерөнхий газар. Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны мэдээлэл.
2. Улсын ерөнхий прокурорын газар. Бүртгэл, мэдээлэл технологийн албаны мэдээлэл.
3. Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн. Шинжилгээний бүртгэл, мэдээллийн хэлтсийн мэдээлэл.
4. Шүүхийн ерөнхий зөвлөл. Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгийн мэдээлэл.
5. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар. Нэгдсэн тоо бүртгэлийн хэлтсийн мэдээлэл.
6. Гэмт хэрэг, шүүн таслах ажиллагааны статистикийн үзүүлэлт тооцох аргачлал. 2018.
7. НҮБ-ын Гэмт хэргийн чиг хандлагын судалгааны мэдээлэл цуглуулалт. 2015-2017.
8. Ажиллах хүчний судалгаа. 2017.
9. Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа. 2018.
10. Жендэрт суурилсан хүчирхийллийн судалгаа. 2018.
11. Шүүхийн ерөнхий зөвлөлийн Шүүхийн таслан сэргийлэх арга хэмжээний тайлан. 2018.
12. Ардчилсан засаглал судалгаа. 2018.
13. Цагдаагийн ерөнхий газрын хохирогчийн мэдээ. 2018.
14. Үндэсний статистикийн хорооны хүн амын мэдээ. 2018.
15. ЦЕГ-ын Тээврийн цагдаагийн албаны Зам тээврийн ослын шалтгаантай нас баралтын мэдээлэл. 2018.

Дөрөв. НҮБ-ын арга зүй, ангилал, гарын авлага, зөвлөмж

1. “Гэмт хэрэг, хууль сахиулахын статистикийн системийг боловсронгуй болгох нь” гарын авлага, НҮБ-ын Эдийн засаг, нийгмийн газар болон Статистикийн хэлтэс. 2003.
2. “Насанд хүрээгүй хүмүүсийг шүүн таслах ажиллагааны үзүүлэлтүүд” гарын авлага, НҮБ-ын Гэмт хэрэг, мансууруулах бодистой тэмцэх газар болон Хүүхдийн сан. 2006.

3. Гэмт хэргийн статистикт зориулсан олон улсын ангилал, НҮБ-ын Гэмт хэрэг, мансууруулах бодистой тэмцэх газар болон Европын эдийн засгийн комисс. 2015.
4. Хохирогчийн судалгааны гарын авлага, НҮБ-ын Гэмт хэрэг, мансууруулах бодистой тэмцэх газар болон Европын эдийн засгийн комисс. 2010.
5. Эрүүгийн эрх зүйн мэдээллийг үнэлэх арга хэрэгсэл, НҮБ-ын Гэмт хэрэг, мансууруулах бодистой тэмцэх газар болон Европын эдийн засгийн комисс. 2006.

Тав. Бусад бүтээл

1. Монгол Улс дахь Гэмт хэргийн цагаан ном 2016 он
2. Монгол Улс дахь Гэмт хэргийн цагаан ном 2017 он

Зургаа. Цахим эх сурвалж

<https://www.legalinfo.mn/>
<https://police.gov.mn/>
<http://www.prokuror.mn/>
<http://www.nifs.gov.mn/>
<http://www.judcouncil.mn/>
<http://cd.gov.mn/>
<http://odin.opendatawatch.com>
www.unodc.org
<https://sustainabledevelopment.un.org/>
<https://unstats.un.org/sdgs/metadata/>
www.1212.mn

ХАВСРАЛТ



ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНЫ СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ
/2015 оны Эрүүгийн хуулиар, зүйл ангиар/

Эрүүгийн хуулийн бүлэг, зүйл, хэсэг	Цагдаагийн байгууллага				Прокурорын байгууллага				Шүүх байгууллага				Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага														
	Бүртгэсэн гэмт хэрэг	Холбогдох		Эмэгтэй	Хэргэхүй болсон	Шүүхэд шийтгүүлсэн	Тухайн жил үүсгэх хэрг	Нийт ХБМБ явуулсан хэрэг	Тухайн жил шийдвэр үүсгэн хэрэг	Хэргэхүй болсон	Хянан шийдвэрлэсэн	Ял шийтгүүлсэн нь	Торлох ялаар шийтгүүлсэн хүн	Нийтэд тусгай ажлаар шийтгүүлсэн хүн	Хүмүүжлийн нийгэмд албадлагын арга хэмжээг хэрэглэсэн	Хорвоогчид хийгээд үйлдсэн	Эмэгтэй	Насаар хурааргүй хүн	Хорвоогчид тоо	Анх удаа шийтгэгдсэн	Хорих ялын хугацаа						
		0-1 жил	1-10 жил																		11-19 жил	20 ба түүнээс ш					
Бүд	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21	22	23	24	25	26	27
Бүд	36220	16389	2218	956	68598	51625	542	12880	15658	2550	766	12,363	108	55	12,088	7,419	1,683	126	2,995	187	295	3,522	1,908	566	1,813	966	177
10-р бүлэг	2	714	266	42	5	4573	3977	12	289	333	68	5	222	3	192	2	1	1	191	24	4	1253	23	35	360	441	162
10.1	3	192	201	22	1	374	255	5	216	240	39	3	164	3	170	1			170	13	3	1223	729	417	646	160	
10.2	4	2	3	1	16	10	1	3	3	3	3	3	3	3	1	1	1	1	1	1	1	14	6	1	11	2	
10.3	5				12	6		7	5	2																	
10.4	6	459	26	7	1	4014	3597	1	14	10	3																
10.5	7	8	4	3	1	17	15	4	2	2		3		3					3	3	3	3	3	3	3		
10.6	8	53	32	9	2	151	103	5	47	74	19	2	52	18	1				17	7	1	13	10	4	9		
11-р бүлэг	9	9134	6936	761	205	14764	11813	223	7179	8061	1116	6,923	75	21	7,340	6,072	903	43	367	13	55	348	771	42	787	81	
11.1	10	295	226	20	12	653	460	9	359	363	29	5	351	2	371	128			243	11	3	264	157	24	238	2	
11.2	11	1	30	1	10	6	4	7	4	7	2	12	2	2	2	1	1		1							15	
11.3	12	31	19	2	110	69	1	38	42	8	43	43	5	5	5				5			3	2	3			
11.4	13	401	337	20	11	1052	801	24	587	660	64	23	626	14	3	564	419	114				6	8	2	4		
11.5	14	8128	6155	709	182	175	138	2	18	30	7	16	1	15	14	1											
11.6	15	68	6	5	12479	10143	180	6156	6944	1012	238	5,757	59	11	6,310	5,507	787	36	15	1	46	30	13	13	17		
11.7	16	210	168	5	519	370	10	165	162	5	2	115	1	73	3	1			71	1	1	27	10	18	9		
12-р бүлэг	17	621	392	4	26	1264	1001	18	349	465	12	314	2	5	308	7	2	2	302	1	30	554	978	112	1,079	83	
12.1	18	519	338	3	24	1105	873	16	312	411	11	31	282	2	5	291	2	2	292		30	540	378	38	192	295	15
12.2	19	12	11	2	20	16	7	7	7	7	1											10	6		9	1	
12.3	20	7	37	1	24	19	3	7	3	7	1	1			1				1	1	1	1	1	1	1		
12.4	21				5	2	3	2	3	2																	
12.5	22	83	11		128	107	2	36	50	1	31			16	7				9			3	2	2	1		
12.6	23																										
13-р бүлэг	24	115	34	10	3	281	225	5	26	51	16	2	16	17	6	2	2	2	9	4	1	7	2343	734	32		
13.1	25	10	7	2	38	26	4	9	4	4	4	3	3	5	5	2	6	5	2	2	2	6	5	5	1		
13.2	26	6	3	2	19	15	4	6	2	2	2	2	2	2	2				2	2							
13.3	27				3	3	2	2	2													1	1	1	1		
13.4	28	2	1		3	3	3																				
13.5	29	56	7	3	1	126	104	2	8	14	3	6	6	5	1	2			2								
13.6	30	14	2	2	46	40	2	8	20	6	2	4	4	4	4												
13.7	31	1	1		2	1	1																				
13.8	32	1	4		1	1	1																				
13.9	33	5			4	4																					
13.10	34	13	1		23	20	1	2																			
13.11	35	5	1		15	10	1	1	1	1	1	1	1	1	1												
13.12	36	1			11	9	1	1	1	1	1	1	1	1	1												
13.13	37	1																									

Эрүүлийн хуулийн бүлэг, зүйл, хэсэг	Цагдаагийн байгууллага				Прокурорын байгууллага				Шүүх байгууллага				Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага														
	Бүртгэгдсэн гэмт хэрэг	Холбогдох	Үүнээс		Нийт ХБМБ-г вэвүүлсэн хэрэг	Тухайн жил шийдсэн хэрэг	Хэрэгсэхгүй болгосон	Шүүхэд шийлүүлсэн	Тухайн жил дахь үүсгэлтэй хэрэг	Эмэгтэй	Насанд хүрээний хүн	Хянан шийдвэрлэсэн		Ял шийтүүлсэн хүн	Торгох ялаар шийтүүлсэн хүн	Нийтэд тусгай ажил хийлгэх ялаар шийтүүлсэн хүн	Хүмүүжилний албанд ажилладаг агаар эмчээс хэрэгсэлсэн	Хорих явдал шийтүүлсэн хүн	Эмэгтэй	Насанд хүрээний хүн	Хоригдлын тоо	Анх удаа шийтгэгдсэн	Хорих ялын хугацаа				
			Хэрэг	Хэрэгсэхгүй болсон								Цагаатгасан	0-1 жил										1-10 жил	11-19 жил	20 ба түүнээс		
БД	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21	22	23	24	25	26	27
14-р бүлэг	38	6			8	8																					
14.1	39	2			6	6																					
14.2	40																										
БД	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21	22	23	24	25	26	27
14.3	41	3			1	1																					
14.4	42																										
14.5	43																										
14.6	44																										
14.7	45	1			1	1																					
14.8	46																										
14.9	47																										
15-р бүлэг	48	33	10	5	118	70	4	9	27	16	8	1	6	5	1	1	1	1	1	1	2	2	1	1	1	1	
15.1	49	32	10	5	97	62	3	6	24	16	4	4	4	3	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	
15.2	50				11	4	1	1	3		2	1	2	2													
15.3	51				3	1					1																
15.4	52				1	1																					
15.5	53				4	1		1			1																
15.6	54	1	3		2	1		1																			
16-р бүлэг	55	21	8	3	89	72	17	13	13	5	1	7	2	2	2	1	1	1	4	2	1	4	2	1	1	1	
16.1	56	2	1		11	7		4	4	1	1	1															
16.2	57				3			2																			
16.3	58	6	1	3	11	6	3	2	2	2	4																
16.4	59				2	2			1																		
16.5	60																										
16.6	61																										
16.7	62	4			16	13		4	1	1	2			2	2												
16.8	63	8	3		14	13		2	3																		
16.9	64																										
16.10	65				12	12																					
16.11	66	1	5		20	19		2	2	1																	
17-р бүлэг	67	22468	6885	1119	41865	29936	221	3439	4852	895	444	3113	21	13	3,039	595	708	77	1,737	113	196	1160	2	1	1	1	
17.1	68	12328	3501	274	503	23428	15965	106	1745	2408	315	314	1,553	7	4	1,542	1	397	54	1,145	47	142	761	252	298	461	2
17.2	69	1497	511	28	93	2992	1938	10	325	512	39	85	301	2	2	360	1	1	9	359	15	50	248	109	58	187	3
17.3	70	5372	1625	643	43	9356	7151	67	547	794	291	20	454	7	5	394	194	88	112	34	34	77	46	12	60	5	
17.4	71	562	182	76		1196	937	16	173	260	92	2	159	2		106	34	41	1	31	15	1	17	14	1	16	
17.5	72	1160	211	58	3	2494	2076	6	262	323	102	6	254	2		272	233	39	2		1						
17.6	73	17		3	46	30	2	6	7	4	4					10	9		1		1	2	1			2	
17.7	74	80	68	5	18	175	146	6	49	85	8	20	43	2	45	27	16		2	2	1	1	1	1	1	1	
17.8	75	329	109	23	7	773	609	5	115	138	27	5	105	2	111	91	15		5	5	1	5	1	1	5	1	
17.9	76	2	1		10	7																					

Эрүүлийн хуулийн бүлэг, зүйл, хэсэг	Цагдаагийн байгууллага				Прокурорын байгууллага						Шүүх байгууллага						Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага										
	Бүртгэгдсэн гэмт хэрэг	Холбогдох	Үүнээс		Нийт ХБМБ явуулсан хэрэг	Тухайн жил шийдвэр үүссэн хэрэг	Хяналт үйлдсэн хэрэг		Хэрэг болсон	Цагаатгасан	Ял шийтүүлсэн хүн	Торгох ялаар шийтүүлсэн хүн	Нийтэд тусгай ажил хийлгэх ялаар шийтүүлсэн хүн	Хүмүүжилний чанартай албадагчдын арга хэмжээг хэрэглэсэн	Хорих ял шийтүүлсэн хүн	Эмэгтэй	Үүнээс	Хоригдлын тоо	Анх удаа шийтгэгдсэн	Хорих ялын хугацаа							
			Эмэгтэй	Хасанд хүрээгүй хүн			0-1 жил	1-10 жил												11-19 жил	20 ба түүнээс						
БД	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21	22	23	24	25	26	27
17.10	77	4			16	12			3	1																	
17.11	78	21	7		61	50		10	8			6			6	4	2										
17.12	79	1096	665	9	16	1589	1187	9	294	542	34	234	1	193	2	109	9		82	1	1	49	12	16	33		
18-р бүлэг	80	242	58	16	1	585	418	4	95	125	43	67	1	75	59	1	15	5	1	3	29	17	36				
18.1	81	1			2	2																					
18.2	82																										
18.3	83	23	1		46	37			2	1																	
18.4	84	4	3		9	7																					
18.5	85	53	46	13	147	108	1	60	61	23		56	1	71	59	1	11	4	1	1	1	1	1	1			
18.6	86	24	4		82	64	1	28	51	12	3	5		3			3	1	1	1	1	1	1	1			
18.7	87	120	4	1	1	271	181		6	9	4	3		1			1		1	1	1	1	1	1			
18.8	88																										
18.9	89																										
18.10	90																										
18.11	91																										
18.12	92	6		2	11	8	1	3	3	3		3															
18.13	93	1			4	3			1																		
18.14	94	1			3	3																					
18.15	95	1			3	1	1																				
18.16	96	4			9	6																					
18.17	97	4	1		6	6																					
18.18	98																										
19-р бүлэг	99	66	19	4	112	96	4	47	86	33	53	1	52	37	4	15	1	1	13	1	1	1	1	1	1	1	
19.1	100																										
19.2	101	2																									
19.3	102																										
19.4	103	2			2	2			3		1			1	4		1	1	4	4		4		4			
19.5	104																										
19.6	105																										
19.7	106																										
19.8	107																										
19.9	108																										
19.10	109	1	1		1	1			1																		
19.11	110																										
19.12	111	3	1		6	3	1	1	1		2			1	1		1										
19.13	112	6		1	6	5	1	5	1	1	2			1	1		1		9	7	1	8					
19.14	113	83	63	18	4	95	83	2	44	75	32	47		49	36	4	13	1									
19.15	114	1			1	1																					
19.16	115	1	1		2	2	1	1	2			1															
19.17	116																										

Эрүүлийн хуулийн бүлэг, зүйл, хэсэг	Цагдаагийн байгууллага										Прокурорын байгууллага										Шүүх байгууллага										Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага																								
	Бүртгэгдсэн гэмт хэрэг					Нийт ХБМБ явуулсан хэрэг					Тухайн жил шийдсэн хэрэг					Хянан шийдвэрлэсэн Хэрэг					Ял шийтүүлсэн нгуу					Торгох ялаар шийтүүлсэн нгуу					Нийтэд тусгай ажил хийлгэх ялаар шийтүүлсэн нгуу					Хүмүүжилний албанд ажилладаг арга хэмжээг хэрэглэсэн Хорих ял шийтүүлсэн нгуу					Хориг ялын тоо					Анх удаа шийтгэгдсэн					Хорих ялын хугацаа				
	Бүртгэгдсэн гэмт хэрэг	Холбогдох	Эмэгтэй	Насанд хүрээгүй хүн	Үүнээс	Нийт ХБМБ явуулсан хэрэг	Тухайн жил шийдсэн хэрэг	Хянан шийдвэрлэсэн болсон	Цүүхдэд шийтүүлсэн	Тухайн жил шийдсэн хэрэг	Тухайн жил шийдсэн хэрэг	Тухайн жил шийдсэн хэрэг	Хянан шийдвэрлэсэн болсон	Цагаатгасан	Ял шийтүүлсэн нгуу	Торгох ялаар шийтүүлсэн нгуу	Нийтэд тусгай ажил хийлгэх ялаар шийтүүлсэн нгуу	Хүмүүжилний албанд ажилладаг арга хэмжээг хэрэглэсэн	Хорих ял шийтүүлсэн нгуу	Эмэгтэй	Насанд хүрээгүй хүн	Үүнээс	Хориг ялын тоо	Анх удаа шийтгэгдсэн	0-1 жил	1-10 жил	11-19 жил	20 ба түүнээс																											
БД	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21	22	23	24	25	26	27																												
20-р бүлэг	117	314	329	47	23	649	480	6	224	360	49	29	189	1	158	14	4		140	16	6	80	11	1	10																														
20.1	118																																																						
20.2	119					2	1																																																
20.3	120					4	2		1																																														
20.4	121	11	10	2	29	25	4		12	15	2	4		2	2																																								
20.5	122					2	1		2	1																																													
20.6	123	1				1	1																																																
20.7	124	195	253	31	20	319	250	2	148	254	28	22	128		104				104	13	3	68	43	27	41																														
20.8	125	1	1			3	1		2	2	1			1	1				1	1																																			
20.9	126	3	2			5	5		1	1		2		2	1				1	1																																			
20.10	127	1	2	1		4	4		5	1		1		1					1																																				
20.11	128					1																																																	
20.12	129	3	3	1		6	6		1	1		1		1	1																																								
20.13	130	16				21	19		2	1																																													
20.14	131	14	8	4		24	17	1	7	9	7	9		5	5																																								
20.15	132	11	7	3		81	72		7	8	4	7		6	5	1																																							
20.16	133	58	42	4	3	157	81	3	48	68	6	7	37	1	36				33	1	3	12	4	4	8																														
21-р бүлэг	134	196	54	12	491	378	10	63	127	47	1	41	2	3	50	39	2		9	1	3	3	4	8	3																														
21.1	135	51	2			129	99	2	8	21	5	5		4	3				1																																				
21.2	136	27	21	8		103	72	5	44	73	36	1	24	1	33	31	2																																						
21.3	137	2				2	2																																																
21.4	138	13	8			31	25		3																																														
21.5	139	5	12	3		18	11		5	13	7	2		3	3																																								
БД	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21	22	23	24	25	26	27																												
21.6	140					2	1																																																
21.7	141	58				155	126	2	6	6		3	1	1	1																																								
21.8	142	1	1			1	1		1																																														
21.9	143					2	2		1																																														
21.10	144	6	8			9	7					1		1	1																																								
21.11	145	5	2			10	8		5	9		6		8	8				8			3			3																														
21.12	146	24				32	28	1		6																																													
21.13	147	3				9	4			1																																													
21.14	148	1				3	2																																																
21.15	149																																																						
21.16	150																																																						
22-р бүлэг	151	362	2	2	591	440	10	49	118	42	28	1	1	30	26	4	4	5	3	4	4	4	4	5	1																														
22.1	152	269	2	2	411	324	6	15	48	14	7			6	4				2			2	1	1	1																														
22.2	153					1	1																																																
22.3	154																																																						
22.4	155	58				124	83	1	29	39	12	15	1	13	12				1			2	2	2	2																														

